

About the New Tactis in Human Rights Project

ХҮНИЙ ЭРХИЙН ШИНЭ ТАКТИК ТӨСЛИЙН ТУХАЙ

Хүний Эрхийн Шинэ Тактик Төслийг олон улсын байгууллагууд, хүний эрхийн ажилтнуудаас бүрдсэн холимог бүлэг удирдан чиглүүлж, Эрүү Шүүлтийн Хохирогчдод Туслах Төвөөс үйл ажиллагааг нь зохицуулдаг бөгөөд олон улсын хүний эрхийн хүрээнд гарч байгаа тактикийн шинэ санаачилга, стратеги төлөвлөлтийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ажилладаг. Ингэхдээ бүтээлч санаануудыг хуваалцах, тактикийн шинэ санаачилгыг дэмжих арга хэрэгсэл, сүлжээнүүдийг хөгжүүлэх замаар дэлхий дахинаа хүний эрхийн ажилтнууд, байгууллагуудын үр ашигтай ажиллагааг дээшлүүлэхийг зорьж ажилладаг юм.

Энэхүү гарын авлага бол хүний эрхийн ажил дахь тактикийн өргөн боломж бололцоонуудыг нээн үзүүлэхийн тулд Хүний Эрхийн Шинэ Тактик Төслөөс эмхлэн гаргасан олон номуудын нэг юм. Шинэ Тактик төслийн www.newtactics.org цахим хуудаснаа судалж, танилцаж болох тактикийн мэдээллийн сан, хүмүүс хоорондоо сүлжээ тогтоон үзэл бодлоо солилцож болох хэлэлцүүлгүүд бий.

Тактикийн тэмдэглэл нь тактик хэрхэн хэрэгжсэн, ямар бэрхшээл тулгарч байсан тухай дэлгэрэнгүй өгүүлсэн хүмүүсийн туршлага, болсон явдлын талаархи нарийн нягт судалгаанууд юм.

Дэлхийн бүх бүс нутагт зохион байгуулагддаг Бүс нутгуудийн Сургалт, Хэлэлцүүлгүүдээр шинэлэг тактик хэрэглэж буй хүмүүс цуглан, бие биедээ зааж эзэмшүүлдэг. Оролцогчид хамтдаа шаргуу хөдөлмөрлөж, хэрэгжүүлэх боломжтой тактикуудын талаарх олон шинэ санаа гаргаж, бусдыг сургах шинэ чадвар, итгэл болон хүний эрхийн янз бүрийн талбарт ажилладаг шинэ хамт олон, сүлжээтэй болон буцдаг билээ.

About the Center for Victims of Torture

ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХОХИРОГЧДОД ТУСЛАХ ТӨВИЙН ТУХАЙ

Эрүү Шүүлтийн Хохирогчдод Туслах Төв (CVT) нь эрүү шүүлтийн улмаас хувь хүн, түүний гэр бүл, хамт олонд учирсан гэмтэл, шархыг эдгээх, даян дэлхийд эрүү шүүлтийг зогсоохын төлөө ажилладаг байгууллага.

1985 онд байгуулагдахдаа CVT нь АНУ-д энэ төрлийн байгууллагуудын анхных нь, дэлхийн хэмжээнд гурав дахь нь байлаа. Өнөөдөр CVT эрүү шүүлтэд өртөгсдөд цогц эмчилгээний загвар байдлаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмнэлгийн туслалцаа, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн эрүү шүүлт ба

дайны гэмт хэргийн хохирогсодтой ажиллах сурган хүмүүжүүлэгч, эмнэлгийн мэргэжилтнүүд, эрүү шүүлтийн нөлөө ба үр дүнтэй эмчилгээний талаар судалгаа хийх, эрүү шүүлтийг эцэслэн зогсоох талаар орон нутаг, улс орон, олон улсын хэмжээнд лобби хийх зэргээр ажилладаг.

Шинэ тактикуудыг бий болгогч, хүний эрхийг хамгаалахын төлөө иргэний манлайллыг сэргээн босгох ер бусын үүргийг гүйцэтгэдэг эмчилгээний төвийн хувьд CVT өөрийн хуримтлуулсан туршлагаараа Шинэ Тактик Төслийг төрүүлсэн билээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.cvt.org. вэб хуудаснаас үзнэ үү.

The Center for Victims of Torture

717 East River Road

Minneapolis, MN 55455

612 436 4800

cvt@cvt.org

www.cvt.org

Page 21

Key terms

Гол нэр томъёонууд

Энэ номонд орсон нэр томъёонуудаас зарим чухал гэсэн хэсгийг энд дурдаж байна. Эдгээр үгс нь бусад сэдвүүдэд өөр олон зүйлийг илэрхийлэхэд хэрэглэгддэг хэдий ч бид өөрсдийн зорилгын үүднээс хэрхэн тодорхойлсноо толилуулъя.

Зорилго- Үр дүнд хүрэхэд чиглэсэн эрмэлзэл ба санаа

Стратеги- Зорилгод хүргэх гол алхмууд болон арга замуудын дүр зураг.

Тактик- Стратегийг хэрэгжүүлэх зорилгоор хийгдэх тусгай үйл ажиллагаа. Тактик нь стратегийг хэрэгжүүлэх механизмын гол хөшүүрэг юм. Юуг хийх нь чухал вэ гэдэг нь стратегээр тодорхойлогддог бол тактикууд нь өөрчлөлт хийх арга ухаан нь болдог. Стратегиуд нь “юуг” гэдгийг, харин тактикууд нь “яаж” гүйцэтгэх тухайд анхаардаг гэсэн үг.

Зорилтот бүлэг- Тактикаар нөлөө үзүүлэхийг зорьж буй хүн, газар орон, юмс.

Идэвхтэй холбоотон-Тухайн үйл хэргийг идэвхтэй, ил тод дэмжиж, оролцож буй хүн ба байгууллага.

Идэвхгүй холбоотон-Тухайн үйл хэрэгт ахиц гаргахад хараахан оролцоогүй ч, зорилгыг нь дэмжиж буй хүн ба байгууллага.

The Need for New Tactics

Шинэ Тактикийн хэрэгцээ

Орчин үеийн Хүний эрхийн хөдөлгөөний хэрэгцээ

Өнгөрсөн хэдхэн арван жилд хүний эрхийн туйлын зорилгыг дэвшүүлэн гаргах, тусгай хамгаалалт бий болгох талаар орчин үеийн хүний эрхийн хөдөлгөөн маш том алхмуудыг хийгээд байна. Үүнд:

- эрүү шүүлтийг буруутган
 - эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хамгаалан
 - улс төрийн хууль ёсны үйл ажиллагаануудыг тодорхойлж
 - улс төрийн хоригдлуудыг хамгаалж, суллан
 - хүний эрхийн жишиг хэмжээг мөрдүүлж буй зэргийг жишээлэн дурдаж болно.
- Эдгээр ололтууд хэр чухал түүнд хүрэхэд хэр бэрхшээлтэй байсныг давтан өгүүлэх нь илүүц бизээ.

Хүний Эрхийн Хөдөлгөөний тактикууд

Дээр өгүүлсэн ололтуудыг авчирсан гурван тактик буйг өгүүлвэл:

1. Конвенц, гэрээний байгууллагуудыг үндэслэсэн олон улсын хэм хэмжээг тогтоосон
2. Эдгээр хэм хэмжээнүүдийг зөвшөөрч, мөрдөж буй байдлыг хянах
3. Жишиг хэмжээ зөрчигдсөн үед засгийн газрын үйл ажиллагаа, идэвхгүй байдлыг буруушаах эсвэл гутаан зарлах

Хязгаарлалт

Эдгээр тактик гайхамшигт дэвшлүүдийг авчирсан бөгөөд улам дэмжигдэж, дагаж мөрдөгдсөн хэвээр байх нь тодорхой болов. Түүний зэрэгцээ хүний эрхийн илт засрашгүй асуудлуудыг шийдвэрлэхэд эдгээр ололт хангалтгүй гэдэг нь ч бас илэрхий байна.

Хөдөлгөөнийг өргөжүүлэх нь

Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэхэд одоогийнхоос улам олон хүн, нийгмийн салбарыг оролцуулах хүний эрхийн өргөн талбар шаардлагатай нь энэхүү төслийн зөрчилтэй тал юм. Энэ нь одоо хэрэглэгдэж буй тактикуудаас илүү

ихийг хийж байж л хийгдэх төгс стратегийн аргуудыг хөгжүүлэхийг шаардаж байна.

Шинэ тактикийн алсын хараа

Хүний эрхийн төлөө өөрийгөө зориулсан ажилтнууд нь шинэлэг аргуудыг хөгжүүлж, стратегийн хувьд санамсаргүй холбоонуудыг байгуулж, найдаж байгаагүй салбаруудаас суралцсанаар дэлхий даяар энэхүү ажлыг эхлүүлээд байна.

Хүний Эрхийн Шинэ Тактик төсөл тэрхүү санаачлагчдыг хамтад нь урьж авчран ажил үйлсээр нь бусдад урам өгөхийг зорьдог. Тэдний түүх тус бүр бүгд өөрийн гэсэн урам зоригийг өгч байна. Тэдгээр нь хамтдаа хүний эрхийн төлөө цаашид хийгдэх хэрэгтэй зүйлсийн алсын хараа болдог юм.

Тактикт сэтгэлгээний ашиг тус

Энэ хэсэгт хүний эрхийн хөдөлгөөний үр өгөөжийг дээшлүүлэхэд тактикт сэтгэлгээ зайлшгүй чухал болох тухай зургаан шалтгааныг дурдаж байна.

1. Стратегийг тодорхойлоход тактикууд тусалдаг.
2. Хоорондоо адилгүй зорилтот бүлгүүдэд ялгаатай тактикууд үр дүнтэй байдаг.
3. Хоорондоо ялгаатай дэмжигч тус бүрт нь тохирсон өөр өөр тактик хэрэгтэй.
4. Тактикт уян хатан байдал нь цочирдуулж гайхшруулахын нэгэн эх сурвалж юм.
5. Тактикууд нь хүний эрхийн ажилтнууд, ажиглагчдыг дэлхий дахины үйл хэрэгт хэрхэн оролцоход сургадаг.
6. Тактик бол тухайн байгууллагын ажилд дэмжигчдийг татан оролцуулахад зориулсан сургалтын тогтолцоо юм.

1. Тактикууд шинэ боломжуудыг нээдэг

Стратегийг тодорхойлоход тактикууд тусалдаг. Хэрхэн чанд үйлдэж болох талаарх сэтгэхдээ бид биелэгдэх боломжтой зүйлсийн талаарх бодлуудаа хязгаарладаг. Ямар ч амжилтгүйгээр дахин дахин оролдсон ижил шийдэл, шинэ тактик нь хуучныгаа ялсан жишээнүүдээр хүн төрөлхтний түүх дүүрэн билээ.

Жишээ: Тактикууд стратегийг тодорхойлдог

Нигери улсын Эмэгтэйчүүдийн Хүний эрхийн төлөөх БАОБОБ (BAOBAB), Иргэний Нөөцийн Хөгжил ба Баримтжуулах төв (CIRDDOC) байгууллагууд

эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хүрээнд олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхээр тэмцэж байв. Нигери улсад эмэгтэйчүүд хүчирхийллээс болж зовж шаналж буй гэдэгт цөөхөн хүн итгэдэг юм. Энэ асуудалд хэвлэл мэдээлэл төдийгүй, засгийн газрын танхимууд, хууль сахиулах байгууллагууд ч анхаарлаа бага хандуулж байлаа. Дээрхи ТББ-ууд Венийн болон Токиогийн Шүүх зэрэг бусад шүүхүүдийн нөлөөнөөс болон дэлхий дахины анхаарлыг татсан хандлагуудаас суралцаж, ямар нэгэн шинэ зүйл хийхээр шийдэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх албан бус үндэсний шүүх байгуулжээ. CIRDDOC хүний эрхийн зөрчлийн ерөнхий сэдвүүд рүү чиглэсэн албан бус/дуураймал жижиг шүүх хурлыг Зүүн өмнөд Нигерийн Амамбра мужид туршсан байна. Олон тооны хүмүүсийн анхаарлыг маш сайн татаж, хүний эрхийн зөрчлийн ерөнхий асуудал болон тухайлан эмэгтэйчүүдийн асуудлын талаар цаашдын хэлэлцүүлгүүдийг явуулах болсон уг үйл явдал нь маш амжилттай болов. Албан бус шүүх хурлыг зохион байгуулах тактик нь боломжийн гэдэг нь харагдсан байна.

Дараа нь тэдний зохион байгуулсан Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллийн талаар Нигерийн Үндэсний Шүүх Хурал хэвлэл мэдээлэл, олон нийтийн анхаарлыг ихэд татсан юм. Шүүх хурлын дараа энэхүү асуудал нь олон нийтийн боловсролын ба дарамт шахалт үзүүлэх бусад тактикийг улам үр өгөөжтэй хэрэгжүүлэх арга замыг нээсэн олон нийтийн хөтөлбөрийн хэмжээнд хүрчээ. Энэ бол эмэгтэйчүүдийн эрхийг Нигерийн хүний эрхийн адил дэмжих, хамгаалахын төлөө удаан хугацааны тэмцлийн нэгэн чухал бөгөөд үйл явцыг хурдасгагч үйл явдал байсан юм.

2. Тактикууд зорилтот бүлгүүдэд өөрөөр нөлөөлдөг

Хоорондоо адилгүй зорилтот бүлгүүдэд өөр өөр тактикууд үр дүнтэй байдаг. Бүрэн нөлөөтэй байх боломжит зорилтот бүлгүүдээ олж, тэдэнд тактикаа тохируулахыг бид сурах ёстой. Тактикууд зорилтот бүлгүүдэд нөлөөлөхгүй бол бид шинэ, илүү үр өгөөжтэй тактикийг санаачлах ёстой.

Жишээ: Тактикууд зорилтот бүлгүүдэд өөрөөр нөлөөлдөг

Хүний Эрх, Захиргааны Шударга ёсны Комисс хэмээх Гана улсын байгууллага зарим нутгийн тахилч санваартнууд залуу охид бүсгүйчүүдийг төрөл садных нь үйлдсэн гэмт хэрэг, нүглийн төлөөсөнд боол болгон шүтээний газартаа байлгадаг.

Хууль журмыг хэрэглэн иймэрхүү зан үйлийг хориглох нь үр дүнгүй бөгөөд энэхүү ёс заншлыг зогсооход тахилч санваартнуудыг оролцуулах нь зарим тохиолдолд үр дүнд хүргэж болохыг Комисс олж тодорхойлсон аж. Комисс өөр, өөр үзэл бодолтой тахилч санваартнуудаас сонголт хийв. Тэд дарангуйлагчид, хохирогчид ба иргэдийн бусад удирдагчид, нийгмийн өргөн төлөөлөлтэй хийх шууд ярилцлагадаа уг зан үйлийн талаарх нийтийн ойлголтыг хялбаршуулах зорилгоор орон нутаг, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн удирдагчдыг байлцуулсан бөгөөд тэдэнд нийгэмд эзэлсэн байр сууриа алдалгүйгээр зан үйлийг хориглох сонголт, боломжуудыг олгосон аж.. Энэ тактикийн үр дүнд одоогоор 3,000 гаруй эмэгтэйчүүд, хүүхдүүд чөлөөлөгдөөд байна.

3. Тактикууд дэмжигчдийн тойргийг бий болгодог

Хэрэв хүний эрхийг хамгаалагчид олон түмэнд хүрэх нэг юмуу хоёр тактикийг санал болговол бид зөвхөн тэрхүү тактикуудыг мэдрэх явцуу хүрээний дэмжигчдийг л уриалах болно. Дарангуйлал бүхий нийгэмд хүмүүс олон нийтийн амьдралаас хол байдаг. Иймэрхүү нийгэмд дэмжигчдийн тойргийг бий болгохын тулд бид эрсдэл, тэсвэр тэвчээр, нийгмийн өөрчлөлтийг харах өөр үзэл бодол руу уриалсан тактикуудыг санал болгох хэрэгтэй.

Жишээ: Дэмжигчдийн тойргийг бий болгох

Нидерландын Эмнести Интернэшнл Яаралтай Үйл ажиллагаанд оролцогч гишүүдийнх нь олонхи нь 30-аас дээш насныхан буйг олж тогтоон, үйл ажиллагаанд оролцох залуучуудын тоог нэмэгдүүлэхийг хүссэн юм. Нидерландын Эмнести Интернэшнл эрүү шүүлтийн эсрэг кампанит ажилд гол төлөв залуусаас бүрдсэн шинэ дэмжигчдийн тойргийг бий болгохын тулд текстэн зурвас илгээх шинэ технологийн хүчийг ашиглажээ. Мөн залуу хүмүүс олноор цугладаг рок концерт болон бусад газар кампанит ажлаа сурталчилсан аж.

4. Тактикийн уян хатан байдал

Тактикийн уян хатан байдал бол гайхам явдлын эх үндэс юм. Бид нэг ижил тактикуудыг давтаад байвал сөрөг талынхан маань тэдгээрийг хэрхэн эсэргүүцэх, хүчийг нь барьж байхаа мэддэг болно. Санаанд оромгүй байдлыг үүсгэх нь сөрөг талынхаа тэнцвэртэй байдлыг алдагдуулдаг. Уян хатан бус байдал нь бидний төдийгүй сөрөг талын сэтгэлгээг ч давтан хуулбарлах

байдалд хүргэдэг. Уян хатан байдал бол хоёр талаасаа суралцах байдлыг хөгжүүлдэг юм.

Жишээ: Тактикийн уян хатан байдал

Otpor! Хэмээх Сербийн оюутны хөдөлгөөн Милошевичийн дэглэмийн үеийн төрийн дарангуйлалтай үр дүнтэй тэмцэхэд тактикийн уян хатан байдлыг ашигласан юм. Тэд өөрсдийн аргаа "Б төлөвлөгөө" гэж нэрлэжээ. Сербийн эрх баригчид жагсагчдыг баривчилж эхлэхээр нь Otpor! жагсагчдын хоригдож буй цагдаагийн газрын гадна хоёр дахь жагсаалыг зохион байгуулдаг аж. Энэ нь нэн ялангуяа тэмцлийн нэн чухал үед үйл ажиллагаанд оролцсон хүмүүс айдсаа даван туулах, идэвхтнүүдээ оролцоотой хэвээр байлгахад тус болдог байна. Мөн энэ нь хүчний харьцааг тэнцвэржүүлж, тэдний эсрэг дэглэмийн хүчнүүдийн нэгийг нь ч гэсэн эргүүлэхэд тусалдаг. Хүмүүс нэн ялангуяа дарангуйлагч дэглэмийг ялан дийлэх үйлсэд оролцож буй бол айж эмээлгүйгээр ярьж чадах нөхцлөө аюул осолгүйгээр нэмэгдүүлж чадах ёстой.

5.Тактикууд нь оролцоонд сургадаг.

Тактикууд нь дэлхий дахины үйл хэрэгт хэрхэн оролцохыг хүний эрхийн асуудалд оролцогчид, ажиглагчдад зааж өгдөг. Бидний үйлдлээр булчингууд хэрхэн хөдлөхөө сурч, тархинд олон нарийн хувиралт, сайжруулалтыг төлөвлөх бололцоог олгодог. Бид хөдөлгөх тусам энэ нь улам хялбар болдог билээ.

Жишээ: Дэлхийн үйл хэрэгт хэрхэн оролцохыг заах нь

Дэлхийн аль ч газарт хүмүүс өнгөрсөн ба ирээдүйгээ эргэцүүлэхээр дурсгалын газрууд руу аяндаа очигдоог. Дэлхий дахины сая сая хүмүүс наад захын дурсамжаас эхлэн албан ёсны тэмдэглэлт дурсамжийг хүртэл сэтгэл санааны эдгэрэл болоод хэрхэн урагшлан хөгжих тухайд эвлэрэл, ойлголцолыг хайн дурсамж, дурсгалын газруудад цугладаг.

Дурсамж бол хүний эрхийн чухал хэл бөгөөд талбар нь билээ. Энэ бол хүний эрхийн зөрчлүүдийн нотлох баримт чухалчлагдан бүх нийтийн шинжтэй болж байсан, тэрхүү нотлох баримтын талаар асуудлууд мэтгэлцээнд хүрч, зөрчил дахин давтагдахаас сэргийлсэн тактикууд хөгжиж ирсэн өнгөрсөн үеэ хадгалан үргэлжлүүлэх үйл явц дунд бий болсон юм. Товчхондоо эдгээр газрууд нь хүний эрхийн бат бэх соёлыг бий болгоход шийдвэрлэх үүрэг бүхий арга хэрэгслэлүүд болж болох юм.

Дурсамжийн Газруудын Олон Улсын Эвсэл бол хүний эрхийн асуудлаар хэрхэн ажиллаж болохыг иргэдэд зааж сургахад хүч болох газруудыг ашигладаг дэлхий

даяарх түүхэн газруудын сүлжээ билээ. Тухайлбал тус эвслийн гишүүн Мемориа Абиерта урьд нь эрүү шүүлтийн төв байсан газарт иргэдэд “эх орныхоо асуудлуудыг шийдвэрлэх хүсэл зоригийг төрүүлэн” зоригжуулах Дурсамжийн Музей нээхээр төлөвлөжээ.

6. Тактик бол Сургалтын тогтолцоо

Тактик бол оролцогчид болоод холбоотнуудыг байгууллагынхаа ажилд татан оролцуулах сургалтын тогтолцоо юм. Тактикуудын зарим нь богино, зарим нь урт хугацаатай байж болно. Гэвч үйлдлийн тогтолцоо болохынхоо хувьд тэдгээр нь бүгд төлөвлөлт, зохицуулалт, удирдлага, чиглэлтэй байхыг шаарддаг билээ. Тактикууд олон иргэдэд оролцоотой байж, ихийг сурч мэдэн тухайн байгууллагын болон кампанит ажилд улам дур сонирхолтой болох боломжийг бий болгож өгдөг. Тактикчилсан үе шатан дахь оролцоо нь залуу, шинэ ажилтнууд ба сайн дурынханд хамгийн сайн сургалтын хөрс болно.

Жишээ: Тактикууд сургалтын тогтолцоо болох нь

Шинэ Тактикууд төслийг үүсгэн байгуулагч Эрүү Шүүлтийн Хохирогчдод Туслах Төв (CVT) нь нийтийг хамарсан хүний эрхийн хэрцгий зөрчлийн дараа нийгмийг сэргээн босгохын тулд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх ойлголт, ур чадварыг төлөвшүүлэх орон нутгийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор дүрвэгсдийн дунд эрчимжүүлсэн сургалт, удирдан чиглүүлэх загварыг үндэслэсэн билээ. CVT нь Гвиней, Сьерра Леоны дүрвэгсдийн хуаранд Либер, Сьерра Леоноос ирсэн дүрвэгсдэд зориулан сургалтын загварыг бий болгосон юм. Гол арга барил нь эрчимтэй, гардан хийх сургалт ба дүрвэгсэд өөрсдөө тасралтгүй удирдан чиглүүлэх загварыг ашигладагт оршино. “Сэтгэл санааны эрүүл мэндийн мэргэжилтнүүд” болсон тэдгээр дүрвэгсэд өөрсдийн чадавхийг бий болгож, сэтгэл санааны гүн шархтай хувь хүмүүст зориулсан ганцаарчилсан болон бүлгийн эмчилгээ хийж, өөрсдийн нэгэн адил дүрвэгсдийг сэргээн босгоход ур чадвараа ашиглан сургалтын тогтолцоонд дэмжлэг болж байна. Олон янзын үйлчилгээг өргөн хүрээнд хүлээн авч буй нас насны мянга мянган дүрвэгсэдтэй ажиллах энэхүү тасралтгүй сургалт, удирдан чиглүүлэх загвар ажиллагаанд одоогоор 122 “сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд” хамрагдаад байна.

Тактикийн Шинэ Санаачлагын Хэрэгцээ

Дэлхий дахинаа хүний эрхийг амжилттай хэрэгжүүлэхэд тактикийн шинэ санаачлага маш чухал. Бид өөрсдийн сэтгэлгээг тактиктайгаар болон

стратегитайгаар өргөжүүлснээр хүний эрхийн төлөө тэмцэгчид улам үр дүнтэй байх боломжтой болно. Дүгнэж үзвэл:

- Явцуу тактикууд нь тухай хүрээний дэмжигчдийг бий болгодог бол өргөн хүрээний тактикууд нь дэмжигчдийг уриалж, дэмжигчдийн тойргийг өргөн хүрээнд бий болгодог.
- Ямарваа ганц тактикт хэт найдах нь буруу нөхцөл байдалд хэрэгжих, стратегийн зорилтот бүлгүүдээ өргөжүүлэх боломжийг алдахад хүргэдэг. Тактикийн хувьд уян хатан сэтгэх нь стратегийн зорилтот бүлгүүдээ улам боловсронгуй болгох боломжийг бий болгодог юм.
- Дахин хэрэглэгдэж буй тактик нь цэгцтэй хариу үйлдэл хийх, өөрсдийн байр суурийг хамгаалан хялбар аргаар эсэргүүцэхэд нь сөрөг талыг зоригжуулдаг. Тактикийн уян хатан байдал нь цочир гайхлыг төрүүлж байдаг.

Physical protection-Бие хамгаалалт

Bodyguards for Human rights

Хүний эрхийн бие хамгаалагчид: Аюулд өртсөн хүний эрхийн зүтгэлтнүүдийг олон улсын сайн дурын ажилтнуудын оролцоотойгоор хамгаалж, зоригжуулах

Олон Улсын Энх тайвны Бригад-Peace Brigades International (PBI) нь засгийн газрын болон цэрэгжсэн байгууллагуудын занал сүрдүүлэлтэд өртөөд буй хүний эрхийн зүтгэлтнүүдийг дагалдан ажиллуулахаар олон улсын ажиглагчдыг илгээдэг. Зөрчил илэрвэл ажиглагчид нь тухайн орны эрх баригчид болон өөрийн улсын засгийн газар, дэлхий дахины хүний эрхийн зүтгэлтнүүдийг сэрэмжлүүлдэг юм. Олон улсын зүгээс хариуцлага хүлээхээ мэдсэнээр зөрчил үйлдэгчид өөрсдийн төлөвлөсөн дайралтаа больдог. Энэ үед зүтгэлтнүүд хүний эрхийн төлөөх өөрсдийн ажлаа идэвхжүүлэн үргэлжлүүлж, өргөжүүлнэ. PBI бол дагалдан ажиллуулах санааг институтжүүлэхийг зорьсон анхны байгууллагын нэг бөгөөд 1980-аад оны эхээр Гватемалд уг санааг хэрэгжүүлж эхэлсэн билээ. PBI нь одоогоор Колумби, Индонези, Мексик болон Гватемалд 80 гаруй сайн дурын ажилтнаа үргэлжлүүлэн ажиллуулж байна.

Тэдгээр сайн дурынхан энэхүү тактикийн хувьд хамгийн бодит харагдах тал нь хэдий ч тактикийн амжилт нь дэлхий даяарх бусад хүний эрхийн ажилтнуудын үйл ажиллагаанаас хамаардаг юм. Сайн дурын ажилтан нь дайралт, айлган сүрдүүлэлт тохиолдолдоход нэн даруй олон улсын анхаарлыг татах чадвартай байх ёстой. Үүнийг тулд PBI нь тухайн сайн дурын ажилтны нутаг нэгт хүний эрхийн зүтгэлтнүүдийн сүлжээтэй хамтран ажилладаг. Мөн сайн дурын ажилтнууд өөрийн ажилдаа гэр бүл, найз нөхдөө татан оролцуулж, сүлжээ болон ажилладаг ба хүний эрхийн зүтгэлтний арвин туршлагадаа тулгуурлах, өмнөх холбоо хэлхээгээ ашиглах зэргээр ажилладаг байна.

Аюултай байнга тулгарч, хувь хүний хувьд өөрсдийн амьдралаа албадлага, дарамтын дор өнгөрүүлэх тул олон улсын дагалдан ажиллагч байх нь аюулд өртсөн хүний эрхийн зүтгэлтэн болон сайн дурын ажилтны аль алинд нь бэрхшээлтэй билээ. Хамтран ажиллагчдын дотоод хэрэгт ямагт хутгалдахгүйгээр зөвхөн хүссэн хэмжээнд хамтрахыг PBI орон нутгийн

зүтгэлтнүүдээс хүсдэг ба тэднийг зоригжуулах, хүчирхэгжүүлэхэд маш өндөр ач холбогдол өгдөг .

Дараах цахим хуудсан дахь “Тактикийн тэмдэглэл”-ээс энэ тухай дэлгэрэнгүй уншиж болно. www.newtactics.org under Tools for Action, and see *Unarmed Bodyguards: International Accompaniment for the Protection of Human Rights*, by Liam Mahony and Luis Enrique Eguren, Kumarian Press, 1997.

Бид бүгдээрээ ёс суртахуун, улс төрийн дарамтнаас хамааралтай гэдгийн түгээмэл бодит дүр зургийг энэ тактик харуулдаг юм. Улс орнуудын удирдагчид хэвлэлээр муу хэлэгдэхийг хүсдэггүй. Доод түвшний зандалчид өөрсдийн бохир ажилдаа гэрч байлгахыг хүсдэггүй. Хэрэгтэн бүр өөрийн үйлдсэн гэмт хэргийг эзэнгүй байлгахыг зорьж, хэн ч гэрчтэй байхыг хүсдэггүй. Дарангуйлагчдын нүдэн дээр олон улсын гэрчтэй байлгаснаар, удирдагчдын зүгээс гадаад дарамт шахалт ирж, халдлага дайралт нь саардаг билээ. Ингэснээр аюулд өртсөн хүний эрхийн зүтгэлтнүүдийн эрсдэлд олон улсын анхаарлыг хандуулж, эв нэгдэл өргөжиж буйг үзүүлж, тэдний эрэлхэг үйл хэргийг нь зоригжуулж, хүчирхэгжүүлдэг юм.

Хүмүүс бие махбодын хувьд аюулд өртөх, зөрчил үйлдэгч дарангуйлагчдыг олон улсын зүгээс ганхуулах зэрэгт энэхүү дагалдан ажиллах тактик хэрэглэгддэг болоод байна. Шри Ланкийн Хүчирхийлэлгүй Энхийн хүч, Баруун эргийн Христийн Энхийг бүтээгч Баг, Гватемалын Ард Түмний Үндэсний Эв Нэгдлийн Байгууллага, Палестин ба Израйл дахь Шашны эв нэгдлийн Дагалдан ажиллах хөтөлбөр, Колумбийн Эвлэрлийн Нөхөрлөл, Мексикийн the Centro Fray Bartolome de Las Casas зэрэг бусад олон байгууллагууд уг тактикийг хэрэглэдэг юм.

Мөн бусад улсуудад ч гэсэн иймэрхүү хөдөлгөөнүүдийг ашиглаж болох талтай. Тухайлбал аливаа хурцадмал байдал, хүчирхийллийн нөхцөлд сүмийн ажилтнууд, сэтгүүлчид өөрсдийн нэр нөлөөний хүчээр ихэвчлэн хамгаалах болоод намжаах нөлөөг үзүүлж чаддаг тул тэдний оролцоотой үед дарангуйлагчид ёс зүйгүй харагдахыг хүсдэггүй. Гайти улсын Эрүү Мэндийн Хамтрагчид байгууллага нь ДОХ, сүрьеэгээр өвчилсөн иргэдтэй өдөр тутам уулзан тэдэнд эмнэлгийн ба сэтгэл санааны дэмжлэг туслалцаа үзүүлэхийн хамт ийм өвчтөнгүүдтэй холбоотой байх нь аймаар зүйл биш болохыг бусад иргэдэд харуулдаг “дагалдан ажиллагчид” хэмээх эрүүл мэндийн ажилтнуудыг ажиллуулдаг.

Дахин хэлэхэд, итгэмжлэгдсэн гуравдагч талын нэр нөлөө ба гар биеийн оролцоо нь зан төлвийг өөрчлөх ёс суртахууны болоод нийгмийн чухал үүрэгтэй билээ.

Та өөрийнхөө тэмцэлд олон улсын анхаарлыг хэрхэн хандуулж чаддаг вэ?

Mobile phones help keep elections honest:

Сонгуулийг шударга явуулахад гар утас тусална: Саналын хуудсыг хуурамчаар үйлдэхээс сэргийлж, санал хураалтын дүнг гар утсаар дамжуулах

Цаг хугацаа чухал болсон ямар ч үед үүрэн телефоны сүлжээнүүд маш ашигтай. Тухайлбал сонгуулийн санал хураалтын үеэр болон яг дараа нь саналын хайрцагийг хянах нь маш бэрхшээлтэй асуудал байдаг. Өөрийн орноо удирдаж, засгийн эрх барихад оролцох ард түмнийхээ эрхийг хамгаалахын тулд сонгуулийн хуудсыг хуурамчаар үйлдэхээс нь өмнө саналын хуудсын тоог мэдээлж, сонгуулийг шударга, үнэн зөв явуулахад үүрэн телефоны сүлжээнүүдийг Кени улсад ашиглаж иржээ.

Кенийн ерөнхийлөгчийн 2002 оны сонгуулийн үеэр бие даасан хяналтын бүлгүүд сонгуулийг шударга явуулахын тулд санал хураалтын байр бүрээс гар утас ашиглан саналын хуудасны дүнг нэн даруй мэдээлж байв.

Өмнөх сонгуулиудын үед сонгуулийн дүн гарахаас өмнө саналын хуудас тоолох, дүгнэх зэрэг гол ажлууд гар ажиллагаагаар хийгддэг байж. Хэдийгээр энэ үйл явцыг ажиглагчид хянадаг ч удаашралтай байдал нь санал луйвардах боломжийг олгох, эс бөгөөс луйвардсан гэх хардлагыг төрүүлэх нөхцөл болдог байв. Гар утсаар явагддаг шуурхай харилцаа нь (Кенийн санал хураах олон байранд газрын шугам тавигдаагүй байдаг) үр дүнг өөрчлөхөд бэрхшээлтэй тулгарч байсан аж.

Ардчиллын Боловсролын төлөөх Институт (IED), Кенийн Орон нутгийн Хөтөлбөрийн Ажиглагч (K-DOP) гэсэн хоёр байгууллагад сонгуулийн саналын хуудсыг тоолоход ажиглах итгэмжлэлийг Сонгуулийн комиссоос нь олгожээ. IED-ийн сайн дурын ажилтнууд Кенийн 210 сонгуулийн тойргийн 178-д нь өөрсдийн гар утсыг ашиглан ажилласан бөгөөд урьдчилгаандаа 2000 шиллинг (US\$26) авчээ. Тэд саналын хуудас тоологдож эхэлмэгц IED-ийн төв руу мэдээлж эхэлдэг бөгөөд тэдний хэлсэн тоо тэр даруй интернэтэд тавигддаг байв. Сайн дурынхан мөн тухайн тойрог дээрхи хүчирхийлэл, замбараагүй байдлыг мэдээлдэг байна. IED-ийн энэ үүрэг маш их үр дүнтэй гэдэг нь Кенийн сонгуулийн комиссын албан

ёсны дүн гарахаас ч өмнө харагдаж байлаа. Учир нь комисс дүнгээ гаргахдаа маш будлиантай протокол хөтөлсөн байдаг аж.

K-DOP нь мөн сайн дурынхны сүлжээг ашигладаг ч тэдэнд өгөх нөхөн төлбөрийн тухайд тогтсон жишиг байдаггүй. Кенийн сонгуулийн комиссын ажилтнууд мөн газрын шугамгүй газарт сонгуулийн дүнг төрөөс зардлыг нь хариуцдаг сансрын холбоо болон өөрийн гар утсаар мэдээлдэг.

Тэдгээр сүлжээнүүдийн шуурхай, хараат бус, мэдээллийн ил тод байдал нь сонгуулийг луйвардсан гэж хардагдаж, ялагдаж буй талын хүмүүстэй холбоотой хүчирхийлэл гарахаас сэргийлэхэд тусалдаг байна. Шуурхай илтгэснээр гол нэр дэвшигчид болон тэдний дэмжигчид сонгуулийн дүнг хууль ёсны хэмээн арга буюу хүлээн зөвшөөрөхөөс аргагүй байдалд хүргэдэг аж.

Сонгуулийн шударга байдал, өөрийн хүслээ чөлөөтэй илэрхийлэх хүний үндсэн эрхийг хамгаалсан жинхэнэ сонгууль мөн эсэхийг шалгахын тулд гар утас ашиглах явдал нэмэгдэж байна. Хэдийгээр хамгийн хурдан харилцаа холбоо байлаа ч хүнд суртлын эсрэг ямагт тийм хурдаар тэмцэж чаддаггүй. Кенийн нэгэн ажиглагчийн тэмдэглэснээр сонгуулийн ажилтнууд сонгогчдын нэрсийн жагсаалтад бичигдээгүй сонгогчдын тухай асуудлыг гар утсаараа илтгэж байхад нь зарим сонгогчид асуудлыг шийдвэрлэсэн тухай протокол хөтлөгдсөнөөс нь болон саналаа өгөлгүй буцаад явчихаж байж.

Гар утас дэлхийн бусад оронд явагдаж буй өнөөгийн сонгуулиудад ч мөн хэрэглэгдэж байна. Перугийн 2000 оны сонгуулийн үеэр Перугийн Transparencia хэмээх байгууллагын нам бус хянагчид орон даяарх санамсаргүйгээр сонгож авсан сонгуулийн тойргоос саналын тооны өөрчлөлт, саналын хуудасны тооллого, санал өгөх үйл ажиллагааны чанарын талаархи дүгнэлтүүд, хэсгийн сонгуулийн дүнг нэгдсэн мэдээллийн төвд утсаар мэдэгддэг байна. Зарим мэдээллүүд Анд, Амазонкийн алслагдсан бүсүүдээс ирдэг. Transparencia-ийн дүн шинжилгээ нь Алберто Фужиморигийн хэт давуу ялалтыг хүлээн зөвшөөрүүлэх үндэсний болон олон улсын дарамт шахалтыг бий болгоход чухал түлхэц болсон юм.

Хүний эрхийг хамгаалах үйлсийг хүчирхэгжүүлэхэд туслах, өөрийн ажлаа сайжруулахын тулд та бүхэн гар утас болон бусад дэвшилтэт технологийг хэрхэн ашиглаж болох вэ?

Protecting Rights on a Time Limit:

Цаг хугацааны хязгаарлагдмал байдалд эрхийг хамгаалах нь: Эрх нь зөрчигдөж болзошгүй хүмүүст эрхээ хамгаалах хугацаа хязгаарлагдсан болохыг мэдэгдсэн нь.

Заримдаа хувь хүмүүст эрхээ хамгаалах боломжийг нь маш бага олгосон заалтууд хуулинд орсон байх нь бий.

Канадын Онтарио хот дахь Амьдрах орон байрны Тэгш Эрхийн Төв хүмүүст эрхийнх нь тухай болон эрхээ хамгаалах үйлдэл хийх эцсийн хугацааг мэдэгдэх шуурхай хариу үйлдэл бүхий тактикийг ашигладаг.

Амьдрах орон байрны Тэгш Эрхийн Төв (CERA) нь байрнаасаа хөөгдөх эрсдэлтэй байр хөлслөгчидтэй холбоо барьж, албадан хөөгдөхөөс зайлсхийж болох арга замын талаар мэдээлэл өгдөг аж. Канадын хуулиар байр хөлслөгчдөд байрнаас нь хүчээр хөөн гаргах явдлыг үл зөвшөөрөх хугацааг тав хоногоор хязгаарладаг бөгөөд олон хүн байрнаасаа хөөгдөхөөс сэргийлэн шуурхай арга хэмжээ авах талаар мэдээлэл, эх сурвалжгүй байдаг.

Түрээсийн байрууд хоосон байсаар атал байрны эздэд зах зээлийн ханшийн дагуу түрээсээ нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн шинэ хууль Онтариод 1998 онд гарсан нь байр хөлслөгчдийг ялангуяа доод зэрэглэлийн ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийг гэр орноосоо хөөгдөхөд түлхэц болжээ. Онтариод жил бүр ойролцоогоор 60,000 хүн орон гэрээсээ хөөгдөх аюулд учирдаг байна.

Онтариогийн Түрээсийн Орон Сууцны Асуудал эрхэлсэн Шүүхэд орон гэрээсээ хүчээр хөөгдөх эрсдэлд учирсан хохирогчдын нэрсийн жагсаалт бүхий өргөдлийг CERA өргөсөн юм. Шүүх байр хөлслөгчийн өөрийнх нь хүсэлтийг чухалчлан үзэх болзолтойгоор жагсаалтыг хүлээн авчээ. Иймд CERA байрны эздээс байрнаасаа гарах шийдвэрийг хүлээн аваад буй бүх түрээслэгчдэд мэдээллийн багцийг шуудангаар хүргүүлэв. Тэгээд сайн дурын ажилтнууд нь түрээслэгчид рүү эрхээ хамгаалах таван өдөр үлдэхээс нь өмнө баталгаажуулан утасдан мэдэгджээ. Ингэхдээ байрны эздэд нь байрнаасаа хөөн гаргахаар шийдсэн тухай нь түрээслэгчдэд сайн дурынхан мэдэгдэж, боломжуудыг хэлэлцэж, холбогдох

байгууллагуудыг санал болгодог байна. Түүнчлэн тэд CERA болон бусад байгууллагууд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахын тулд эн тэргүүнд ашиглах чухал мэдээлэл болох орон байрны эрсдэлтэй байдал үүссэн шалтгаан, байрнаасаа хөөгдөхөд хүргэсэн нөхцөл байдлын тухайд нь байр хөлслөгчдөөс асууж ярилцдаг.

CERA жил бүр 25,000 орчим хүнд хүрч ажилладаг байна. Хөтөлбөр эхэлсний дараа утсаар мэдээлэл авсан хүмүүсийн байрнаасаа хөөгдөх байдал 20 гаруй хувиар буурчээ. Гэвч албадан хөөн гаргасан тоо баримтыг Иргэний Хүний Эрхийн Комиссоос нийтлэхийг хориглосонтой холбогдуулан 2003 оны гуравдугаар сараас хойш CERA Орон Гэрээс нь Албадан хөөхөөс Урьдчилан Сэргийлэх хөтөлбөрөө үргэлжлүүлэх боломжгүй болсон юм. CERA одоогоор уг шийдвэрийг эсэргүүцэн давж заалдаж буй билээ.

Орон сууцаар хангах Онтариогийн хуулиар гэр орноосоо хөөгдөн гарахыг үл зөвшөөрөх эрхийг хүмүүст олгосон байхад олонхи байр хөлслөгчид зөвшөөрөгдсөн хязгаарт хугацаанд эрхээ хамгаалах хэрэгтэйгээ мэдэхгүй байв. CERA-ийн тактик тэдэнд энэ мэдээллийг олж авч, хугацаанд нь багтаан ашиглахад нь тусалдаг юм. Харин CERA-ийн хувьд байрнаасаа хөөгдөн гарах эрсдэлд тулгарсан хүмүүсийн жагсаалтыг болон иймэрхүү мэдээллийн хомсдолоос болж эрсдэж буй бусад тохиолдлыг олж авах шаардлагатай байв. Түүнчлэн байр хөлслөгч олон хүмүүстэй утсаар холбоо барих боломжгүй, бас олон хүн өөрсдийн эрхийг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй байгаагүй гэдгийг дурдах нь зөв болно.

Шуурхай хариу үйлдэлт сүлжээ танай тэмцэлд хэрэгтэй юү? Хэрэв тийм бол ямар хэлбэрийн сүлжээ ашигтай байх бол?

Page 40

Providing Information and Skills needed to claim Rights

Эрхээ шаардахад хэрэгтэй мэдээлэл, ур чадвараар хангах: Өөрсдийн эрхэнд нь нөлөөлөх хуулийн тогтолцоог ашиглахад хүмүүсийг сургасан нь

Тодорхой эрхүүдийн талаарх үндсэн хуулийн баталгаа ихэнхдээ бодит байдал дээр хэрэгждэггүй эс бөгөөс хуулиар хамгаалагдаагүй байдаг. Санкт Петербург хотын “Цэрэг эрсийн Ээжүүд” үндсэн хуулинд заагдсан армид алба хаахгүй байж болох эрхээ эдлэх, цэргүүдийг эрүүдэн шүүсэн анги нэгтгэлүүд рүү нь буцаахгүй байхыг хэрхэн шаардах талаархи хэрэгцээт мэдээлэл, чадварыг хүмүүст хүргэдэг юм.

Санкт Петербург хотын “Цэрэг эрсийн Ээжүүд” цэрэг татлагын комиссынхон, цэргүүдийн гэр бүлийнхэнд хууль ёсны эрхийнх нь талаар зааж, үүний дүнд тэд эрхээ үр дүнтэйгээр эдлэж чаддаг байна.

Оросод бүх залуус цэргийн алба хаадаг. 1993 оны хуулиар эрүүл мэнд, амьдралын хувьд хүнд нөхцөлд (эцэг эх нь өвчтэй ба тэтгэвэрт, эсвэл өөрөө сургуульд суралцдаг) буй эрчүүдийг чөлөөлөхөөр болсон ч цэрэг татлагын комисс үүнийг байнга зөрчсөн хэвээр ажээ.

“Цэрэг эрсийн Ээжүүд” цэргийн албанаас чөлөөлөгдөх ёстой сэтгэцийн болон эрүүл мэндийн асуудалтай залуусыг хүчээр цэрэгт татаж буй тохиолдлуудыг баримтжуулжээ. Цэрэг татлагын комисс цагдаагийнхантай хамтарч гудамж, сургууль, дотуур байр, тэр бүү хэл айлуудаар явж цэргийн залуусыг цуглуулдаг .

Цэргийн алба хааж буй залуус доромжлол, амьжиргааны жишиг хэмжээнээс доогуур нөхцлийн амьдрал, шөнийн зодуур болон эрүү шүүлтэд өртдөг.

“Цэрэг эрсийн Ээжүүд”-ийн зохион байгуулдаг “Хөвгүүдээ хамгаалцгаая” сэдэвт хүний эрхийн сургалтанд оролцогсод эрхээ хамгаалдаг хуулиудыг хэрхэн ашиглах тухай заалгадаг. Мөн хууль тэднийг хамгаалдаг гэдэгт итгэх, бие биенээ дэмжиж, нэгэндээ айдаст байдлаа даван туулахад нь тусалдаг.

Сургалт долоо хоногт нэг удаа гурван цагаар үргэлжилдэг. Сургалт нь эрх баригчдад хэрхэн мэдэгдэл бичих тухай тусгай зааварчилгаа өгөх, эрх зүй, хүний эрхийн талаар хийх хэлэлцүүлэг, дүрийн тоглолт зэрэг хэсгээс бүрддэг. Мөн жил бүр зөвлөмж хэвлэн гаргадаг юм.

Ихэнхи хүмүүс энгийн эмч нараас баримт бичиг авч, цэргийн эмч нарт үзүүлж чаддаг байна. “Цэрэг эрсийн Ээжүүд” байгууллага нь өөрийн арван ажилтан, Орос болон гадаадын олон сайн дурынхны хамт судалгаанд оролцогчдоороо дамжуулан асуудлыг дүгнэж, хавтаст хэргүүдийг хүн нэг бүрээр болон дүүрэг бүрээр нь хадгалдаг аж. Армиас чөлөөлөгдөхийг хүссэн өргөдөлдөө хариу авч чадсан оролцогчдоос дараагийн бүлгийн хүмүүст туршлагаа ярьж өгөхийг хүсдэг.

12 жилийн хугацаанд 120,000 хүн эдний сургалтанд хамрагдаж, 90,000 хүн цэргийн алба хаалгүйгээр хууль ёсны эрхээ хамгаалуулжээ. Армид алба хааж байхдаа эрүүдэн шүүгдсэн 5,000 орчим хүн анги нэгтгэл рүүгээ буцаж очихгүй байх заргаа амжилттай авч чаджээ. Орос улсад цэрэгт байхдаа хүчирхийлэлд өртөж байсан болон хүчирхийллээс айж буй залуусыг хамгаалах үндсэн хуулийн хамгаалалт бий ч мэдээллийн хомсдол, хууль хяналтын тогтолцоог хэрэглэхээс эмээдэг явдал нь (үүнийг хувь хүмүүс түгээмэл хэрэглэж ирээгүй) эрхийн давуу талаа ашиглахад саад болдог аж. Иймд “Цэрэг эрсийн Ээжүүд” байгууллага тэрхүү эрхүүдийн тухай мэдээлэл, захидал бичих чадвар, хууль журмыг хэрхэн ашиглах зөвлөмж зэргээр хангадаг билээ.

Page 41

Fighting Corruption through Transparency

Ил тод байдлыг авилгатай тэмцэхэд хэрэглэх нь: Төрийн албан хаагчдын онлайн бий болгож, авилгатай тэмцэх ажлын гарааг эхлүүлсэн нь

Өмнөд Солонгосын Сөүл хотын захиргаа албан хаагчдаа Интернет сүлжээнд холбогдсон хэнтэй ч шүүмжлэлтэй мэдээллийг хуваалцах явдлыг чин сэтгэлээсээ хөхүүлэн дэмжиж байна.

Засаг захиргааны ил тод байдлыг хөгжүүлэхийн төлөө мэдээллийн сүлжээний баазыг Сөүл хотын захиргаа байгуулжээ. Иргэдийн Хүсэлтийг Онлайнаар Өргөжүүлэх (OPEN) байгууллага нь авилгалд хамгийн их өртсөн гэгддэг орон сууц, барилга байгууламжийн төсөл, хүрээлэн буй орчин, хот төлөвлөлт зэрэг хотын захиргааны ажил үүрэгтэй холбоотой 70 гаруй асуудлаар иргэдийн хүсэлтийг нарийвчлан судлах ажилд хотын оршин суугчдыг оролцуулдаг. OPEN-ыг бий болохоос өмнө, Өргөдөл гаргагчид өөрсдийн өргөдлөө ямар үйл явцаар шийдвэрлэгдэж буйг мэдэж чаддаггүй байлаа. Өргөдөлдөө нааштай хариу авахын тулд захиргааны албан хаагчдын шаардсан хахууль өгөх зэргээр авилга хөгжих боломж бүхий ил тод бус, маш бүрхэг, ойлгомжгүй үйл явцаар төрийн ажил явагддаг байжээ.

Одоо бол албан хаагчид өргөдлийг хүлээн авах, шинэчлэхдээ стандарчлагдсан бүртгэлийн маягт бөглөдөг. Хэлтэс бүр хэрэглэсэн маягтуудаа онлайн

мэдээллийн сандаа оруулж, шинэчлэдэг. Энэ мэдээллийн сангаар дамжуулан өргөдөл нь хэнд буй, хэзээ өргөдлийг шийдвэрлэх, хэрэв удааширч саатсан ба өргөдлийг шийдвэрлэхээс татгалзсан бол ямар шалтгаантай зэргийг хүсэлт гаргагч нь мэдэж болдог байна.

OPEN нь авилгатай тэмцэх бусад санаачлагуудтай холбоотойгоор байгуулагдсан юм. Үүнд хахууль авсан эсвэл шаардсан албан хаагчдад хатуу шийтгэл оноох, Авилгын Мэдээллийн Жагсаалтыг хотын Захирагчид өргөх, авилгын хэргүүдийн талаар Захирагчийн албанд сэрэмжлүүлж ярих иргэдийн шууд утас ажиллуулах, хэлтсийнхний дунд найзархаг байдал үүсэхээс сэргийлж, албан хаагчдаа сольж байх зэрэг саналууд гарч байв.

OPEN-ний цахим хуудас руу өдөрт 2.500 удаа зочин нэвтэрдэг байна. Сөүлийн Захиргааны Интернет судалгаанд дурдсанаар судалгаанд хамрагдсан иргэдийн 78.7 хувь нь тус байгууллага төрийн захиргааны авилга хээл хахуулийг бодитойгоор бууруулж буй гэдэгт итгэдэг гэжээ. Хотын захиргаа саяхнаас захиргааны 35 хороодын талаархи мэдээллийг нийтэд ил болгож эхэлсэн юм.

Энэ нь иргэд OPEN системээр дамжуулан хороодын менежментийг хянах боломжтой гэсэн үг.

OPEN нь захиргааны албадад хандсан хувийн хүсэлтүүдэд авилгаас сэргийлэн үйлчилж буй нь мөн болж буй зөрчлүүдийг таслан зогсоохоор өргөн хүрээнд хийж буй хөндлөнгийн оролцоо билээ. Энэхүү системийн амжилтын нэг хүчин зүйл нь идэвхитэй оролцоо, Захирагчийн албаны байнгын дэмжлэг юм. Төрийн хууль журмыг хэрэгжүүлэх өндөр албаны хүмүүсийн иймэрхүү дэмжлэггүйгээр OPEN-ны адил тогтолцоо хэрэгжихэд хэцүү байх байсан билээ. Авилгын эсрэг энэхүү тактикийн амжилтад мөн орон даяар түгээмэл ашиглагддаг Интернет чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

Removing opportunities for abuse

Зөрчил гарах боломжийг зайлуулах

Page 43

Workers saving their factories and saving their jobs:

Ажилчид өөрсдийн үйлдвэр, ажлаа хамгаалах нь: Өмч хөрөнгийг албадан хураах хуулийг хэрэглэн эдийн засгийн эрхээ хамгаалах

Бизнесийн үйл ажиллагаа хаагдаж, ажлын байр үгүй болоход хувь хүмүүс, айл өрх ядууралд шилжих эрсдэлд ордог.

Аргентины эдийн засгийн өнөөгийн уналтын улмаас олон бизнес хаагдаж, дампуурсан юм. Ажил олгогч нь дампуурлаа зарлах үед Аргентины ажилчид ажлаа зогсоохоос татгалзаж, ажилгүйдлээс сэргийлэхээр хичээж байна. Ойролцоогоор 200 орчим дахин сэргэсэн үйлдвэрийн ажилчид хүмүүсийн төдийлэн сайн мэддэггүй “Өмч хөрөнгийг албадан хураах тухай” хуулийг хэрэглэснээр ажлын байраа хамгаалан үлдээж чаджээ. Энэхүү хуулинд зээл олгогчид үйлдвэрийн тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлж, үйлдвэрийг шинээр хүлээн авах авах эзэмшигчийг хайх үйл ажиллагаанаас хэрхэн урьдчилан сэргийлэх тухай заасан байдаг аж. Зайрмаг, металын үйлдвэрээс эхлэн дөрвөн одтой зочид буудал, хөлөг онгоцны үйлдвэр хүртэл бүх зэрэглэлийн бизнес үүнд хамрагдсан юм.

“Эдийн засгийн гайхамшиг” гэж нэгэнтээ нэрлэгдэж байсан Аргентин 1990-ээд оны эцсээр уналтанд орж, олон Аргентинчуудыг ядуурлын зам руу хөтөлсөн билээ. Эдийн засгийн доройтлын хариуд үйлдвэрүүдийг булаан эзлэх хөдөлгөөнүүд аяндаа өрнөв. Энэ арга тэмцлийн үндсэн загвар болсон юм.

Эхлээд бизнес эрхлэгчид дампуурдаг эсвэл хаяад алга болж байв. Тэгээд ажилчид нь цалингүй байсан өнгөрсөн хугацааныхаа нөхөн төлбөрт уг бизнесийг цаашид үргэлжлүүлэн эрхлэх эрхийг шүүхийн шийдвэрээр авах олж авах хүртэл нь зээлдүүлэгчид машин техникийг нь нүүлгэн авч явахаас сэргийлж бизнесийг гартаа авч, хамтдаа удирддаг байна. Олон нийтийн ажлын байрны төслүүдийн төлөө өмч хөрөнгийг хураан авахыг орон нутгийн засаг захиргаадад зөвшөөрсөн хуулийн дагуу ийм шийдвэр гардаг байна. Үндсэн хөрөнгийг эзэмшигч этгээдэд хөрөнгийн үнэ хөлсийг байгуулагдсан цаг үеийнх нь жинхэнэ өртөгөөр төлөхийг ажилчид зөвшөөрөх ёстой бөгөөд гэхдээ зөвхөн ашигтай ажиллаж эхэлсэн үеэсээ төлж болдог байна.

Энэ тактикийн үр дүнд 10,000 гаруй ажлын байр хадгалагдаж чадсан бөгөөд дахин сэргэсэн хэд хэдэн үйлдвэрийн ажилчид өөрсдийн эзлэн авсан бизнесийн өмч хөрөнгийг өөрсдөө эзэмшиж байна.

Булаан эзлэлтээ зөвтгөхийн тулд өмч хөрөнгийг албадан хураах хуулийг хэрэглэсэн явдал нь үнэхээр аргагүй байдлын дүнд үүссэн хэдий ч бизнесийн үйл ажиллагааг хаалгахгүй гэхээсээ илүүтэйгээр ихийг хийх боломжийг бас агуулж байгаа билээ. Энэ бол эмзэг бүлгийнхэн нэмэгдэхээс сэргийлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн алхам юм. Энэ тэмцэл бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын дөрөвдүгээр зүйлд тусгагдсан хөдөлмөрлөх, амьжиргаагаа хамгаалах эрхийн илэрхийлэл юм.

Intervention tactics - ОРОЛЦООНЫ ТАКТИКУУД

Resistance tactics –эсэргүүцэх тактикууд

Page 53

With the Flick of a Switch:

Унтраалган ташуураар: Иргэд гэрээсээ ямар ч аюулгүйгээр хийж болох хялбархан үйлдэлд тулгуурлан бүх нийтийн эсэргүүцлийг илэрхийлсэн нь

Туркэд, кампанит ажилд маш олон хүний оролцсон нь хамгаалалтын арга хэмжээ болоод зогсохгүй эцсийн дүнд сая сая хүмүүс татагдан оролцох хэмжээнд хүртэл улам олон хүмүүсийг урамшуулан зоригжуулжээ.

Туркэд “Гэрлийн төлөө Харанхуйн Кампанит ажил” –д 30 сая хүн оролцож, гэрлээ асааж, унтраах байдлаар засгийн газрынхны авилга хээл хахуулийн эсрэг олон нийт эсэргүүцлээ илэрхийлжээ. Авилга “ил-нууц” байж, олон нийт ч түүнийг зогсоох хүчгүй болж, үл тоосон байдалд орсон мэт байдаг. Олонхи хүмүүс улс төрийн үйл ажиллагаанд оролцохоос эмээдэгтэй уялдан тэрхүү айдсыг дагадаг нийгмээс тусгаарлагдах сэтгэлгээг даван туулахад туслах, хувь хүний хувьд эрсдэл багатай тактик байгууллагуудад хэрэгтэй болдог.

Авилгын эсрэг хийгдэж буй ажил хангалтгүй байгаад дургүйцлээ илэрхийлж, орой бүр тогтсон цагт ердөө л гэрлээ унтраах буюу хүн бүр хийж чадах эрсдэлгүй, хялбар үйл ажиллагааг уг кампанит ажил хүмүүст санал болгожээ. Энэхүү кампанит ажил уг нь төрийн албан хаагчид ба зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүдийн хоорондох өргөн холбоог илчилсэн гутамшигт хэргийн хариуд төлөвлөгдсөн байв.

Үйл явдал болохын өмнөх сард зохион байгуулагчид нь сурталчилгааны ажлыг өргөнөөр явуулав. Тэд иргэдийн байгууллага, холбоодтой холбоо байгуулан хүлээн авсан эсэргүүцлийн кампанит ажлын уриалга, мэдээллийг найз нөхөд, бусад таньдаг хүмүүстэй явуулж чадах гишүүддээ буцаагаад факсдахыг гуйжээ. Мөн тэд олон нийтэд сануулахаар нийтлэл бичигчид, радио TV-ийн нэвтрүүлэгчдийг элсүүлсэн байна.

Зохион байгуулагчид эхэндээ иргэдэд орой бүр нэг минутын турш гэрлээ унтраахыг санал болгожээ. Харин хүмүүс гэрлээ унтраагаад зогсохгүй бас асааж, унтраан анивчуулж эхэлсэн юм. Хоёрдахь долоо хоногоос нь хүмүүс

өөрсдөө сав суулгаа нүдэх зэрэг гудамжны өөр ажиллагаануудыг санаачлан хийж эхэлсэн байна. Үйл ажиллагаагаа зогсоох хүртэл кампанит ажил бараг сар илүү хугацаагаар явагдсан байлаа.

Хэдийгээр гутамшигт хэрэгт орооцолдсон зарим хүмүүс парламентад үлдсэн ч гэсэн энэ кампанит ажлаас хойш зарим томоохон бизнесмэн, цагдаа, цэргийн албан хаагч, мафийн толгойлогчдын шүүх хурал, парламентийн доторхи авилгын эсрэг кампанит ажил, авилгын асуудалд орооцолдсон улс төрчдийн халаа сэлгээ зэрэг улс төр, эрх зүйн томоохон өөрчлөлт хийгдсэн билээ.

Хүмүүсийн оролцох үйл ажиллагаа дэндүү энгийн ямар ч бэлтгэл шаардлагагүй байсан бөгөөд өргөнөөр оролцохыг л уриалсан юм. Энэ тактик нь бусад тохиолдолд ч зохицуулан хэрэглэхэд хялбар. Үнэндээ дэлхий даяар ийм тактикийг янз бүрийн нөхцөлд хэрэглэж иржээ. Замбигийн иргэд эрх мэдэлдээ хэвээр үлдэхийн тулд үндсэн хуулиа өөрчлөх шийдвэр гаргасан Ерөнхийлөгчөө эсэргүүцэж, Баасан гариг бүрийн орой тогтсон цагт машиныхаа дохиог дуугаргацгааж байлаа. Чилид хүмүүс Пиночетийн дэглэмийг эсэргүүцэн машиныхаа дуут дохиог чангаар дуугаргаж, байрнуудынхаа цонхоор сав суулгаа нүдэн, гудамжинд жагсацгааж байсан юм. Айдаст автаж, тусгаарлагдаж, ялагдсан мэт санаа зовнил илэрхий, түгээмэл тархсан нийт ард түмнийх болохыг харуулахыг хичээснээрээ дээр өгүүлсэн кампанит ажилууд нь хоорондоо ижил шинжтэй юм.

Иймэрхүү тактикууд нь үл үзэгдэх байдлыг ил тод болгон харуулдаг сайн талтай. Тэдгээр нь ард түмэнд эв нэгдлийг бий болгох, олон иргэд хамтдаа тэмцэхийг улам эрмэлзэх улс төрийн шинэ орон зайг дахин тодорхойлох чадвараараа хэмжигдэх ёстой.

Хэдийгээр эдгээр тактик маш хялбар байж болох ч амжилтыг нь давтахад тийм ч амаргүй. Зохион байгуулагчид нь ердөө хэдхэн сарын дараа ижил төстэй асуудлыг энэ тактикаараа ижил түвшинд сэргээж чадаагүй юм. Ийм тактикийн хөдөлгөх хүч нь нэгэнт олсон амжилтаараа тухайн хөдөлгөөнийг урагшлуулах хөтөч болдог.

Ийм тактикийг та бүхэн хэзээ хэрэглэж болох вэ? Хүмүүс мэддэг ч айдас, үл тоомсорлох байдлаасаа болж эсэргүүцэн ярьж чаддаггүй явдал танай улсад бий юу?

Petition power

Өргөх бичгийн Хүч: Бичиг өргөх ажиллагааг өргөн хэмжээнд зохион байгуулах нь өөрчлөлт хийхээс аргагүй дарамт шахалтыг засгийн газарт үзүүлдэг

Аргентины нэгэн байгууллага олон нийтийг гэгээрүүлж, өөрчлөлтийн төлөө хөдөлгөхийн хамт эрх зүйн шинэтгэл хийх хэрэгтэй болсоныг парламентдаа ойлгуулахаар улсынхаа үндсэн хуулинд дахь хүмүүс төдийлэн мэддэггүй , бараг хэрэглэгддэггүй заалтыг ашигладаг байна.

2002 онд Poder Ciudadano (Иргэний Хүч) хэмээх байгууллага үндсэн хуулийн заалттай холбоотой өргөх бичигт гарын үсэг цуглуулснаар Аргентины конгресс түүнийг авч үзэх үүрэг хүлээсэн билээ. Үндсэн хуулинд зааснаар иргэдийн төлөөлөгчид ба байгууллагуудаас конгресст санал оруулж буй аливаа эрх зүйн асуудал наад зах нь Аргентины 24 бүсийн зургаад нь амьдардаг нийт иргэдийн 1.5 хувийн гарын үсгээр баталгаажсан байхыг шаарддаг ажээ.

Poder Ciudadano нь 1989 онд Аргентин дахь иргэний эрхийг хамгаалах зорилгоор нэгдсэн хэсэг хүмүүсийн санаачлагаар байгуулагдсан юм. Улс орны эдийн засгийн уналтын үед тус байгууллагын өргөх бичгүүд бүх бие давхар ядуу эмэгтэй, таваас доош насны Аргентин хүүхдүүдийг хүнсээр хангахад гол анхаарлаа хандуулахыг санаачилжээ. Эдийн засгийн уналт эхэлснээс хойш Аргентины хүн амын бараг тэн хагасаас илүү нь ядуурлын хамгийн доод түвшинд амьдарч байгаа билээ. Ядуусын ихэнхи хувийг хүүхдүүд эзэлдэг бөгөөд нийгмийн халамжийн цөөхөн хөтөлбөрүүд тэднийг өлсгөлөнгөөс аврах ажлыг хийдэг.

Өргөх бичгийн зорилго нь уг асуудлыг зөвхөн конгресст үүрэг хариуцлага болгон ноогдуулахад бус шийдэх арга замыг санал болгосонд оршиж байна. Poder Ciudadano өргөх бичиг бичээд, орон даяараа 250 сайн дурын ажилтныг элсүүлдэг. Тэдэнд тусгайлан сургалт явуулж, өргөх бичигт хэн гарын үсгээ зурах эрхтэй, гарын үсэг бүхий өргөх бичгээ хаашаа илгээх, гарын үсгээ зурж буй хүмүүст ямар мэдээлэл хэрэгтэй зэргийг тусгасан нарийн зааварчилгаа бүхий хуудсуудыг өгдөг ажээ. Сайн дурынхны олонхи нь тус байгууллагын веб сайт болон төслийн зохицуулагчаар дамжуулан элссэн байдаг. Тэд зах, номын дэлгүүр, эмийн сан, сонин борлуулах цэг, утасны бүхээг зэрэг олон нийт төвлөрсөн газруудаар явж, иргэдтэй уулзан гарын үсэг цуглуулдаг. Poder

Ciudadano нь хэд хэдэн байгууллага, хэвлэл мэдээлэлтэй хамтран ажилладаг. Үүний дотор радиогийн хамгийн нэр хүндтэй “од” гарын үсэг цуглуулах газар хаана буйг зарлан, томоохон сонинууд цугласан гарын үсгийн тоог уншигчиддаа шинэчлэн мэдээлэх зэргээр хамтардаг байна.

Энэхүү санаачлагыг Аргентины иргэд маш сайн хүлээн авч, 2002 оны эцсээр Poder Ciudadano өргөх бичгийг зарим нэгэн шинэчлэл хийх саналын хамт конгресст өргөсөн юм. Шууд гардан хийсэн энэхүү санаачлагын дүнд нэг сая гаруй гарын үсгийг цуглуулсан бөгөөд конгресс нь төрийн үүрэг хэмээн хүлээн зөвшөөрчээ. Өлсгөлөнгийн эсрэг тэмцэх хөтөлбөр нь одоогоор хэрэгжилтийнхээ эхний шатанд орж, хүнсний хангалтын анхны төвүүд нээгдээд буй.

Нийтэд түгээмэл тархсан үл хайхрах байдлыг ийнхүү Poder Ciudadano жинхэнэ өөрчлөлт болгон хувиргаж чадсан юм. Төр, иргэдийн өмнө хүлээх түүний хариуцлагад итгэл алдарсан хүмүүс өөрсдийн дуу хоолой нь хэрхэн хууль журамд нөлөө үзүүлж чадахыг тэгэхэд харсан билээ. Poder Ciudadano өргөх бичгийнхээ санааг түгээх, их хэмжээний гарын үсэг цуглуулахын тулд сайн дурынхны бат бэх сүлжээг байгуулж, байгууллагууд болон хэвлэл мэдээлийг өөрийн холбоотноо болгосон юм.

Page 59

Training victims as Human rights monitors

Хохирогчдыг хүний эрхийн зөрчлийг хянагчид болгон бэлтгэх: Хүний эрхийн зөрчилд өртөгсдийг эрхээ хамгаалах, хянахад сургасан нь.

Хүний эрхийн зөрчлийг хянахад нутгийн уугуул иргэдийг сургадаг нэгэн байгууллага Мексикт бий. Баримтжуулах ур чадвар эзэмшсэн, хуулийн хамгаалалтаар зэвсэглэсэн уугуул иргэдийн төлөөлөгчид өөрсдийн гомдол хүсэлтээ хамгийн дээд шатанд хүртэл өргөж чадахаар болжээ.

Чиапас Иргэдийг Хамгаалагчдын Сүлжээ (Red de Defensores Comunitarios por los Derechos Humanos or Red) гэх энэ байгууллага уугуул нутгийн залуухан иргэдийг өөрсдийн эрхээ хамгаалах, хянахад сургадаг.

Чиапаст цэрэг арми өргөнөөр байрлаж, Мексикийн Засгийн Газар болон Запатистачуудын хооронд цэрэгжсэн мөргөлдөөн ихэссэнээс болж хууль бус баривчилгаа, иргэдийн зэвсэгт халдлага (ялангуяа шалган нэвтрүүлэх цэгүүд

дэх), хууль бус аллага, цэргийнхэн, зэвсэгт бүлгийнхний бэлгийн хүчирхийлэлд эмэгтэйчүүд өртөх зэрэг хүний эрхийн зөрчил газар авчээ.

Хамгаалагчдын Сүлжээ байгууллага анх 1999 онд Чипасын долоон муж, овгуудыг төлөөлсөн 14 хүнийг сургажээ. 2001 онд хамгаалагчдын хоёр дахь ангийн сургалт эхлэв. Хамгаалагчдыг овгийнхон нь сонгодог бөгөөд овгийн гишүүд нь тэдний ажилд идэвхтэй оролцдог байна.

Хамгаалагчид сар тутмын сургалтаар хүний эрхийн онол, гол ойлголтуудын зэрэгцээ хүний эрхийн зөрчлүүдийг баримтжуулж, илтгэл тайланд тусгаж, сэрэмжлүүлэх ажил хийгдсэн эсэхийг хэрхэн шалгах зэрэг практик чадварт суралцаж бэлтгэгддэг. Үүгээрээ тэд эрхийн зөрчил чухам юунаас бүрддэг, дүрс бичлэгийн хэрэгсэл, гэрэл зураг, компьютераар хэрхэн баримтжуулж болохыг сурдаг аж. Мөн хариу үзүүлэх олон арга замыг мэдэж авдаг юм.

Хамгаалагчид гомдлуудыг засгийн газарт хүргэж, хэвлэлийнхэн болон хүний эрхийн байгууллагынханд мэдээлэл өгч, хууль бусаар хоригдсон хүмүүсийг суллуулах, хууль эрх зүйн хамгаалалт хайх зэргээр ажилладаг. Мөн тухайн хүний эрх зөрчигдөх аюултай нөхцөлд байвал хүмүүсийг өөр газар байрлуулах, тухайн хүн хуулийн дагуу хоригдсон эсэхээ магадлуулахаар шүүхэд хандах ажлыг зохион байгуулдаг. Хүний эрхийн зөрчил гарч болзошгүй үед хамгаалах арга хэмжээнүүдийг авахын тулд гомдлуудыг хэрхэн цэгцлэх болон зөрчил гарвал түүнийг буруушааж болох хэнд хандах вэ гэдгээ тэд мэддэг. Шүүхэд шилжиж буй, эс бөгөөс урт хугацааны хууль зүйн стратеги шаардлагатай хэргүүдийн хувьд хамгаалагчидтай хуулийн зөвлөхүүд хамтран ажилладаг.

Овгийнхныхоо хэрэгцээ шаардлагаас хамаарч хийх ажил нь олон янз. Хүний эрхийн хохирогч, гэрчүүдээс мэдүүлэг цуглуулах, зөрчлийн дүрс бичлэг, гэрэл зургийн нотлох баримтуудыг олж авах, зөрчил үйлдэгдэж байгаа тохиолдолд тохиромжтой арга хэлбэрээр хөндлөнгөөс оролцох гээд маш олон ажилтай. Түүнчлэн өөрийн ажилдаа овгийн бусад гишүүдээ ч сургадаг байна.

Энэхүү арга барил маш их амжилт авчирсан бөгөөд ТББ-ууд зэрэг гадаад хүчний оролцооноос хамааралтай байх явдлыг зогсоож, уугуул омгийн “өөртөө засах” байдал дээшилж байгаа билээ.

Хамгаалагчдын Сүлжээний загвар нь овгийн гишүүд, нутгийн удирдагчдыг хүний эрхийн тэмцлийн төвд тавьж, гадны хүмүүсийг зөвхөн зөвлөгчийн байр суурьнаас үйлчлэх хэмжээнд аваачсан юм. Өөрийн овогтоо хүний эрхийг бие

даан хамгаалах нутгийн иргэдийн сүлжээний сургалтыг аливаа газар нутагт хүний эрхийн нөлөөллийг хүчирхэгжүүлэхийг зорьж буй бүх байгууллага хийх боломжтой. Хүний эрхийг хянах, хамгаалахад хүний эрхийн зөрчлийн хохирогчдыг сургах тактик нь хүний эрхийн ухамсрыг болон уугуул иргэдийн өөрийн хамгаалалтыг дээшлүүлэхийн зэрэгцээ тэдгээр овгуудын тусгаар байдлын төлөөх үүрэг, чадавхийг нь төлөвшүүлдэг юм.

Хамгаалагчид хууль зүйн “анхны тусламж” үзүүлдэг. Энэ бол овгуудын хамгаалалтын эхний эгнээнд байхаар тэд бэлтгэгдсэн гэдгийг харуулж байгаа юм. Тэд эрхийн зөрчил гэж юу болохыг, үүнийг баримтжуулахад юу шаардлагатайг болон ажил хэргээ хэрхэн явуулахаа мэднэ. Энэ тактикийн үр дүнд өөрийн иргэдийн хууль ёсны хамгаалалтыг анхаардаг овгуудын төлөөлөгчдөөс бүрдсэн байнгын бүлэг бэлтгэгдээд байгаа бөгөөд тэд эргээд бусдыгаа сургаж байна.

Miguel Angel de los Santos,
Red de Defensores Comunitarios
por los Derechos Humanos, Mexico

Taking Young Women Out of Brothels:

Залуу бүсгүйчүүдийг биеэ үнэлэгчдийн газраас гаргаж авах: Хохирогчдыг хамгаалахад туршлага, мэдлэгтэй хүмүүсийг ашигласан нь

Бангладеш улсад хүний эрхийг зөрчдөг хувийн секторуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцдог орон нутгийн нийгэмлэг бий.

Бангладеш улсад хүчинд автан янхны газарт очсон охидыг хамгаалахын тулд урьд өмнө нь биеэ үнэлэгчид байсан хүмүүсээс бүрдсэн судалгааны багийг ашиглан ажиллагаа явуулдаг “Секс ажилчдын Екотагийн Нийгэмлэг” гэж байдаг. Эдгээр ахмад хүмүүс секс худалдаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний олонхи нь янхны газарт буй биеэ үнэлэгчдэд өрөө хөлслүүлдэг юмуу эсвэл тэднийг захирдаг эзэгтэй нар билээ. Тэд залуу биеэ үнэлэгчдийг бодвол зав зай ихтэй бас уг үйлдвэрлэлийн талаар гүнзгий мэдлэгтэй хүмүүс. Тэд янхны газар дахь өөрсдийн эдийн засгийн эрх мэдэл, байр сууриа ашиглан залуухан эмэгтэйчүүдэд өрөө хөлслүүлэхдээ насанд хүрээгүй охидыг зөвшөөрөхгүй байх зэрэг тухайн газарт хэнийг байлгахыг шийдэх онцгой боломжтой.

Хэдийгээр ийм бодлого байдаг ч залуу биеэ үнэлэгчид заримдаа янхны газарт охидыг дагуулан ирэх нь бий. Иймэрхүү тохиолдол гарахад ахмад биеэ үнэлэгчид нь охиныг байлгаж буй өрөөнд очиж, түүнтэй жижиг шагайвар, цонхоор нь харьцдаг. Тэгээд охин өөрийн хүслээр ирсэн эсэх, аль тосгоноос ирсэн, хэдэн настай, төрөл садангууд нь ямар хүмүүс байдаг зэргийг олж мэдэхийг хичээдэг. Түүнийхээ дараа охины гэр орон байдаг тосгон руу итгэлтэй хүнээр эцэг эх, төрөл төрөгсдөд нь хэл хүргүүлдэг нийгэмлэгтээ олж мэдсэн бүхнээ мэдэгддэг ажээ.

Олонхи тохиолдолд гэр бүлийнхэн нь янхны газар ирж, охиноо аварч чаддаг байна. Гэхдээ заримдаа гэр бүлийнхэн нь охиноо янхны газарт зарсан байдаг бөгөөд түүнд туслахыг ч хүсдэггүй, чаддаг ч үгүй тохиолдол гардаг.

Янхны газруудаас охидыг аварч эхэлсэн цагаасаа өөрсдийн ажлыг дэмжүүлэх, охидод туслуулахаар “Секс ажилчдын Нийгэмлэг” орон нутгийнхаа янз бүрийн

ТББ-уудтай холбоо тогтоон ажиллажээ. ТББ-ууд нь гэр орон руугаа буцаж чадахгүй охидыг сэргээн эмчлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Янхны газруудаас насанд хүрээгүй охидыг суллах секс ажилчидын хүчин зүтгэлд орон нутгийн иргэдээс маш өчүүхэн дэмжлэг үзүүлдэг нь биеэ үнэлэлт бол нийгмийн хэмжээний аюул болсныг харуулж байна.

Түүнчлэн секс ажилчид хүүхдүүдийг хамгаалах болсон нь сексийн худалдаанаас ашиг олдог хүмүүст ч тэр биеэ үнэлдэг байсан ахмад хүмүүс болон тус нийгэмлэгийг аюулд хүргэж байгаа зүйл юм. Тэдгээр секс ажилчдын болон янхны газраас насанд хүрээгүй хүүхдүүдийг чөлөөлөх хамгаалалтыг нэмэгдүүлэх талаар төрийн албан хаагчдад нөлөөлөхөд орон нутгийн ТББ-ууд дэмжлэг үзүүлнэ гэдэгт дээрхи эмэгтэйчүүд найдаж буй.

Уг асуудлыг хянах, олж илрүүлэхийн аль алинд нь ахимаг биеэ үнэлэгчид өвөрмөц байр суурьтай оролцож буй учраас энэ тактик маш их үр дүнтэй юм. Мөн тэд өөрсдийн нийгэмлэгээр дамжуулан мэдээллийг аюулгүй олж авч, дамжуулж чадах өргөн сүлжээг бий болгосон билээ. Энэ нь охид аль хэдийн янхны газарт ирсэн үед буюу зөрчлийн хамгийн эцсийн шатанд хөндлөнгөөс оролцдог тактик бөгөөд нөхцөл байдлаас бодитойгоор чөлөөлөхийг зорьдог юм. Гэр бүлийн хүчирхийлэл, албадан хөдөлмөрлүүлэх, албадан суурьшуулах зэрэг мөлжлөгийн хохирогч болсон бусад бүлгүүд ч зовж шаналж буй бусдадаа туслахад өөрсдийн туршлага, байр суурийг ашиглах боломжтой. Гэхдээ, Бангладешийн эдгээр эмэгтэйчүүд өөрсдийгөө бодит аюулд хүргэж буй гэдгийг тэмдэглэх нь чухал.

The power of the airwaves:

Агаарын долгионы хүч: Зөрчлийг зогсоож чадах эрх мэдэл бүхий хүмүүст зорьсон санаагаа хэвлэл мэдээллээр хүргэх нь

Хүний эрхийн зөрчлүүдийн талаар нийгмийн ухамсрыг дээшлүүлж, тэдгээрийг өөрчлөхөд хүчтэй нөлөөлөх нийгмийн байр сууриа сэтгүүлчид ашиглаж чадна. Бурундигийн сэтгүүлчид радио нэвтрүүлгүүдээрээ эмнэлгүүдэд үүсээд байгаа хүний эрхийн зөрчлүүдийг зогсоохыг улс орны гол удирдагчиддаа ухуулж чаджээ.

Төлбөрөө төлж чадаагүй ядуусыг эмнэлгээс гаргалгүй, хүчээр байлгаж байсан Бурундигийн эмнэлгүүдийн нөхцөл байдлыг сайжруулж чадах хувь хүмүүс, байгууллагуудад хэвлэл мэдээллийн байгууллагын хувиар нөлөөлөхөд Африкийн Олон Нийтийн Радио (APR) өөрийн хүчийг дайчилсан юм. Эцэст нь орон нутгийн ТББ-уудтай хамтран ажилласнаар APR тэдгээр хүмүүсийг суллуулахын тулд засгийн газартаа амжилттай шахалт үзүүлж чадав.

Дайнд сульдсан Бурундид олон хүн хэрэгцээт эмнэлгийн үйлчилгээндээ төлөх төлбөрийн чадваргүй байлаа. 1990-ээд онд улс төрийн тогтолцоо задран унасанаар төрөөс эрүүл мэндийн салбарыг дэмжих чадавхи буурсан нь уг асуудалд улам нэрмээс болжээ. Төсвийн хямралд орж, өр ширэнд баригдсан эмнэлгүүд төлбөрөө төлж чадаагүй өвчтөнүүдийг хорьж эхлэв. Учир нь эмнэлгүүд төлбөрөө төлж чадаагүй тэдгээр өвчтөнүүдээс болж хохирсон гэж үзэж байсан бөгөөд үүнийг хүний эрхийн асуудал талаас нь харж чадахгүй байсан юм.

Хоригдсон хүмүүс рүү нэвтрэх боломжтой болсоныхоо дараа APR тэдний итгэлийг олж, нууцаар ярилцлага авч, түүнийгээ нэвтрүүлжээ.

Нөхцөл байдлыг засаж сайжруулах эрх мэдэл бүхий тусгай байгууллага, хувь хүмүүст чиглэсэн санаануудыг нэвтрүүлгүүддээ бас тусгадаг байв. Анхны нэвтрүүлгийнхээ дараа APR нь үндэсний ба олон улсын ТББ-уудтай нэгдэн эрүүл мэндийн үйлчилгээний талаар сайтар бэлтгэгдсэн хэвлэлийн бага хурлыг төрийн албан хаагчид болон бусад нөлөө бүхий хүмүүсийг оролцуулан зохион байгуулав. Эцсийн мэтгэлцээнийг хоригдож буй хүмүүст чиглүүлэн

засгийн газар арга хэмжээ авах хэрэгтэйг харуулсан ёс суртахууны шахалт үзүүлсэн байна.

Эмнэлэгт хүмүүсийг хорихыг хориглож, бүх хоригдогсдыг чөлөөлөхийг 2002 оны дөрөвдүгээр сард Сайд нарын Зөвлөл тушаажээ. Засгийн Газар мөн эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой томоохон асуудлыг шалгах комисс байгуулж, эрүүл мэндийн үндэсний бодлогод шинэчлэл хийсэн юм.

Энэ тактикийн гол хэсэг нь ямар бүлэг, байгууллагууд эмнэлгүүдийн нөхцөл байдлыг өөрчлөх эрх мэдэлтэй бөгөөд нэвтрүүлгийн санааг нааштайгаар хүлээн авах вэ? гэдгийг тооцон нэвтрүүлгүүдийн зорилтот бүлгийг тодорхойлсон явдал байлаа. Энэ тохиолдолын хувьд үйл явдлууд олны өмнө тодорхой болсоны дараа ёс суртахууны хувьд аргагүй байдалд орох төрийн албан хаагчид зорилтот бүлэг нь байсан юм. Энэ тактик нь хүмүүст тохиолдсон үйл явдлуудыг мөн хүчтэйгээр гарган тавьж байлаа. Төрийн өндөрлөг дэх хувь хүмүүсийн гарт очсон хохирогчдын эдгээр түүхүүд үндэсний хэмжээний бодлогыг өөрчилсөн билээ.

Гэхдээ радиогийн хөтөлбөрт оролцсон өвчтөнүүдэд эмнэлгүүд цаашдаа үйлчлэхгүй гэж шийдвэл яах вэ гэж зарим нэг нь эмээж байсан бөгөөд хэрвээ ингэвэл уг тактикийг эсрэгээр эргүүлж ч болох байсан. Мөн өвчтөнүүдийн хувьд өөрсдийн өвчин зовлонг тойрсон аливаа гутамшиг бий болох вий гэх санаа зоволтыг ч авчирч болзошгүй байсан. Уг тактикийг амжилтанд хүргэхэд сэтгүүлчдээс хүний эрхийн асуудлуудад ахиц дэвшил гаргахын төлөө гар бие оролцох, ажиллах хүсэлтэй байхыг шаарддаг юм.

Хүмүүст хүний эрхийн талаар мэдээлж, өөрчлөхийг шаардсан шахалт үзүүлэхэд радиоог хэрхэн ашиглаж болох вэ?

Page 70

Enlisting local leaders to end harmful customs:

Аюултай ёс заншлуудыг халахаар нутгийн удирдагчдыг уриалах: Хүний эрхийн зөрчлийг таслан зогсооход орон нутгийн удирдагчдыг оролцуулж, тэдний нөлөөг ашигласан нь.

Хүний эрхийн зөрчлийг таслан зогсооход холбоотон дэмжигч хайвал анхны сонголт нь тухайн иргэдийн удирдагчид байдаг. Тэдний дотор омгийн ахлагч, өндөр настан, шашны удирдагч, орон нутгийн улс төрч эсвэл нөлөө бүхий хувь хүмүүс ч байж болно.

Гана улсын Хүний Эрх, Захиргааны Шударга Ёсны Комисс олны хүндэтгэл хүлээсэн удирдагчид болох захирагч, хатан эхчүүдээс эмэгтэйчүүд, залуу охидыг өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр ариун шүтээний бунханд аваачин байлгадаг Трокоси заншлын асуудалд анхаарлаа хандуулж, Комиссын тактикийг дэмжихийг хүсжээ. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нүгэл, гэмт хэрэг үйлдсэний төлөө эцэг, эх нь охидоо ариун шүтээний газарт хүргэн өгч гэр бүлээ гай барцадаас нь салгадаг заншил байдаг аж.

Комисс Трокосийн эсрэг хуулийг хүчин төгөлдөр болгох бүрэн эрх мэдэлтэй ч гүн гүнзгий сүсэг бишрэл дээр тогтдог уг уламжлалыг сайн дурын үндсэн дээр өөрчлөхгүй л бол хууль амархан замхарна гэдгийг олж харсан учраас уг тактикийг хэрэглэхэд хүрсэн байна.

Энэ кампанит ажилд бэлтгэхийн тулд тус Комисс Трокоси сүсэг бишрэлийг судалж, түүний хохирогчдод нөхөн сэргээх эмчилгээ, зөвлөгөө өгдөг Олон Улсын Хэрэгцээ хэмээх Ганын ТББ-тай холбоо тогтоожээ. Хоёр байгууллага хамтдаа хохирогчид болон шүтээний газрын тахилч нартай уулзалт хийж, үзэл бодлоо чөлөөтэй хуваалцахыг нь дэмжсэн байна.

Ингээд нутгийн удирдагчид Комисст тусалж, уг заншлыг таягдан хаяхад олон түмний дундах өөрсдийн байр сууриа ашиглан эмэгтэйчүүд, охидыг суллан явуулахыг шүтээний газрын тахилч нарт ойлгуулах хэрэгтэйг чухалчлан үзжээ. Тэдний зохион байгуулсан чөлөөлөх ёслол нь тахилчийн шийдвэрийг олонд нээлттэй харуулахын зэрэгцээ иргэдийн сүсэг бишрэлийн хэрэгцээг хангахад тусалдаг. Эдгээр ёслолын ажиллагааг хэвлэл мэдээллээр сурталчилж, нутгийн удирдагчид энэ заншилыг халахыг дэмжиж байгааг олон түмэнд өргөнөөр харуулдаг ажээ. Энэхүү тактикийн үр дүнд 3,000 орчим охид, эмэгтэйчүүд суллагдаад байна.

Дэлгэрэнгүйг www.newtactics.org цахим хуудасны “Тактикийн тэмдэглэл”-ээс уншина уу.

Хүмүүсийн суурь итгэл үнэмшил, нийгмийн байгууллыг нь хөндөхгүйгээр, эсвэл итгэл үнэмшил, байгууллага өөрчлөх сонголтыг санал болгохгүйгээр уламжлалт ёс заншлаа халахыг уриалах нь иргэдийн дэмжлэгийг авахаас илүүтэйгээр харин ч тэрхүү заншлыг нуугдмал байдалд үйлдэхэд хүргэж болно. Энэ тактик нь иргэд нь өөрсдийн удирдагчдыг хэр хүндэлдэгээс, мөн иргэддээ үлгэр жишээ үзүүлэн дагуулах тэрхүү удирдагчдын хүсэл зориг дээр

тулгуурладаг. Трокуси заншлыг халахын тулд гэм нүглээсээ салах гэж гэр бүлийн гишүүдээ тахилчдад аваачин орхих шаардлагагүй гэдгийг иргэдэд ойлгуулсан байх нь чухал. Чөлөөлөх ёслол болон овгийн удирдагчдын зүгээс өгөх баталгаанууд бол бурхдаас ирэх шийтгэлээс айх айдсыг нь намдааж, овгийн дотор итгэлцлийг бий болгоход чухал үүрэгтэй байдаг.

Эмэгтэйчүүдийн эмзэг эрхтэнийг огтлох, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг хүний эрхийг зөрчсөн зарим уламжлал, нийгэмд хатуу тогтсон заншилудыг өөрчлөх болон халахад энэ тактик ашигтай байж болох юм.

Page 73

Shareholder power

Хувь нийлүүлэгчдийн эрх мэдэл: Хувь нийлүүлэгчдийн шийдвэрээр компаниудад хүний эрхийн тодорхой бодлого, журамтай байх зэрэг илүү нийгмийн хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа явуулах талаар дарамт шахалтыг үзүүлсэн нь .

Хувь нийлүүлэгчид, хөрөнгө оруулагчид бол бизнесийн орчин дахь хүний эрхийн хамгааллыг сайжруулж чадах гол хүмүүс гэдэг нь ихэнхдээ анзаарагддаггүй.

Корпорацийн Хариуцлага дахь Харилцан Итгэлцлийн Төв (ICCR) хэмээх итгэлцэлд суурилсан зохион байгуулалттай 275 хөрөнгө оруулагчдын Хойд Америк дахь эвсэл нь корпорацуудын шударга бус, осолтой бодлого, үйл ажиллагаануудыг өөрчлөх гэсэн хувь нийлүүлэгчдийн шийдвэрүүдийг дэмжин ажилладаг. 2003 оны байдлаар Итгэлцлийн Төвийн гишүүн байгууллагуудын нийлүүлсэн өнөөгийн хөрөнгийн дүн урьдчилсан тооцоогоор бараг /\$110 billion/ 110 тэрбум ам.доллар хүрчээ.

ICCR –ын гишүүд өөрсдийн хөрөнгө оруулсан компаниуд нь нийгэм, байгаль орчинд ямар үүрэг гүйцэтгэж буйг шалгадаг. Үйл ажиллагаа нь осолтой компаниудын хувьцааг борлуулахын оронд ICCR тэдгээр компаниудыг үйл ажиллагаагаа өөрчлөхийг шаардаж, хөрөнгө санхүүг нь тэдэнд үзүүлэх дарамт шахалтын хэрэгсэл болгон ашигладаг аж.

Хувь нийлүүлэгчдийнхээ хувьд ICCR-ийн гишүүд жилийн эцсийн тайлангийн хурал дээр болдог компанийн сонгуулийн санал хураалт дээр нийгмийн асуудлын тухай шийдвэрүүдээ гаргаж тавьдаг. Нэгэн жишээ дурьдахад ICCR-т нэгдсэн есөн байгууллага Amalgamated банк болон бусад олон байгууллагатай хувь нийлүүлэгчдийн хамтын шийдвэр гаргажээ. Уг шийдвэрээр 2002 онд Unocal-ын хувь нийлүүлэгчдэд танилцуулагдсан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан Ажлын байран дахь Үндсэн Зарчим, Эрхийн Тунхаглал дээр үндэслэгдсэн компанийн шинэ бодлогыг хүлээн зөвшөөрөхийг Unocal-аас шаардсан байв. Бирм улс дахь усны хоолойн шугамын төсөлтэй холбогдох бизнесийн үйл ажиллагаа нь эргэлзээтэйн улмаас Unocal –ын нэр хүнд унаж байсан. Тиймээс Unocal-д оруулсан хөрөнгө оруулалт найдваргүй хэмээн хувь нийлүүлэгчид нь маргалдаж байлаа. Хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг дэмжих талаар хувь нийлүүлэгчийн гаргасан санал дээд амжилт тогтоож, төлөвлөсөн шийдвэр нь хамгийн олон саналыг авч, удирдах зөвлөлийн анхаарлыг татсан шилдэг менежмент болсон юм. 2003 онд Unocal компани Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Тунхаглалд нийцсэн бодлогыг баталжээ. 2004 онд ICCR-ийн гишүүд шийдвэр гаргаснаар Occidental Petroleum хүний эрхийн тодорхой бодлого батлахаар болов. ICCR нь хувь нийлүүлэгчдийн тухайн жилд гаргасан шийдвэрүүдийг агуулсан *Итгэлцлийн Шийдвэрүүдийн Ном* хэмээх жилийн тайлан илтгэлээ гаргадаг. Түүнээс менежерүүд суралцаж, харин хөрөнгө оруулагчид корпорацийн хариуцлагын талаархи чиг хандлагыг олж үзэх боломжтой.

ICCR-ийн гишүүн байгууллагууд жил бүр нийгмийн болоод байгаль орчны асуудалтай холбоотой хувь нийлүүлэгчдийн 100 гаруй шийдвэрийг танилцуулдаг. Олонхи тохиодолд эдгээр шийдвэр нь хөрөнгө оруулагчид болон компанийн гүйцэтгэх ажилтнуудын хооронд тохиролцох үүдийг нээж өгдөг юм.

Хувь нийлүүлэгчдийн шийдвэрүүд компаниудад хэрэгжихгүй бол тэд хангалттай олон хувь нийлүүлэгчдийн дэмжлэгийг авч компанийн үйл ажиллагаанд сануулга өгдөг. ICCR энэ чухал асуудалд 1971 оноос хойш өөрийн дуу хоолойгоо өргөж явна. Хамгийн гол нь энэ тактик хөрөнгө оруулалтын арга замаа өөрчилж, хүний эрхийн хөгжил дэвшилд оролцох боломжийг улам олон хүнд олгодог.

From the street to school

Гудамжнаас Сургуульд: Хүүхдүүдээ ажил хийлгэлгүй, сургуульд явуулахад нь эцэг эхүүдэд туслах сан ажиллуулах

Хүүхдийн хөдөлмөрийн үндсэн шалтгааны нэг нь ядуурал билээ. Олон гэр бүл хүүхдүүдээ сургуульд явуулахыг хүсдэг ч ядуугаасаа болж чаддаггүй. Хүүхдүүдээ боловсролтой болгох гэсэн гэр бүлүүдийг эдийн засгийн хувьд дэмжих хөтөлбөрийг Бразилд хэрэгжүүлж эхлээд байна.

Бразилийн Bolsa Escola хөтөлбөр хүүхдүүдээ хар ажил хийлгэхийн оронд сургуульд явуулж байгаа өрхүүдэд сар бүрийн тэтгэлэг өгдөг. Ажил хийж буй өнөөдрийн хүүхдүүд маргаашийн насанд хүрсэн ядуус болохыг ухаарснаар энэ хөтөлбөрийг саначилж, Бразилиа хотод үйл ажиллагаагаа эхэлжээ. Bolsa Escola хөтөлбөр 2001 онд холбооны улсын хэмжээнд хүрч өргөжсөн байна.

Bolsa Escola хөтөлбөрийг Боловсролын Газар удирддаг. Шалгуурт нийцсэн өрх сар бүрийн тэтгэлгээ шууд авах боломжтой АТМ карт (банкны цахим карт) хүлээн авдаг. Хүүхдүүд нь 6-15 настай, сард хоёроос дээш өдөр хичээл тасалдаггүй байх; өрхийн доторхи насанд хүрсэн ажилгүй хүн бүр Улсын Хөдөлмөрийн Албанд бүртгэлтэй бөгөөд ажил идэвхтэй хайж байгаа; тухайн гэр бүл сүүлийн таван жилийн турш Бразилд амьдарч байгаа гэсэн шалгууруудыг өрхүүд хангасан байх ёстой. Тэтгэлэгийг хоёроос таван жил хүртэл хугацаагаар олгодог байна. Хэрэв хүүхэд нь дурдсан шаардлагад нийцээгүй бол тухайн сарын тэтгэлэг олгогддоггүй.

Ядууралтай тэмцэх, боловсрол эзэмшихэд нь хүүхдүүдийг урамшуулахын зэрэгцээ энэ тактик нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоог мэдэгдэхүйцээр бууруулж байгаа төдийгүй мөн сургууль завсардалт багасгаж чадсан юм. Bolsa Escola өнөөдрийг хүртэл нийт 8,289,930 хүүхдийн гэр бүлд туслаад байна. Улс, үндэсний шинжтэй том хөтөлбөр болсоноороо Bolsa Escola дэлхий дахинд хамгийн өргөн түгсэн нийгмийн хөтөлбөр болж чадсан билээ. Хүүхдийн хөдөлмөрийг ашиглах нь сонголт гэхээсээ илүү хэрэгцээ болсон байсан бол харин уг тактик тэдэнд сонгох боломжийг олгосон байна. Тусламжийн АТМ карт нь бусад АТМ карттай адил харагдах төдийгүй адилхан хэрэглэгддэг тул энэ нь ядуу байдал, төрийн тусламж авч буй зэргээсээ ичиж эмээх явдалгүй

үйлчлүүлэхэд нь өрхүүдэд тусалдаг давуу талтай. Энэ арга маш их санхүүгийн нөөц сурвалж шаардах нь ойлгомжтойгоор барахгүй мөн олон янзын байгууллага, институтуудыг удирдан зохион байгуулах, зохицуулах нүсэр ажлыг шаарддаг.

Мөнгө хөрөнгөний зэрэгцээ таны дэмжигчид болон эсэргүүцэгчдийг тань сэдэлжүүлэн хөдөлгөх өөр ямар хөдөлгөх хүчнүүд байна вэ?

Page 78

Linking loans to human rights

Зээлийг хүний эрхтэй холбон олгох: Хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй байх нөхцөлтэй, хугацааны хувьд тохиромжтой зээлийг жижиг бизнес эрхлэгчдэд санал болгосон нь.

Бангладеш улсад хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүйгээр бизнес эрхлэх боломжийн хугацаатай зээлийг иргэдэд олгодог байгууллага байдаг.

Бангладешийн Хөдөөгийн Дэвшлийн Хороо (BRAC) хэмээх энэ байгууллага хүүхдийн хөдөлмөр ашиглахгүй байх нөхцлийн талаар зөвшилцлөө сахиж чадах жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан боломжийн хугацаатай зээлийн санал бүхий Жижиг Аж Ахуйд Зээл Олгон Дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Зээлийн хөтөлбөр нь сүлжмэл, хүнс, үйлчилгээний болон тээврийн салбарт ажил үйлчилгээ эрхэлж буй болон шинэ жижиг бизнес эрхлэгчдийн ажилд үнэлгээ хийдэг.

Зээлдэгчид ихэвчлэн 15 хувийн үйлчилгээний хөлстэй 300-3500 ам долларын зээл авахыг хүсдэг. Зээлийн дундаж хэмжээ нь ойролцоогоор 1000 ам доллар байдаг. Хөдөөгийн хүмүүст зээл өгөхийг хүсдэггүй, өгсөн ч их хэмжээний мөнгө буцаан төлөхийг шаарддаг банкуудыг бодоход сар бүр жигд хөрөнгө оруулалт хийдэг учраас энэхүү зээлийн хугацааг зээлдэгчид зөвшөөрдөг аж. Зээл авсан хүмүүс нэгээс хоёр жилийн дотор зээлээ буцаан төлдөг.

Мөн зээлийнхээ хугацааг баримталж буй эсэх, хүний эрх зөрчиж буй эсэхийг нь шалгаж, BRAC зээлдэгчдийнхээ үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Хүний эрх зөрчигдсөн тохиолдолд BRAC-ийн хөтөлбөрт хамрагдаж буй зээлдэгч мөн эсэхээс нь үл хамааран зээлийн ажилтнууд нэн даруй арга хэмжээ авах үүрэгтэй байдаг. 1996 онд байгуулагдсанаасаа хойш энэхүү хөтөлбөр хүүхдийн

хөдөлмөрийг ашигладаггүй Бангладешийн 45,000 гаруй зээлдэгчдэд зээл олгоод байгаа билээ.

Энэхүү хөтөлбөр орон нутгийн бизнесүүдэд шинэ хөрөнгө оруулалт хийснээрээ ажил эрхлэлтийг дээшлүүлэхийн хамт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлын талаар нийгмийн ухамсрыг төлөвшүүлж, тэдний хөдөлмөрийг ашиглах явдлыг бууруулж байна.

BRAC нь хүний эрхийг хүндэтгэх шаардлагуудаа тавьснаараа түүнийг хэрэгжүүлэх хэрэгцээ байдгийг олж харсан юм. Энэ тактиkyг хүний эрх ба санхүүгийн үйл ажиллагааны хооронд холбоотой байж болох алагчлахгүй байх, цалин хөлсийг шударгаар олгох явдлыг баталгаажуулах, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлтэй байх зэрэг бусад нөхцөл шаардлагуудад ч хэрэглэх боломжтой. BRAC-ийн зээл банкнуудынхыг бодвол эргэн төлөгдөх хугацаа нь боломжтой, хүү багатай гэдгээрээ хүмүүсийг өөртөө татдаг ажээ.

Page 80

When Businesses Lead the Way:

Бизнесүүд арга замыг удирдвал: Үйлдвэрлэлийн бүх шат дамжлагыг төвлөрүүлэх нь хүүхдийн хөдөлмөр ашиглалтыг хянах, түүнийг таслан зогсоох явдлыг хялбаршуулдаг.

Бизнесийн ертөнцөд хамгийн сайн танигдсан брэндүүдийн нэг Reebok компанийн хичээл зүтгэл, хяналт шалгалтаар уг брэнд хүний эрхийг хамгаалах үйлсэд хамрагдан хамгаалагдаж ирсэн билээ.

1996 онд Reebok компани Пакистан дахь хөл бөмбөгийн үйлдвэрлэлдээ хүүхдийн хөдөлмөр ашиглахаас урьдчилан сэргийлж үйлдвэрийн хяналт, бүтээгдэхүүний шошгожуулалт, боловсролын хөтөлбөр зэргийг санаачилсан юм. Урьдчилсан тооллогоор Пакистаны Сиалкот дахь хөл бөмбөгийн үйлдвэрүүдийнх нь ажилчдын 20 орчим хувь нь хүүхдүүд байв. Reebok-ийн тогтоосон хүний эрхийн стандарт нь тухайн орон нутагт мөрдөгдөж буй хуулиас хамаарч үйлдвэрийн ажилчдаа доод тал нь 15, түүнээс дээш насны хүмүүс байхыг шаарддаг. Хөл бөмбөгийн үйлдвэрлэлийн зах зээлд нэвтрэхдээ Reebok Сиалкотын цорын ганц дэвшилтэт технологи бүхий үйлдвэр болох өөрийн үйлдвэртээ оёж, шаглахыг оролцуулан бүх дамжлагад хүүхдийн хөдөлмөр ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авчээ. Үйлдвэр дээрээ .бүх

ажиллагаагаа хүүхдийн хөдөлмөргүйгээр гүйцэтгэдэг. Ажилчидтай уулзаж, үйлдвэр рүү орж, үйлдвэрээс гарч буй бараа бүтээгдэхүүнийг хянаж байдаг байцаагчид, тусгай хянагчид үйлдвэрийн дамжлагуудыг үе үе шалгадаг байна. Тэд мөн орон нутгийн иргэдтэй холбоотой байхыг чухалчилдаг бөгөөд Reebok-ийн бөмбөгнүүд үйлдвэрээс гадуур хийгдээгүйг баталгаажуулахаар ойр орчмын тосгодоор явдаг.

Бөмбөгнүүд нь “Баталгаа: Хүүхдийн хөдөлмөргүйгээр үйлдвэрлэгдэв” гэсэн шошготой. Энэ нь тэдний бөмбөг хэрхэн үйлдвэрлэгдсэнээс нь хамаарах сонголтыг хэрэглэгчдэд олгож, хөл бөмбөгийн үйлдвэрлэлд хүүхдийн хөдөлмөрийн тухай ойлголтыг төлөвшүүлж өгч байна. Хүүхдийн хөдөлмөргүй зорилтот үйлдвэрлэлийн үр дүнд Reebok хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүйгээр хэдэн арван мянган хөл бөмбөгийг үйлдвэрлэх чадвартай боллоо.

1997 онд Reebok компани нь “Reebok-ийн Боловсролын Дэмжлэг Пакистанд” хөтөлбөр (R.E.A.P.) боловсруулж, бөмбөг үйлдвэрлэгдэж буй бүс нутгийн боловсролын салбарт дэмжлэг болгон /US\$1 million/ нэг сая ам долларыг бөмбөгний худалдаанаас олгожээ. Мөн 1997 онд Reebok компани Сиалкотын Боловсролын Дэвшлийн Нийгэмлэгт нэгдэж, хүүхдүүдийг хөдөлмөрийн талбараас холдуулж, сургуульд суралцуулахаар нутгийн өрхүүдтэй ажилладаг Чаанаан Институтыг байгуулалцав.

Reebok хүүхдийн хөдөлмөргүйгээр хийгдсэн бүтээгдэхүүний зах зээлийг олж харсан бөгөөд түүнийг өөрийн бүтээгдхүүнээр дүүргэхээр шийдсэн юм. Олон жилийн турш энэхүү үйл явдлын хүрээнд олон нийтийн ухамсар төлөвшиж байгаа билээ. Зах зээлийг эзэлсэн, олон үндэстэн дамнасан корпорацийн хувьд Reebok өөрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлтийн бүхэл бүтэн гинжин хэлхээнд нөлөөлөх ер бусын байдалд байлаа. Тийнхүү хүний эрхийн зөрчлийг хянахад дэлхий дахины эдийн засаг дахь түүхий эд, хэрэглэгчийн хоорондох шат дамжлагыг нэмэгдүүлсэн нь энэ тактикийн чухал тал юм. Reebok бүтээгдхүүнүүд нь хүүхдийн хөдөлмөргүйгээр хийгдэж буй эсэхийг шалгахын тулд тэдгээр шат дамжлагыг нэгтгэх хэрэгтэйг олж харжээ.

Шошгожуулах энэ тактик нь ажилчид нь шударгаар цалин хөлс авдаг байх, бүтээгдхүүнээ байгаль орчинд хор учруулахгүйгээр үйлдвэрлэсэн буюу тарьж ургуулсан байх зэрэг бусад “шударга хөдөлмөр”-ийн эд барааны зах зээлийг бий болгоход хэрэглэгдэж болох юм.

Таны тэмцэлд санамсаргүй холбоотон болохуйц бизнесүүд байна уу?

Restorative tactics- Засах тактикууд

Remembering abuses-Хүний эрхийн зөрчлийг дурсан санах нь

Page 87

Answers for victims' families

Хохирогчдын гэр бүлийнхэнд өгөх хариултууд: Шударга ёсыг дэмжих зорилгоор хүний эрхийн зөрчлийн бүртгэлүүдийг баримтжуулах нь.

Улаан Кхемерийнхны үед үйлдэгдсэн зөрчлүүдийг баримтжуулж буй Камбожийн нэгэн байгууллага үй олноор хоморголон устгасан гэмт хэрэг амьдралд нь нөлөөлсөн болон түүнийг үйлдсэн хүмүүсийн аль алиных нь дурсамжийг хөндөлгүйгээр олон нийтэд хүргэж болох тайлангуудыг бэлтгэжээ.

Камбожийн Баримтжуулах Төв (DC-Cam) нь Камбожид болсон хоморголон устгалтын талаарх нотлох баримтуудыг цуглуулдаг бөгөөд энэ нь сураггүй алга бологсдын үхлийн тухай гэр бүл, найз нөхөд нь дэлгэрэнгүй мэдэж авахад тусалдаг байна. Түүний хамт DC-Cam хууль, шүүхийн өмнө Улаан Кхемерийн удирдагчдын эсрэг хэрэглэх хууль ёсны нотлох баримтуудыг цуглуулдаг.

DC-Cam-ийн Гэр бүлийн Ялган таних Хэргийн Тогтолцоо нь хохирогчдын болон дарангуйлагчдын аль алины гэр бүлийнхэнд Улаан Кхемерийн дэглэмийнхний (1975–1979) үед хадгалагдсан дэлгэрэнгүй бүртгэлүүдийг судлан өөрсдийн хайртай хүмүүсийнхээ үхлийг олж илрүүлэхэд тусалдаг. DC-Cam нь холбогдох баримт бичиг, гэрэл зураг, ярилцлагуудаас бүрдсэн хэдэн зуун мянган хуудастай каталоги бүхий дөрвөн том мэдээллийн сантай. Тэдний зураглалын төсөл нь Камбожийн 170 дүүрэг болон тус орны бараг бүх муж даяар буй үй олноор булшилсан 19,466 булш, 168 шорон, аймшигт аллагын 77 дурсгалыг олж тодруулахаар GPS технологийг ашиглаж байгаа билээ.

Төрөл төрөгсөд нь Улаан Кхемерчүүдэд хороогдсоныг ихэнхи олдворууд гэрчилдэг ч ар гэрийнхэн нь яг юу болсоныг мэдэж байж хэргийг хаалгах хүсэлтэй байдаг ба хоморголон устгалтын эмгэг, дарамтаас чөлөөлж эдгээх ажлыг тус байгууллага хийж эхэлдэг юм.

Бүртгэлүүд хааяа сураггүй алга бологсдын шарил хаана байгааг илрүүлж өгдөг бөгөөд гэр бүлийнхэн нь тэднийхээ сүнснийг замд нь үдэх ёслолыг үйлдэх боломжтой болдог байна. Камбожийн айл өрхүүдийн бараг 80 хувь нь хайртай хүмүүс нь хэрхсэн тухай хариу авахаар лавлах төвд иржээ.

DC-Cam-ийн эцсийн зорилго бол Камбожийн ард түмэнд шударга ёсыг эрж хайх, бат бэх ирээдүйг байгуулахад нь тусалж, иймэрхүү аллага дахин давтагдахаас сэргийлэхийн тулд үй олноор хоморголон устгасан аймшигт хэргийн дурсамжийг мартуулахгүй байх юм.

Ард түмэн нь аймшигт зовлон, хүний эрхийн зөрчлийг удаан хугацааны турш туулж ирсэн Камбожид DC-Cam-ийн энэ тактик маш үр дүнтэй хэрэгжижээ. Тэдний туршлага удаан хугацаагаар хүний эрхийн зөрчилд буй бусад орнуудад тус болох талтай. Мэдээллийн төв санг байгуулахын тулд дарангуйлагчид хэрхэн дарангуйлж байсныг, мөн тэдний үлдээсэн аливаа бичиг баримт, нотлох баримт гээд юуг ч байсан олж, цогцсуудыг таних болон шүүх ажиллагаа явуулах ёстой. Камбожид болсон энэ аллага бол мэдээлэл зөвхөн нийгэм дахин байгуулагдсан үед л ашиглагдах болно гэх утгаар хүн амын боловсролтой хэсэг рүү чиглэж, шударга ёсны тогтолцоог нураасан билээ.

Өөрийн оронд буй хүний эрхийн зөрчлийн түүхийг та бүхэн хэрхэн бүртгэн тайлагнаж чадах вэ? Гажуудлыг засах, шударга ёсыг дэмжихийн тулд тэрхүү түүхийг хэрхэн ашиглаж болох вэ?

From Refugee to Mental Health Paraprofessional:

Дүрвэгчээс Сэтгэцийн Эрүүл мэндийн бага мэргэжилтэн хүртэл: Гэмтэл эмгэгт чиглэсэн эрчимжүүлсэн загвар сургалтаар сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ бий болгох орон нутгийн чадавхийг бэхжүүлэх нь.

Эрүү Шүүлтийн Хохирогчдод Туслах Төв (Хүний Эрхийн Шинэ Тактикууд төслийг зохицуулагч бөгөөд энэхүү номыг нийтлүүлэгч байгууллага) хүн амын дийлэнхи нь эрүү шүүлт, дайны хор хохирлоос болж зовж зүдрэн гэр орноо орхихоос өөр аргагүй болсон улс орнуудын сэргээн босгох ажилд тусалж байна.

Эрүү Шүүлтийн Хохирогчдод Туслах Төв нь (CVT) Гвиней, Сьерра Леон улсуудын дүрвэгсдийг зөвлөгч болгон эх оронд нь сургадаг. Урьд нь сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэггүй байсан эдгээр оронд тэндэхийн дүрвэгсэд CVT-ийн үйлчлэх ажилтнуудын нэг болсноор сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн бага мэргэжилтэй боловсон хүчин бий болж, эрүү шүүлт, дайны хор хохирлоос зовж шаналсан бусаддаа уг үйлчилгээг үзүүлдэг боллоо. Бага мэргэжилтнүүд мэргэжлийн олон янзын үүргийг зөвхөн тусгай удирдамж, хяналтын дор хэрэгжүүлдэг аж.

Баруун Африкийн орнуудын дайн дажин, дотоодын мөргөлдөөн нь хүн амын дийлэнхи хэсэгт нөлөөлж, маш олон хүнийг дүрвэгсдийн хуаранд амьдрахад хүргэсэн юм. Үүнээс болж сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг CVT шиг олон улсын байгууллагын ажилтнууд тус бүс нутагт хүрэлцэхгүй байна. Иймд CVT дүрвэгсдийн хуарангуудаас нөөц бололцоог хайхаар шийдсэн бөгөөд Гвиней, Сьерра Леоны хуарангуудаас 120 гаруй дүрвэгчийг зөвлөгч буюу сэтгэл зүйн төлөөлөгчөөр (PSA) элсүүлжээ.

Эрүү шүүлтийн хохирогсдод туслах зорилгоор туслалцаа хэрэгтэй хүмүүс бөөнөөр цуглах боломжтой, удаан хугацааны хяналт, сургалт явуулж болох байршил сайтай газруудыг дүрвэгсдийн хуаранд бий болгов. Балмад хүчирхийлэл үйлдэгдсэн газарт хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө PSA-ийн олонхи нь дөрвөн жил хүртэл хугацааны тасралтгүй сургалтанд хамрагдаж, өдөр тутмын хяналт удирдлагаар хангагддаг байна.

CVT-ийн эрчимжүүлсэн, шууд гардан хийх загвар сургалт нь эмгэг шархыг эмчлэх орон нутгийн ойлголт, Барууны сэтгэл зүйн эмчилгээтэй хослон явагддаг. Хөтөлбөр хоёр долоо хоногийн сургалтаар эхэлж, сар тутам нэг бүтэн өдрийн, улирал тутам долоо хоногийн сургалтуудаар үргэлжилдэг. Сургалтуудаар эмгэг гэмтлийн онол, ерөнхий сэтгэл зүй болон зөвлөгөө өгөх, харилцааны чадварыг түлхүү олгодог. CVT-ийн сэтгэл зүйчид, нийгмийн ажилтнууд PSA-уудын зан чанарыг төлөвшүүлэх, ур чадвараа дадлагажуулахад нь туслан өдөр бүр ажилладаг. PSA нар сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд эмчилгээний бүлгийг хэрхэн чиглүүлж буйд 10 долоо хоногийн ажиглалт хийж, 10 долоо хоног хамтран удирдаж, 10 долоо хоног өөрсдөө үе шаттай үзлэг хяналтаа бие даан удирддаг байна. Сургалтынхаа төгсгөлд тэд гэмтлийн үр нөлөө, эмчилгээний арга чадвар, хөтөлбөрийн үнэлгээний талаар дадлагажсан хүмүүс болсон байдаг. Түүнчлэн тэд ур чадвар сайтай зохион байгуулагчдын бүлэг, үр өгөөжтэй харилцагчид билээ.

CVT энэ тактикийг иргэд өөрөө өөрсдийгөө эдгээж сурахад нь туслах зорилгоор хэрэглэж буй билээ. Тэд бол шинэ чадварт суралцсанаараа өөрсдийн адил дүрвэгсдийн төлөө ямар нэгэн сайн зүйл хийх эрхтэй болсон хүмүүс юм. Гадаадын хэн нэгэн иргэн бус харин өөрсдийнх нь дундаас нэг нь тэдэнд туслах байр сууринд хүрснийг хүмүүс олж хардаг. Тэгээд өөрсдөдөө шаардлагатай сэтгэцийн эрүүл мэндийн халамж үйлчилгээг хүлээн авдаг юм.

Эрүү шүүлт, дайны хохирогсдод туслах энэ тактикийг хэрэгжүүлж байхад эрх нь гүн гүнзгий зөрчигдсөн бусад улс үндэстнүүдэд бас хэрэглэж болох нь ажиглагдсан.

Анагаах ухаан, сэтгэцийн эрүүл мэнд эсвэл олон нийтийн эрүүл мэндийн бага мэргэжилтэй боловсон хүчнийг хөгжүүлэх нь танай ажилд чухал үүрэг гүйцэтгэх үү? Энэ чадавхийг та бүхэн хэрхэн хөгжүүлж болох вэ?

Page 100

Telling stories online

Үйл явдлуудыг онлайн сүлжээгээр өгүүлэх: Түүхээс нь хуваалцаж, шинэ ур чадварыг хөгжүүлэхийн тулд цэрэгт дайчлагдаж байсан хүүхдүүдэд зориулсан хуудсыг Интернэтэд бий болгосон нь

Шинэ технологиуд хүний эрхийн зөрчлүүдийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх боломж олгодог.

2000 онд эхэлсэн Сьер Леон дахь Олон Улсын Боловсролын ба Эх Сурвалжийн Сүлжээний (iEarn Sierra Leone) “Цэрэг Хүүхэд” төслөөс цэрэг байсан хүүхдүүд өөрсдийн түүхээ хуваалцаж чадах цахим хуудсыг бий болгоод буй билээ. Тэрхүү цахим хуудас нь (www.childsoldiers.org) цэрэг хүүхдүүдийн эссэ, шүлэг, зурсан зураг, санал бодлыг нь нийтэлж, онлайн хэлэлцүүлгийг санал болгодог.

iEarn Sierra Leone өмнө нь цэрэг байсан хүүхдүүдэд төслийн тухай мэдээлэхээр сургууль, эмнэлэг, зуслангуудаар айлчилж, радиогоор зар өгч, сонинд өгүүлэл нийтлүүлдэг ажээ. Оролцогчид нь уншиж, бичих болон компьютер дээр ажиллах анхны мэдэгдхүүнийг заалгадаг байна. Мөн тэд сайн дурын сувилагчид, сэтгэл судлаачдаас сэтгэлийн эмгэг шархаа эдгээх зөвлөгөө авдаг юм.

Оролцогчид компьютер дээр ажиллах чадвартай болмогцоо тус цахим хуудсыг ашиглан өөрсдийн бодол санаа, туршлагаа хуваалцаж эхэлнэ. Цэрэг хүүхдүүдийн түүх, зураг, дуу хоолой бүхий галлерей дэлхий дахины улс түмнүүдээс бие биенээ дэмжиж, эв нэгдэлтэй байхыг сануулж байна.

Олон талт хэлэлцүүлэг нь оролцогчдыг дараа үеийнхээ цэрэг хүүхдүүд, бусад хүмүүстэй хэлэлцэх, мэтгэлцэх боломжтой болгодог. Оролцогчид өөртөө итгэх итгэлтэй болж, нийгэмд өөрсдийн байр суурийг амархан олох чадварт суралцдаг. Одоогийн байдлаар цэрэг байсан 200 гаруй хүүхэд энэ төсөлд оролцоод байгаа юм.

Энэ бол тарж сарнисан бүлэг хохирогчдыг бие биетэйгээ холбогдож, өөрсдийн түүхээ хуваалцахад нь туслахын тулд Интернэт ашигладаг тактик бөгөөд мөн эрх нь зөрчигдсөн хохирогчид бутарч сарнисан эсвэл зөрчил хүн амын цөөнх рүү (жишээ нь: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ижил хүйстнүүд гэх мэт) чиглэсэн бөгөөд хүмүүс өөрсдийн хүрээндээ ч туулсан туршлагаа ярьж чадахгүй нөхцөлд хэрэглэгдэх боломжтой.

Өөрсдийг нь ойлгох бусад хүмүүстэй холбогдох аюулгүй орон зайг Интернэт үүсгэж чаддаг. Гэхдээ Интернэт дэх хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, зохиогчийн нэрийг нууцлах нь дандаа баталгаатай байх боломжгүй.

Уг тактик нь шаардлага хангасан дэд бүтцийг шаарддаг хэдий ч дайнд сүйрсэн, дэлхийн хамгийн ядуу зэрэглэлийн орон болох Сьер Леонд амжилтанд хүрсэнээрээ ийм бэрхшээлийг давж болдог гэдгийг iEarn харуулж байна.

Өөрсдийн түүхээ ярихад нь хүмүүст та хэрхэн боломж олгож чадах вэ?

Зарим нэг нь урлагийн янз бүрийн авъяастай эдгээр хүүхдүүд амьдралаа дээшлүүлж чадна гэсэн итгэлийг өөрт нь төрүүлж өгч буй өөрсдийн авъяасыг дахин нээж чадаж байна. Тэдний дуу, зурсан зураг, зохиосон хөгжмийн зэрэгцээ үе тэнгийнхнээс нь ирсэн маш олон хариу захидлууд нь нийгмийн шударга ёс, зөв өөрчлөлтийн төлөөх нэгэн арга зам боллоо.

— Эндрю Бенсон Грийн, childsoldiers.org, Sierra Leone

Demanding compensation:

Нөхөн төлбөр шаардах: Цагдаа, цэрэг, зэвсэгт хүчний албан хаагчдын буруугаас болж эрх нь зөрчигдсөн хохирогчдод нөхөн төлбөр олгохыг засгийн газарт ойлгуулах нь

Энэтхэгт Хүний Эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийн зөрчлүүдийн талаарх гомдлуудыг мөрдөн шалгаж, хохирогчдод нөхөн төлбөр олгохыг орон нутгийн засаг захиргаанд зөвлөдөг аж.

Энэтхэгийн Хүний Эрхийн Комисс цагдаагийн буруутай үйл ажиллагаа болох нь батлагдсан гомдлуудын дагуу хохирогчдод санхүүгийн нөхөн төлбөр олгох, гэмт этгээдүүдэд зохих шийтгэл оногдуулахыг засгийн газраасаа хүсдэг байна. 1993 оны Хүний Эрхийг Хамгаалах Хуулийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж байгуулагдсан тус Комисс нь хүчирхийллийг өдөөсөн, эс бөгөөс сэргийлэх талаар хайнга хандсан зэрэг төрийн албан хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчлүүдийг мөрдөн шалгах, арга хэмжээ авахыг зөвлөх эрх мэдэлтэй. Хүлээн авдаг гомдлуудын дийлэнхи нь цагдаагийн байгууллагын эсрэг гаргасан гомдлууд байдаг боловч уг Комисс мөн цэргийн ба зэвсэгт хүчний албан хаагчдын үйлдсэн зөрчлийн хохирогчдод нөхөн төлбөр олгохыг зөвлөдөг ажээ.

Хүний эрхийн идэвхтнүүд, хэвлэл мэдээллийн эх сурвалжуудын зэрэгцээ хохирогчид болон тэдний төрөл садангуудаас зөрчил гарсан тухай гомдлуудыг хүлээн авдаг байна.

Бие махбодын хүчирхийлэл, хувь хүн ба гэр бүлүүдэд чиглэсэн халдлагууд, эмэгтэйчүүдэд хандах хандлагын талаарх журам үл мөрдөгдөх, хууль ёсны болон хууль бус хорионд байхад нь үл тоох, эрүү шүүлт зэрэгтэй холбоотой гомдлууд түгээмэл ирдэг. Мөн хүүхдийн ба хөлсний хөдөлмөр эрхлэлт болон хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, зарим каст ба омгууд, дүрвэгсэд, цөөнхүүд зэрэг нийгмийн эмзэг давхаргын гишүүдийн эрхийн зөрчлүүдтэй холбогдох гомдлуудыг хүлээж авдаг юм.

Гомдлыг хүлээж аваад Комисс лавлах баримтуудыг авчруулж, хэргийг шалгуулахаар мөрдөн шалгах хэсгээ оруулдаг. Хэрэв уг хэрэг батлагдвал хүчирхийлэл үйлдэгдсэн муж улсын засгийн газарт илтгэлээ явуулдаг.

Хохирогчдод санхүүгийн нөхөн төлбөр олгох, зөрчил гаргагчид хариуцлага тооцох арга хэмжээ авахыг сануулсан зөвлөмж энэ илтгэлд дурдагддаг. Хүчирхийлэл үйлдсэн төрийн албан хаагчаас гаргуулах нөхөн төлбөрийн хэмжээг засгийн газар нь тогтоохгүй.

Тус Комисс хамгийн ноцтой хэргүүдийн талаар “*Human Rights*” хэмээх сар тутмын сонин бичиг, жилийн тайлан илтгэлдээ дэлгэрэнгүй нийтэлдэг. Мөн хэвлэл мэдээллээр томоохон хэргүүдийг нийтэлж, нэвтрүүлдэг байна.

Зөвхөн боломжийн хэмжээний нөхөн олговор л хохирогчид, тэдний гэр бүлийнхэнд амьдралаа дахин босгоход нь тус болдог. Түүнчлэн энэ тактик нь бусад талаар сайжруулан өөрчлөх буруу хандлага төрүүлэх ёсгүй гэдгийг нягтлан авч үзэх ёстой. Хэдийгээр иймэрхүү зөрчлүүд байдаг ч Хүний Эрхийн Комиссын ажил нь төрийн албан хаагчдад өөрсдийнх нь үйл ажиллагааны хор уршгийг мэдүүлэх, хожим гарч болзошгүй хэрэг зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой билээ.

Ийм комиссыг байгуулах нь төрийн эрх барьж буй албан хаагчдын томоохон дэмжлэгийг болон хохирогчид, тэдний ар гэрийнхэн айдасгүйгээр энэ тусламжийг ашиглаж болохыг нь баталгаажуулахад зайлшгүй сурталчилгаа, сурталчилгааны кампанит ажлуудыг иргэдийн дунд явуулахыг шаарддаг юм.

Төрийн байгууллагууд, дэд бүтцүүдийг хариуцлагатай байлгаж, өөрсдийн үйл хэргийг дэмжүүлэхийн тулд тэдэнд ойлгуулах ажлыг хэрхэн эхэлж болох вэ?

Page 110

Taking responsibility for the past

Өнгөрсөн явдалд нь хариуцлага тооцох: Нийгмээс тусгаарлагдсан бүлгийн төлөө олон нийтийн хүчийг дайчлах.

Зөрчил үйлдэгчдийг илрүүлж, хариуцлага тооцох нь эрх тэгш байхын зөвхөн нэг тал нь билээ. Хүний эрхийн зөрчлүүдээс үүдсэн хохирлыг арилгахуулахын тулд зарим байгууллагууд хохирогчдод ихэвчлэн эмчилгээ хийх, нөхөн төлбөр эсвэл хураагдсан эд хөрөнгийг нь буцаан олгуулах арга замыг эрэлхийлдэг.

Ийм байгууллагууд өөрсдийн арга замыг амжилтанд хүргэхийн төлөө засгийн газраа тухайн хэрэг зөрчилд оролцсоноо хүлээн зөвшөөрч, хохирогчдод нөхөн

төлбөр олгох, тэдэнд эмчилгээний туслалцаа үзүүлэх үүрэгтэй болохыг нь ойлгуулах ёстой болдог.

Румыний ICAR Сан нэгдүгээрт эрүү шүүлтийн эмчилгээний төвүүдэд бодит нөхцөл бүрдүүлэх, хоёрт эрүү шүүлтээс амьд үлдсэн хохирогчдод шаардлагатай тусгай анхаарал, үйлчилгээнд зориулагдсан үнэгүй эм, даатгалаар үйлчлүүлэх эрх олгох талаар туслахыг засгийн газартаа шахалт болгожээ.

ICAR-ийн тактик бол илүү сайн сайхан ирээдүйг бий болгохын тулд улс үндэснийхээ туулж өнгөрсөн бүхэнд засгийн газар хариуцлага хүлээх ёстойг ойлгуулах стратегийн нэг хэсэг нь юм. Румыний коммунист дэглэмийн үеийн эрүүдэн шүүгчдийн олонхи нь ямар ч ял шийтгэлгүйгээр оргон зайлсан ба зарим нь одоо нийгэмд нөлөө бүхий албан тушаалуудыг эзэлжээ.

Ардчилал, хүний эрхийн хувьд илүү сайн нийгмийн баталгааг бий болгохын тулд өнгөрсөнөөс суралцахын оронд түүнийг мартах нь дээр гэх бодит хүчин зонхилсон нийгэмтэй хохирогчид нүүр тулж байна.

ICAR нь Румыний улс төрийн хоригдлуудын Холбоотой хамтран ажиллаж, эхлээд хохирогчдын итгэлийг олж авахыг хичээж, дараа нь хүлээн авах эмнэлгийн зохистой үйлчилгээ, санхүү, хууль тогтоомжийн дэмжлэг зэргээс бүрдсэн байгууллагын хэрэгцээг тодорхойлжээ.

Эдгээр хэрэгцээг хангахын тулд ICAR бусад байгууллагуудын дотроос мэргэжлийн үйлчилгээ явуулахаар иргэний нийгмийн үйлчилгээнүүд, эмнэлгийн мэргэжилтнүүд, хот, дүүргийн захиргааны болон Эрүүл Мэндийн Яам зэрэг засгийн газрын байгууллагуудын албан хаагчид руу чиглэн ажиллав. Мөн иргэний нийгмийн бусад жижиг байгууллагууд, хэвлэл мэдээлэл болон Эрүү Шүүлтийн Хохирогсдыг Сэргээн Эмчлэх Олон Улсын Зөвлөлтэй (Дани улс дахь) холбоо байгуулан ажилласан юм.

Хэдийгээр энэ нь арваад жилийн хөдөлмөр шаардсан боловч ICAR нь өнгөрсөн дэглэмийн үед зовж шаналсан хүмүүсийн өмнө Румыний засгийн газар хариуцлага хүлээх ёстойг ойлгуулж чадсан билээ.

Дэлгэрэнгүйг www.newtactics.org цахим хуудас дахь Тактикийн тэмдэглэлээс уншина уу.

ICAR-ын амжилт бол тухайн үед Румын улсад явагдаж байсан улс төрийн шилжилтээс ихээхэн хамаарсан хэцүү ялалт байв. ICAR улс төрийн энэ

нээлттэй байдалтай хэрхэн холбогдохоо тодорхойлж, түүнийг өөрийн давуу тал болгон ашиглаж чадсан юм. Мөн шинэ гарсан хуулиуд, дөнгөж нээлттэй болж эхэлж байсан нийгэм хохирогчдыг өс хонзогнолын айдасгүйгээр зохион байгуулагдахыг дэмжиж байлаа. ICAR-ын тактик хохирогчдод нөхөн төлбөр олгох, ял завших явдлыг зогсоох гэсэн хоёр зорилгод үйлчилсэн юм.

Хохирогчдод үзүүлэх үйлчилгээнд нөөц хөрөнгө зарцуулахад засгийн газрын анхаарлыг хэрхэн татах вэ?

Going Door- to Door to Find Allies:

Хаалганаас хаалганд хүрч, холбоотнуудаа олох: Хүний эрхийг дэмжих боломжтой холбоотнуудаа олохын тулд нэр дэвших кампанит ажлыг ашигласан нь.

Гэр бүлийн хүчирхийлэл бол эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийн алиных нь амьдралд нөлөөлдөг асуудал хэдий ч ихэвчлэн эмэгтэй хүнд хамаатай асуудал мэт авч үздэг. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад эрчүүдийг оролцуулах ер бусын тактик хэрэглэдэг байгууллага Өмнөд Африкт байдаг.

Өмнөд Африкийн “Зургаад тав нь” төсөл “Өдөр бүрийн Баатар” кампанит ажлынхаа хүрээнд эмэгтэйчүүдэд эерэгээр ханддаг эрэгтэйчүүдийг олж тодруулахыг бүсгүйчүүдээс хүсжээ. Тэгээд тэдгээр эрсийг эмэгтэйчүүдийн эрхийн шинэ өмгөөлөгчид болохыг урьсан байна. Өмнөд Африк бол дайн дажингүй бүх улс орнуудаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн зэргээрээ хамгийн өндөр орон. Судалгаагаанаас үзэхэд эндхийн зургаан эрэгтэй тутмын нэг нь хамт амьдарч байгаа эмэгтэйнхээ эрхийг зөрчдөг аж. “Зургаад тав нь” төсөл эмэгтэйчүүдийн эрхийг зөрчдөггүй бусад таван эрэгтэй рүү чиглэжээ. Төсөл цаашдаа ийм эрчүүдийг олж хайх “Өдөр бүрийн баатар” кампанит ажил болон өргөжиж, тэднийг тэмцэлдээ татан оролцуулж байна. Сайн дурынхан өрх бүрээр явж эмэгтэйчүүдээс сайн, эерэг эрчүүдийг мэдээллийг цуглуулдаг. Улсынхаа “Хамгийн сайн” аав, авга, нагац ах, ах, эрэгтэй дүү, өвөө нар болон эрэгтэй найзыг шалгаруулахаар шуудангаар явуулсан нэр дэвшүүлэлтэнд 50,000 гаруй хариу ирсэн байна. Нутгийн сүмүүдийн ханыг тэдний нэрс, нэр дэвшүүлсэн маягтаар дүүргэн чимэх зэргээр кампанит ажлын ойлголтыг түгээж, оролцох хүмүүсийнхээ тоог нэмэгдүүлдэг ажээ.

Нас, туршлага, нийгмийн давхарга, санхүүгийн чадавхийн хувьд өөр өөр олон эрчүүдийг хамарсан “иргэний асуудал”-аар хэлэлцэх уулзалтуудад нэрсийн жагсаалтанд буй хүмүүс сайн дураараа уригдан оролцдог байна. Уулзалтууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, хамтдаа хөгжих асуудалд голлон анхаардаг. Бусад хэлэлцүүлгүүд нь хүйс хоорондын харилцааны хүчийг ойлгох, өөрийн

хүндэтгэлийг бий болгох, орон гэрийн бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэх зөв арга зам эрж хайхад нь эрчүүдэд тусалдаг. Олон оролцогчид гэр бүлийн хүчирхийллийн талаар өөрсдийн ойлголтонд нь болон бусад эрэгтэйчүүдийг уг асуудалд татах чадварт нь гайхамшигтай өөрчлөлт гарч байгааг тэмдэглэсэн юм. Олонхид нь эдгээр асуудал өмнө нь сонсогдож байгаагүй анх удаагийн зүйл байсан бөгөөд үр дүн сайтай байна.

Нутагтаа үлгэр жишээ эрэгтэйчүүдийг олж илрүүлэн, хүндэтгэснээр “Зургаад тав нь” төсөл нийгэмд эерэг үүрэг гүйцэтгэж байгаа нутаг нутгийн үлгэр жишээ эрчүүдийг хооронд нь холбох боломжтой болж, тэднийг гэр бүлийн хүчирхийллийн тухай хэлэлцэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оролцуулан энэ нь нийгэмд тулгарч буй бусад асуудлын үндсэн хэсэг нь хэмээн үзэхэд анхаарлыг нь хандуулдаг.

Нэр дэвшүүлэх энэхүү кампанит ажил нь тодорхой асуудлуудад санаа зовнидог ч идэвхтэй оролцдоггүй “боломжийн холбоотон, дэмжигчид”-ийг олж тогтооход тусалдаг. Тэд бол өөрсдөд нь уг асуудал нөлөөлж байгааг мэддэггүй эсвэл зүгээр л оролцох боломж олддоггүй байсан эс бөгөөс тэднийг уг асуудлаас хол байлгах нийгэмд тогтсон уламжлалтай учраас оролцдоггүй. “Зургаад тав” төсөл нь нэгэн удаа тэдгээр идэвхгүй дэмжигчдээ олж тодорхойлсны дараа тэдний заримыг идэвхтэй дэмжигчид болоход тусалсан нь үр нөлөөг нь өсгөсөн байна. Идэвхтэй дэмжигчид болсон тэд зайлшгүй мэдээлэл, арга хэрэгслэлээр хангагдан бусад эрчүүдэд ярьж, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө илүү олон дэмжигчдийг бий болгож байв.

Та бүхний хувьд хэн идэвхгүй холбоотон буюу дэмжигч вэ?

Тэдний оролцоо, дэмжлэгийг авахын тулд та ямар тактикуудыг хэрэглэж чадах вэ?

page 123

Building networks through text-messaging:

Гар утасны Зурвасаар дамжуулан сүлжээ бий болгох: Гар утасны зурвасыг ашиглан хүний эрхийн үйл ажиллагааны дэмжигчдийн тойргийг бий болгох

Хүний эрхийн ойлголтыг түгээх, хүний эрхийн кампанит ажлуудад хүмүүсийг ялангуяа залуучуудыг өргөнөөр татан оролцуулахад орчин үеийн технологи ашиглагдах боломжтой боллоо.

Нидерландын Эмнести Интернэшнл шинэ гишүүд, нэн ялангуяа залуу гишүүдийг байгууллагадаа татах, Эрүү Шүүлтийн эсрэг кампанит ажлынхаа талаар мэдлэг олгох, яаралтай уриалгуудад хариу хурдан бичихэд нь хүмүүсийг урамшуулах зорилгоор гар утасны зурвас бичих технологийг ашигладаг. Уг зурвас дамжуулах технологийг ашигласны шууд үр дүнд 500 гаруй шинэ гишүүд энэхүү хөдөлгөөнд нэгдэж, яаралтай уриалганд 5,000 орчим хариу илгээгээд байна.

Энэхүү тактик нь 2001 онд нэгэн хүнийг эрүү шүүлтээс нэн даруй хамгаалах ажиллагааны үеэр Эмнести Интернэшнлийн Нидерландын секц уг ажилд оролцогч мянга мянган хүмүүсийн гар утас руу зурвас илгээснээр анх хэрэглэгдэж эхэлжээ. Зурвас илгээх кампанит ажилд сайн дураараа оролцсон тэдгээр оролцогчид уриалгад хариу ирүүлснээр хэдхэн цагийн дотор эрүүдэн шүүх хэргийн эсрэг эсэргүүцлийн олон мянган гарын үсгийг Эмнести Интернэшнл цуглуулж чадсан билээ. Тус байгууллага тэдгээр олон эсэргүүцлийг факс болон цахим шуудангаар эрх баригчдад хүргүүлсэн байна. 2.5 сая хүнд хүрдэг телевизийн хамгийн алдартай Бямба гаригийн үдшийн хөтөлбөрөөр яаралтай үйл ажиллагааны гол сэдэв болж, үр дүнг нь хүртсэн Тунис эрэгтэйн тухай мэдээлснээрээ Нидерландын Эмнести Интернэшнл уг аргаа нийтэд таницуулсан юм. Үзэгчид уг Яаралтай Үйл ажиллагааны уриалга дөнгөж 160 тэмдэгт бүхий зурваст багтсаныг мэдлээ. Хариулахын тулд ердөө 'JA' (Тийм) гэдэг үгийг л "4777" дугаар руу илгээх хэрэгтэй байв. Нэг минут өнгөрсний дараа талархлын үгтэй, мөн хичнээн хүн эсэргүүцлээ илэрхийлээд байгаа тухай мэдээлэл агуулсан өөр нэг зурвасыг оролцогчид буцаан хүлээж авчээ. Хожим нь саатуулагдсан хүн суллагдсан зэрэг кампанит ажлын үр дүнг илтгэсэн зурвас хүлээж авдаг.

Эмнести Интернэшнл Яаралтай Үйл ажиллагааны хэргүүдэд дурьдагдсан хүмүүсийн нөхцөл байдлыг сайжруулах шууд хариуцлагыг ховорхон шаарддаг хэдий ч ойролцоогоор уг хэргүүдийн 1/3 орчим нь амжилтанд хүрдэг: цаазаар авах ял хөнгөрч, "сураггүй алга болсон" хүмүүс олдож, хоригдож буй хүмүүсийн хаана байгаа нь мэдэгддэг юм. Тиймээс эрүү шүүлт явагдах

боломж буурч байгаа бөгөөд хүндээр өвчилсөн хоригдлуудад үзүүлэх эмнэлгийн анхаарал халамж дээшилж байгаа билээ.

Түүнчлэн энэхүү кампанит ажил нь олон хүмүүсийг түүний дотор мянга мянган залуучуудыг Эмнести Интернэшнлийн Яаралтай Үйл ажиллагааны сүлжээнд нэгдэхэд нь нөлөөлдөг .

Маш олон хүн байдлыг өөрчилж чадахаа мэдрэн оролцох энгийн ажиллагааг ашиглан Эмнести Интернэшнл хэн нэгэнд тусламж хэрэгтэй бол.дэлхийн аль ч газарт хүрч ажиллахыг хичээдэг. Кампанит ажлууд нь олон түмэнд хүний эрхийн боловсрол олгож, эрүү шүүлт зэрэг хүний эрхийн зөрчлүүдийн талаар түгээмэл ухамсрыг төлөвшүүлдэг юм.

Зурвас илгээх кампанит ажил нь хохирогчид туслах ажилд хурдан хариу өгөхийн зэрэгцээ шинэ дэмжигчдийн хүрээнд Эмнестигийн боловсролын нөлөөг өргөжүүлдэг билээ. Зурвас илгээх кампанит ажил нь бусад арга хэмжээ, үйл ажиллагаануудаар хийж үл чадах хэмжээнд шинэ залуу гишүүдийг Эмнести Интернэшнл рүү татаж чаддаг аж. Эмнести Интернэшнлийн ямагт хүрэхийг хүсдэг нийгмийн давхарга болох залуус гар утасны хамгийн өргөн, байнгын хэрэглэгчид билээ. Залуусын соёлын энэхүү хамгийн түгээмэл хэрэглүүрийг ашигласнаараа Эмнести Интернэшнл удаан хугацааны турш кампанит ажилд эрч хүчээ зориулах шинэ залуу идэвхтэнүүдийг төлөвшүүлж байна.

Public dialogue with the Police Force:

Цагдаагийнхан ба олон нийтийн харилцан яриа: Хүний эрхийн талаарх гомдлууд болон цагдаа иргэдийн харилцаанд нөлөөлж буй бусад асуудлыг шийдвэрлэхээр цагдаа, энгийн иргэд хамтран ажиллаж болох урт хугацааны нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах нь.

Олон улс оронд байдаг нэгэн зөрөлдөөнтэй зүйл бол цагдаа, иргэдийн хоорондын харилцааны асуудал. Тааруухан харилцаа нь олон нийтийн аюулгүй байдлыг зөрчил, эсвэл харилцан буулт хийх байдалд хүргэдэг. Нигерийн нэгэн байгууллага энэхүү ангальг давах шинэлэг арга замыг олоод байна.

CLEEN Сан буюу Нигерийн Хууль Сахиулах Боловсролын Төв нь гэмт хэрэг, цагдаагийнхны зан харилцаатай холбоотой санал, шүүмжлэлүүдийг иргэд, цагдаагийнхан хамтдаа хэлэлцэж болох нийтийн хэлэлцүүлгүүдийг санаачилжээ. Ингэснээр иргэд, цагдаагийн байгууллагынхан үр дүнгүй байнгын үл итгэлцлийн байдалд буйгаа олж мэддэг. Цагдаагийнхны зан суртахуунгүй, харгис хэрцгий байдал болон авилгад автсан тухайд иргэд голлон санаа зовнидог. Харин цагдаагийнхан иргэдийг мөрдөн шалгах ажилд хамтрах аргагүй, дайсагнасан байдлаар үнэлж хардаг байна.

Нигерийн цагдаагийн байгууллагын бүтцийн төвлөрөл улс орон даяар нэг л хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэхээс аргагүйд хүргэдэг ба үүний дүнд цагдаагийн байгууллагын хууль сахиулах нэн тэргүүний шаардлага болон орон нутгийн иргэдийн хэрэгцээний хооронд ангал үүсэж, асуудалд нэрмээс болдог. CLEEN орон нутгийн удирдлагуудад иргэдтэйгээ нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахыг санал болгон захидлуудыг илгээж, энэхүү хоорондын холбоогүй байдлын гүүр нь болон ажиллаж эхэлсэн юм. Орон нутгийн удирдлагууд хамтран ажиллахаар хариу өгч, нутгийн цагдаагийн байгууллагынхан аюулгүй байдлыг нь хамгаална хэмээн амласан үед тус байгууллага ажлаа үргэлжлүүлдэг. Ингээд CLEEN зөрчил мөргөлдөөнийг хэрхэн шийдвэрлэх тухай сургалт хийхийн зэрэгцээ нутгийн иргэдийн гомдолд цагдаагийнхны өгөх хариултууд, тухайн газарт CLEEN-ний хөтөлбөр хэрэгжих боломжийн талаар

цагдаа, нутгийн иргэдийн төлөөлөл оролцсон уулзалтуудыг зохион байгуулдаг байна. Эдгээр уулзалтаар иргэдийн бүлэг, овог бүр өөрийн шаардлагад нийцсэн хөтөлбөр бий болгох боломжтой байдаг. Түүний дараа бүлгийн хоёр гишүүнийг хэлэлцүүлгүүдийг зохицуулуулахаар хоёр жилийн хугацаатайгаар хагас цагаар хөлслөн авдаг байна. Хоёр жилийн дараа тухайн бүлэг, овог уг хөтөлбөрийг өөрсдөө үргэлжлүүлэх арга зам олох ёстой.

CLEEN-ний тактик нь иргэдийн бүлгийн /овгийн төлөөлөл, цагдаагийн албан хаагчдын санаа бодлоо хуваалцах, хүнд суртлаас үүдсэн гол саад бэрхшээлүүдийг даван туулах аюулгүй орчныг бүрдүүлдэг. Сөргөлдөөнт харилцаатай байж болох хоёр тал сөргөлдөхийн оронд хамтран ажиллах нэг нь нөгөөгөө нэгэн гэж илүү хүмүүнлэгээр харах боломжтой. Цаг хугацаа улирах тусам цагдаагийнхан иргэдэд үйлчлэх өөрсдийн үүргийг ухаарч, иргэд өөрсдийн үүргийн дагуу цагдаад тусалдаг шинэ суурийг тавьсанаар үл итгэлцлийг таслан зогсоож чадна. Энэ нь мөн цагдаагийн хүчирхийлэл, иргэдийн гэмт хэргийн аль алиныг бууруулах болно.

Уг төсөл Нигерийн нутаг дэвсгэрийн зургаан бүсээс сонгогдсон 14 орон нутагт хэрэгжиж байгаа билээ. Үл итгэлцэл, үл ойлголцол нь олон бүлэглэлүүдийн хоорондын зөрчлийг үүсгэж байгаа учраас энэ тактикийг угсаатны бүлгүүд, бизнес эрхлэгчид, газар эзэмшигчид зэрэг зөрчилтэй бусад бүлгүүдийн хооронд илүү бат бэх харилцааг бий болгоход хэрэглэж болох юм. Ганц болзошгүй аюул нь маш хүнд асуудлуудыг тойрсон сэтгэл хөдлөл, хонзонт санаа байдаг. Чиглүүлэгчид нь үүнтэй хэрхэн ажиллах талаар бэлтгэгдсэн байх ёстой бөгөөд үүнийг эцэс болгоход хангалттай урт хугацаа шаардлагатай. Нэг удаагийн уулзалт бол CLEEN-ний урт хугацааны арга барилыг бодоход дэндүү үр дүнгүй зүйл.

Helping Human rights advocates to be more effective:

Хүний Эрхийг Хамгаалагчдыг улам үр дүнтэй байхад нь туслах: Хүний эрхийг хамгаалагчдыг улам үр дүнтэй ажиллахад нь туслах зорилгоор мэдээллийн мэргэжилтэн, тогтолцоог ашигласан нь

Хүний эрхийн ажилтнуудад шинэ ур чадвар, технологи, эсбөгөөс зохион байгуулах ур чадвар суулгах, бодлогын хувьд бэхжүүлэх тактикууд их тустай байдаг.

Сараевын Их сургуулийн Хүний Эрхийн Төв нь хүний эрхийн хамгаалагчдын мэдээлэл хүлээн авалтыг дээшлүүлэхэд анхаардаг. Мэдээллийн хүчирхэг тогтолцоо, мэдээллийн мэргэжилтний голлох үүргийг тэндэхийн ажилтнууд бий болгожээ. Ийм тогтолцоо, мэргэжилтний ур чадварыг ашиглах нь бусад ажилтнуудад өөрсдийн үндсэн хөтөлбөрт зорилтуудад илүү сайн, үр бүтээлтэй анхаарах боломжийг олгодог байна.

Хүний эрхийн байгууллага дотооддоо номын сан, баримтжуулалтын нэгж байгуулснаар мэдээллийн урсгалыг чиглүүлэх, нууц баримтуудыг цэгцлэх, байгууллагын түүхийг он дараалалжуулах, өдөр тутмын ажиллагааг сайжруулахад ажилтнууддаа тусалдаг юм. Энэхүү тактикийн түлхүүр элементүүд гэвэл ур чадвар сайтай номын санч, мэдээллийн мэргэжилтнийг ажиллуулах, зохион байгуулалт сайтай зай талбай, баримт материалын үндсэн цуглуулга, тохиромжтой програм хангамж болон бусад мэдээллийн технологи юм.

Хүний эрхийн номын санч нь хүний эрхийн мэдээллийн технологи, баримтжуулатын мэдлэгтэй байх зэрэг хүний эрхийн байгууллагуудад санал болгох тодорхой ур чадваруудтай байдаг. Номын санчийн үүрэг нь байгууллагын үндсэн зорилготой холбоотой баримт материалуудыг олж авах, үнэлэх, тэдгээрийн үр дүнтэй ашиглалтыг зохицуулах, байгууллагын дотооддоо түгээх явдал юм. Сүүлийн үүрэг нь мэдээллийг ангилах, ач холбогдлоор нь алийг нь тэргүүнд тавихыг шийдвэрлэхээр бусад ажилтнуудтай ойр холбоотой ажиллахад хүргэдэг.

Баримт материалыг цэгцлэх, ажилтнуудын хоорондын үйл ажиллагааг явуулахад хангалттай зай талбайтай байх нь чухал. Баримтжуулах төв нь хамгийн наад зах нь сүлжээнд холбогдсон тооцоолуур, тавиурууд, хавтаснууд бүхий номын санчийн өрөөг бий болгох зайтай байх хэрэгтэй. Ном, бусад материалын үндсэн цуглуулга нь байгууллагын зорилго, түвшингээс хамаардаг. Ерөнхийдээ байгууллага нь өөрийн өнөөгийн болоод ирээдүйн хөтөлбөрүүдэд зайлшгүй чухал мэдээллүүдийг багтаахыг хичээх хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд чадварлаг сайн баримтжуулах төв нь тохиромжтой программ хангамж (каталогжуулах, ангилах, индексжүүлэх, гэх мэт), номын санч нь мэдээллийг чөлөөтэй хүлээн авах боломжтой Интернэт холболттой байх юм.

Сараевын Их Сургуулийн Хүний Эрхийн төвийн номын санчийн ажил нь хүний эрхийг хамгаалагчдад хэрэгтэй, цаг хүч чадлаа хэмнэн илүү үр бүтээлтэй байхад нь зориулагдсан мэдээллийг олж авахад чиглэдэг. Тус төв нь нэлээд том бөгөөд нөөц сайтай байгууллага боловч өнөө үед хүний эрхийн бараг бүх ажлууд бүрэн бөгөөд мадаггүй мэдээллийг цаг тухайд нь хүлээж авахыг шаардлагатай болов. Зайлшгүй чухал эх сурвалжуудтай үедээ үүнийг олж авахад нь хүний эрхийг хамгаалагчдад зөвхөн хагас цагийн ажилтан, эсвэл тууштай сайн дурын ажилтантай байсан ч уг байгууллага тусалж чаддаг. Гэсэн хэдий ч байгууллагын үндсэн зорилгод анхандаа нэг их ач холбогдолгүй мэт харагдах энэ ажлын хэр чухал болохыг номын санчид, мэдээллийн мэргэжилтнүүд өөрсдөө байгууллага, гишүүддээ ойлгуулах ухуулгын тактикуудыг ашиглах хэрэгтэй ч байж болох юм.

Хүний Эрхийн төвийн энэ тактикийг би ахин ашигласан бөгөөд ашигтай байх болно гэдгийг нь мэдэж байсан юм. Үүнийг хариуцсан захиргааны ажилтантай нь би хэдэн цагийг хамт өнгөрөөсөн. Номын сан нь үнэхээр замбараагүй байсан гэсэн. Тэгээд тэрээр номын сангаа босгохын тулд гурван сар зарцуулсан юм билээ. Энэ бол бүхэл бүтэн зуны турш ажилласан үнэхээр нүсэр ажил байсан. Надад маш их хэрэг болсон.

— Беа Бодроги, NEKI, Унгар

Broadcasting human rights:

Хүний Эрхийг хэвлэл мэдээллээр цацах: Хүний эрхийн зөрчилд өртөгсдийг дүрс бичлэгийн технологи ашиглан зөрчлийг гаргаж тавихад сургах нь.

Хүний эрхийн ажилтнуудын хувьд өөрсдийн санаагаа олон нийтэд өргөнөөр хүргэх хэрэгцээ нэлээд гардаг. Дэвшилтэт технологи хөгжсөн өнөө үед дүрс бичлэгийн хэрэгсэл, дамжуулж нэвтрүүлэх технологи болон тэдгээрийг ашиглах ур чадвар ихээр шаардагдаж буй.

Унгар, Румынд байгуулагдсан “Хар Хайрцаг Сан” нь үндэсний цөөнх болсон Цыгануудад хандах хандлагыг дээшлүүлэхийн тулд тэднийг орон нутгийн сувгуудаар телевизийн хөтөлбөр бэлтгэн явуулахад сургаж ажилладаг юм.

Тус сан уран бүтээлийн баг бүрдүүлж, тэднийг дуу дүрст бүтээл туурвихад сургаж, хөтөлбөр цацагдах цагийг нь баталгаажуулж, багууд хоорондын хөтөлбөрийн солилцоог хянадаг ажээ.

Хар Хайрцаг Сан 1997 оноос хойш Унгар, Румыний 12 нутагт ойролцоогоор 150 Ромчуудыг өөрсдийнх нь амьдралд нөлөөлж буй асуудлуудыг орон нутгийнхаа үзэгчдэд мэдээлэхэд сургаад байна. Сангийн зүгээс Цыгануудын хүсэлт шаардлагууд юу болохыг асууж лавлан, угсаа гарлын хувьд холимог таван хүнээс бүрдсэн багуудыг байгуулдаг. Сангийн ажилтнууд эхлээд хувь хүмүүсийн үзэл бодлыг сонсон хэлэлцэх, хөтөлбөрт оруулж болох эмзэг асуудлуудыг тодорхойлох зэргээр сан ба багийн гишүүд, мөн багийн гишүүд хоорондын итгэлтэй харилцааг бий болгоход чиглэн ажилладаг.

Түүний дараа багууд телевизийн уран бүтээлийн анхны мэдэгдэхүүнд суралцаж, үндэсний цөөнхийн асуудлаархи шинжээчидтэй зөвлөлдөг.

Сургалтын сүүлийн гурван өдрийн турш багууд өөрсдийн анхны бүтээлээ туурвидаг. Дүрс бичлэгийн камер, гэрэл, микрофон болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр сан хангаж өгнө. Ингээд багууд тус тус орон нутгийнхаа телевизэд бие даан ажиллаж, өөрсдийн эх сурвалжуудаар сар тутмын хөтөлбөр хийхээр явцгаах ба Сангийн зүгээс тэдний хөтөлбөрүүдийг цацах тогтмол цагийг баталгаажуулан зохицуулдаг байна. Сургалтын дараагийн

зургаан сарын турш Сан багуудыг удирдан чиглүүлж, хянадаг ба багууд өөрсдийн хийсэн дүрс бичлэгүүдээ солилцдог аж.

Уран бүтээлийн багуудын ажлын үр дүн харилцан адилгүй янз бүр байдаг. Зарим багууд орон нутгийн телевизээр хөтөлбөрөө тогтмол цацах ажлаа үргэлжлүүлж байхад зарим нь одоогоор өөрсдийн ур чадвар, тоног төхөөрөмжөө өөрийн байгууллагын үйл ажиллагааг баримтжуулахад ашиглаж байх жишээтэй. Энэхүү амжилтаасаа улбаалан Хар Хайрцаг Сан телевизийн мэргэжилтэй болохыг хүссэн цыган оюутнуудад зориулсан нэг жилийн сургуулийг нээгээд байгаа билээ.

Хар Хайрцаг Сангийн хөтөлбөр нь бүс нутгийн үндэсний цөөнхийг ялгаварлан гадуурхах болоод муйхар заншил баримтлах явдлыг багасгаж, тэдэнд хандах хандлага, үзэл бодлыг өөрчлөхөд дэм болж байна. Унгар, Румын дахь цыганууд нь ихэвчлэн зонхилох хүн амаасаа тусгаарлагдмал, тулгамдаж буй асуудлууд нь далдлагдмал байдаг Түүнчлэн тэд улсынхаа нийт иргэдтэй адил хэмжээнд боловсрол эзэмших, бусад эх сурвалжуудыг ашиглах боломжгүй амьдардаг. Хар Хайрцаг Сангийн сургалтын хөтөлбөр нь оролцогчдодоо өөрсдийн асуудлыг илэрхийлэхэд нь шаардагдах чадварыг зөвхөн өгөөд зогсдоггүй, тэдгээр үйл явдлуудыг үндсэн хүн амын дундаж давхаргынхан дуртайяа сонирхохуйц байдлаар нэвтрүүлэн цацахад тусалдаг юм. Энэ нь бүх нийтийн хүний эрхийг дэмжихээр хүн амын зонхилох болон цөөнхи хэсгийнхэн хамтран ажиллах соёлыг төлөвшүүлэхэд тусалж буй билээ.

Page 139

Documenting torture:

Эрүү шүүлтийг баримтжуулах: Эрүү шүүлтийг баримтжуулж, хохирогчдыг дэмжих мэргэжилтнүүдийн сүлжээ байгуулах нь

Хууль сахиулах байгууллагуудын үйлдсэн хүний эрхийн зөрчлүүдийг гаргаж тавих, эрүү шүүлт хэрэглэж буй талаар нийтийн ойлголтыг дээшлүүлэхийн тулд эмч нар болон өмгөөлөгчидтэй хамтран ажилладаг нэгэн байгууллага Кени улсад бий.

Хараат бус Эмч-Хуульчдын Бүлэг (IMLU) хэмээн бүртгэгдсэн энэ төрийн бус байгууллага нь хохирогчид болон тэдний гэр бүлийнхэнд үйлчилгээ үзүүлдэг

эмч нар, өмгөөлөгчдийн сүлжээ юм. Хууль сахиулах байгууллагынхантай холбоотой сэжиг бүхий үхэл, эрүү шүүлт хэрэглэсэн байж болзошгүй хэргүүдийн баримтжуулалт болон хоригдлууд, эрүү шүүлтийг даван туулсан хүмүүст үзүүлсэн эмнэлгийн ба хууль зүйн туслалцаанд бие даасан мөрдөн шалгалт хийх ажиллагаа тэдний үйлчилгээнд багтдаг аж.

IMLU нь Кенийн Эмч нарын Нийгэмлэгийн Хүний Эрхийн Байнгын Хороо гэх зэрэг мэргэжлийн хороод болон эрүү шүүлтийг таслан зогсоох үйлсэд санаа тавьдаг хуульчдын бүлгийг үүсгэн байгуулах явдлыг дэмжих замаар анх өөрийн сүлжээг зохион байгуулжээ. Хороод байгуулагдмагц IMLU нь эрүү шүүлтийн талаар ажилладаг эмнэлгийн ажилтнууд, өмгөөлөгчдийн чадавхийг бэхжүүлэх цуврал сургалт, хэлэлцүүлгүүдийг явуулсан байна. Сургалт, хэлэлцүүлгүүд нь хүний эрхийг тодорхойлох, шоронгийн захиргаатай харилцаа тогтоох, хүний эрхийн хууль тогтоомж, зөрчлүүдийн талаар мэргэжилтнүүд ба төрийн ажилтнуудыг сургах зэрэг сэдвүүдийн дор орон даяар зохион байгуулагдав.

Эрүү шүүлтийн хохирогчид, тэдний гэр бүлийнхэнд хүрэхийн тулд IMLU Кенийн олон янзын шашны байгууллагууд, өмгөөлөгчид, эмч нар, ТББ-уудтай сүлжээтэй ажилладаг. Үйлчлүүлэгчид нь гэр бүлийн гишүүдээсээ эмнэлгийн ба хууль зүйн удирдамжийн дагуу нарийн баримтжуулсан байцаалт өгөх хүсэлт гаргаж чаддаг.

IMLU нь эрүү шүүлтийн нотлох баримт олдвол хууль ёсны нөхөн сэргээлтийг шаардах талаар үйлчлүүлэгчдээ зоригжуулж өгдөг юм. Хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгчдийг IMLU өмгөөлөгчдийн сүлжээ, хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ эрхэлдэг ТББ-ууд руу илгээнэ. Үүний зорилго бол олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хэргүүдийг мөрдөж, эрүү шүүлтийг хэрэглэхээс урьдчилан сэргийлэх загварыг бий болгох, эрүү шүүлт үйлдэгчдэд сануулга өгөх явдал билээ. Кенид эрүү шүүлтийг илчлэн гаргах IMLU-ийн тасралтгүй оролдлогуудын дүнд хэд хэдэн хэргүүд шүүхэд шилжиж, хоригдлуудын аж байдал, эмчилгээнд санаа тавих байдал дээшилсэн. Түүнчлэн одоо шоронгийн эрх баригчид эрүү шүүлт, бие махбодын шийтгэлүүдийг хэрэглэхийг бууруулж, шоронгийн нөхцөл байдлыг сайжруулах сонирхолтой буйгаа харуулдаг болжээ.

2002 оны эцсээр шинэ засгийн газар төрийн эрх авсанаас хойш төрийн албан хаагчид хүний эрхийн IMLU-тай хамтран ажиллаж эхлээд байна.

Мэргэжлийн сүлжээдийг зохицуулж, гишүүдийг нь эрүү шүүлтийг баримтжуулахад сургаснаар IMLU нь Кени улсын эрүү шүүлтийн талаарх ойлголтыг дээшлүүлсний, дүнд эрх баригчид эрүү шүүлтээс сэргийлэх нэмэлт шахалтуудад ороод байгаа юм. Тус сүлжээ нь мөн эрүү шүүлтийг зогсоохын төлөө улс орон даяарх дэмжлэгийг бэхжүүлж, өөрсдийн ур чадвараа хүний эрхийг дэмжихэд зориулах гэсэн зарим эмч, өмгөөлөгчдийн шаардлагыг онцлон авч үздэг.

Гэхдээ энэхүү үйлс сорилт, бэрхшээлгүйгээр явж ирээгүй юм. Үйлчилгээнүүдийнхээ шаардлагын улмаас хохирогчдыг дэмжих санхүүгийн чадавхиа ихэнхдээ хэтрүүлэх, хөдөөгийн хохирогчид ихэвчлэн нийслэл Найроби хотод оршин суух сүлжээний өмгөөлөгчдөөсөө хариу авах нь удаашралтай байх зэрэг бэрхшээлтэй IMLU тулгарч байв. Мөн хэргийг дахин мөрдөн шалгах ажиллагааг баримтжуулах ажилд нь цагдаагийн байгууллага хөндлөнгөөс оролцон саад хийх, сүрдүүлэх явлууд ч гардаг байна. Иймд тийнхүү саад хийж буй явдлыг буруушаах бусад ТББ-уудтай нэгдэн ажилладаг.

Page 140

The eyes and ears of human rights:

Хүний Эрхийн Нүд ба Чих: Хүний эрхийн нөлөөллийн ажилд дүрс бичлэг ашиглах эрхийг ТББ-уудад олгох нь.

ГЭРЧ /WITNESS/ байгууллага нь дэлхий дахины хүний эрхийн байгууллагуудыг өөрсдийн ажилдаа дүрс бичлэгийг нөлөөллийн хэрэгсэл болгон бүрдүүлэхэд тусладаг юм. Хувь хүний гэрчлэлийн хүч чадал, зураг дүрс бол мянган үгнээс үнэтэй хэмээх зарчимд үндэслэсэн WITNESS-ийн ба түүний хамтрагчдын дүрс бичлэгүүд нь нотлох баримт болж; хүний эрхийн зөрчлүүдийн заргуудыг баримтаар нотлоход; улс орны хүний эрхийн байдлыг харуулсан албан ёсны дүгнэлт болох, олон улсын ба бүс нутгийн байгууллагуудад илгээх бичмэл тайлангуудтай сөрөгцүүлэн дагалдуулахад; жирийн иргэдийн боловсрол болон идэвхийг өдөөхөд; мэдээллийн хэрэгслэлүүдээр мэдээлэл түгээхэд; интернэтээр дамжуулан хүний эрхийг дэмжихэд; болон дэлхий даяар телевизээр цацах баримтат кино бүтээхэд ашиглагдаж ирлээ.

1992 онд байгуулагдан New York хотод төвлөж буй WITNESS байгууллага нь Төв Америкийн гудамжны хүүхдийн талаархи “нийгмийн цэвэрлэгээ”-ээс эхлэн Сьерра Леоны иргэний дайны үеэр бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүд, АНУ-дахь ажилчдын хөдөлмөрийг завшигч үйлдвэрүүд, Бирмын орон нутгаасаа зайлуулагдсан хүмүүс гээд олон янзын асуудлаар 50 орны 150 гаруй байгууллагатай хамтын ажиллагааг бий болгожээ.

WITNESS нь дүрс бичлэгийг үр дүнтэй ашиглах урт хугацааны чадавхийг бий болгохоор зорьдог, дүрс бичлэгийн амжилт уналтын тэнцвэрийг хадгалж чадахуйц тусгай кампанит ажлыг явуулах боломжуудыг эрэлхийлж байдаг хамтрагчдыг сонгодог. Хамтрагчтай болмогц WITNESS дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийн болон сургалтын бүлэг байгуулж, дүрс бичлэгийн арга барилын сургалтууд, хүний эрхийн ажилд дүрс бичлэгийн хэрэгслэлийг ашиглах эрчимжүүлсэн заавар өгөх, дүрс бичлэгийн чанарын уялдаат үнэлгээ, яаралтай бүтээлийн туслалцаа, хүчтэй баримтат кино хийх бүтээлч шүүмжлэл зэргийг дараалан зохион байгуулдаг.

WITNESS болон түүний хамтрагчид цуглуулсан бичлэгүүдийнхээ хүрээнд дүрс бичлэгийн нөлөөллийн кампанит ажлуудыг эхлүүлдэг. Тэдгээр нь бичлэгийг нэвтрүүлэх, үзүүлэх тайз индрүүд, бусад байгууллага, сүлжээнүүдийн хамтын ажиллагаа, голлох үзэгчдээс өмнө хүрэх зорилтот үзүүлбэрүүд, үйл ажиллагаанд оролцох үзэгч-хувь хүмүүст хүрэх боломжууд гээд олон хэсгээс бүрддэг. Кампанит ажлууд нь гол шийдвэр гаргагчдын жижиг бүлэгт дүрс бичлэгийг ашиглан нөлөөлөхөөр эс бөгөөс тухайн асуудлын хүрээнд залуусын хөдөлгөөнийг өргөжүүлэхээр чиглэсэн байж ч болох талтай.

Хүний эрхийн мэдээллийн өвөрмөц эх сурвалж болж бүх нийтэд ашиглагдах боломжтой WITNESS-ийн архивт бичлэгүүд хадгалагддаг.

Дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглаж буй хүний эрхийг дэмжигчид нь орон нутгийн байдлаас хамааран хамгаалагдах эсвэл аюулд өртөх боломжтой гэдгийг WITNESS тодорхойлжээ. WITNESS өөрийн ажилтнууд, хамтрагчдынхаа туршлагыг ашиглан өөрсдийн нөхцөл байдалд тохирсон аюулгүй, тохиромжтой бодлогыг бий болгоход нь бусдад тусалдаг. Мөн түүнчлэн дүрс авч байгаа болон дүрсээ авахуулж хүний хоорондын итгэлцлийн чухлыг анхааруулж, дүрс бичлэгийн хэрэгсэлд яриа өгөхийн эрсдлүүд, давуу талуудыг тодорхой тайлбарлаж өгдөг ажээ.

Theater breaks the silence:

Тайзнаас нам гүмийг эвдэж болдог: Хүний эрхийн эмзэг асуудлуудын эргэн тойрон дахь нам гүм байдлыг театрт эвдэж, эрх зүйн боловсрол олгох нь.

Сенегал улсын нэгэн байгууллага газар нутгийн байршлаараа бус соёлын хэм хэмжээгээрээ гадуурхагдсан нийгмийн давхаргуудад хууль ёсны эрхийн талаарх мэдээлэл олгох ажлыг зохион байгуулдаг.

Нэгдмэл Хөгжлийн Африкийн Сан (Rйseau Africain pour le Dйveloppement Integри, or RADI) театрчилсан тоглолтоор эмэгтэйчүүдэд гэр бүлийн хүчирхийллийн тухай боловсрол олгож, тэдэнд тохирсон өөрсдийг нь хамгаалах хуулийн эх сурвалжуудыг таниулах хэлэлцүүлгүүдийг хуулийн мэдлэгтэй хүмүүсээр удирдуулан зохион байгуулдаг. RADI байгууллага театрийг ашиглан Сенегалын хүний эрхийн эмзэг асуудлуудыг тойрсон чимээгүй байдлыг эвдэхийг зорьдог.

Гэр бүлийн хүчирхийлэл, ялангуяа бэлгийн хүчирхийлэл бол Сенегалд бараг дурсахыг цээрлэсэн асуудал бөгөөд эрх баригчдад маш ховорхон мэдээлэгддэг ажээ. Хүн амын 95 хувь нь лалын шүтлэгтэй энэ оронд олонхи хүмүүс гэр бүлийн хүчирхийллийн зарим хэлбэрийг шашны хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн зүйл гэж үздэг. Иймд RADI байгууллага саяхан хийгдсэн эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан хүмүүсийн эрхийн ухамсрыг дээшлүүлэх үр дүнтэй арга зам хайх хэрэгтэй болсон юм. Бичиг үсэг үл мэдэх явдал газар авсан, театруудад мэдэгдэхүйц дахин сэргэлт явагдаж буй зэргээс үүдэн үзэгчдэд хүргэх ур чадварыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн талаар ойлголтыг дээшлүүлэх, бэлэн эх сурвалжуудыг хүмүүст мэдүүлэх зорилгоор RADI театрыг сонгон ажилладаг байна.

RADI-ийн сонгогдсон олны танил жүжигчид үзэгчдийн дундаас эмэгтэйчүүдийг сонгон гэр бүлийн зөрчлийг харуулсан 10 минутын нэмэгдэл үзэгдэлд урьж оролцуулдаг. Тэдгээр эмэгтэйчүүд болон үзэгчдийн зүгээс аяндаа үүсэх үйлдлүүд нь тэдний энэхүү байдалдаа хэдүйн танил дасал болсоныг гэрчлэн харуулдаг. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, түүнийг даван туулах

боломжит арга зам, боломжуудын талаарх хэлэлцүүлгүүдийг хуулийн мэдлэг бүхий хүмүүсээр хөтлөн явуулуулахын тулд эдгээр нэмэлт үзэгдлүүдэд хөндөгдсөн асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр үлдээдэг байна. Хуулийн зөвлөгөө өгөгч мөрдөж байгаа эрх зүйн эх сурвалжууд, хүчирхийлэлд ноогдох ял шийтгэлүүдийн талаар ойлголтыг нь тодорхой болгож өгдөг.

RADI энэхүү тактикаараа соёлын хоёр чухал эх сурвалжийг гаргажээ. Нэгд, театр бол Сенегалд нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, сайн танигдсан заах арга гэдгийг. Хоёрт, эмэгтэйчүүдийн албан бус, уламжлалт уузалтуудын хүрээнд зохион байгуулагдаж буй хөтөлбөрүүд нь бүлгийн хэлэлцүүлгүүдэд маш сайн хандах баталгаа нь болж өгдөг. Театр болон хэлэлцүүлгүүдэд оролцогчдын олонхи нь зөвхөн өөрсдийн эрхийн талаар суралцаад зогсдоггүй олж авсан мэдээллээ гэр бүлийнхэн, найз нөхдөдөө дамжуулдаг байна.

Хүний эрхийг дэмжихийн тулд театрчилсан тоглолтуудыг ашигладаг олон байгууллагууд буй хэдий ч RADI бол хууль, театр хоёрыг хослуулсан ер бусын арга хэрэглэдэгээрээ бусдаасаа өвөрмөц. Үзэгчдийг дагуулж чаддаг RADI-ийн амжилтын шалтгааны нэг тал нь мботтайчуудын дунд оршин буй нийгмийн бүтцийг ашиглаж чаддаг явдал билээ. Театрчилсан байдал нь ийм тоглолтонд цаашдаа дахин оролцохыг нь өдөөдөг төдийгүй хувийн асуудлыг нь сонирхолгүйгээр харилцан яриаг өрнүүлдэгээрээ оролцогчдоо хамгаалах боломж олгодог байна.

Хүний эрхийн тодорхой асуудлуудыг ярихад саад тотгор болдог соёлын ямар уламжлалууд танай улсад байдаг вэ? Тэрхүү саадыг давахад туслах, хүний эрхийн талаар үг дуугүй байх явдлыг зогсоох соёлын ямар уламжлалууд бий вэ?

Хүчирхийллийн хэрэг, тохиолдлуудыг буруушаан өөрсдийгөө илэрхийлэгч эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байна.

Сенегал Улсын Дэд Прокурор

Page 149

Making your point with mapping

Зураглал хийж, үнэлэх нь: Олон нийтийг гэгээрүүлж, бодлогын өөрчлөлтийг хийх шахалт үүсгэхийн тулд үзүүлэнт зураглал хийх нь

Анхаарч буй асуудлын тань үзүүлэнт дүрслэлүүд та бүхний хүрэхийг хичээж буй сонсогчид ямар хүмүүс байхаас үл хамааран маш хүчтэй үр дүнг үзүүлэх болно. Лебаноны Грийнпийс байгууллага Лебаноны эрэг дагуух байгаль орчны эрсдэлтэй байдлуудыг үзүүлэх зураглалыг их үр дүнтэй хэрэглэдэг юм. Лебаноны Грийнпийс байгууллага нь энгийн иргэдэд аж үйлдвэрийн хорт хог хаягдлын асуудлын талаар ойлгуулах, асуудлыг засаж залруулах бодлого боловсруулах талаар засгийн газартаа дарамт шахалт үзүүлэхийн тулд тус орны далайн эргийн дагуух газар нутгийн байгаль орчны сүйрэл зөрчлийн зураглалыг гаргажээ.

Эргийн хамгийн их хүн төвлөрсөн болон ихээр ашиглагдсан газруудад хүчээ төвлөрүүлэн долоо хоног бүр хийлдэг завиар эрэг дагуу нэг шинэ газар аялах замаар тус байгууллага нь далайн эрэг дагуух газар нутгийн байгалийн нөхцөл байдлын талаар олон нийтийн сонирхлыг маш ихээр хөндөж чадсан. Ингэхдээ очсон газар бүртээ Газар Зүйн мэдээллийн системийг ашиглан үзлэг шалгалтын үр дүнгийн зураглалыг гаргаж, байгаль орчны хамгийн хүнд асуудлуудыг тодруулан гаргадаг юм. Шалгалтын явцад олон нийт Грийнпийсийн аялалын үр дүнг түүний зураглал/газрын зураг нийтлэгдсэн TV, сонин, тус байгууллагын цахим хуудаснаас төдийгүй тухайн газар дээрээс нь мэдэж авдаг .

Долоо хоног тутмын аялал нь олон нийтийн сонирхлыг маш ихээр татаад зогсохгүй бүр дараагийн газраасаа тэд юу олох бол? гэх хүмүүсийн гайхшийг төрүүлсэн хүлээлтийг бий болгодог аж. Кампанит ажлын төгсгөлөөр тэрхүү зураглал нь өөрөө хортой бүс газрын болон бүхий л эргийн дагуух байгаль орчны асуудлын хэр хэмжээг харуулсан графикт үзүүлэн болдог юм. Грийнпийс зураглал хийх төсөлтэйгээ хослуулан хэд хэдэн өөр тактикуудыг бас хэрэглэжээ. Гишүүд нь улс төрчид, засгийн газрын албад, оршин суугчид, эрэг хавийн бизнес эрхлэгчдийг лоббиддог. Орон тооны нэг ажилтан нь хэвлэл мэдээллийнхэн сонирхож, мэдээлсэн байх, нийтлэл нэвтрүүлгүүд нь цагтаа цацагдсан эсэх, олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн эсэхийг нягтлах үүрэгтэй ажиллана.

Тус байгууллага мөн бохирдлын удаан хугацааны үр нөлөөг харуулсан радио сурталчилгаа, баримтат нэвтрүүлгүүд, зөөврийн маш том зурагт хуудсууд, телевизийн дүрст сурталчилгаануудаараа олны анхаарлыг татдаг. Уг кампанит ажлаар хийгдсэн олон нийтийг гэгээрүүлэх ажил нь мэдээлэл авах эрхийг багтаасан байгаль орчны 444-р хууль батлагдан гарахад тус болсон юм.

Лебаноны Грийнпийс энэхүү ажилдаа олны анхаарлыг татан, тэдний ашиг сонирхлыг хөндөнгөө хуурай, техникжсэн мэдээллийг нийгмийн гишүүн бүрт ойлгогдохуйц баримтууд бүхий тулган шаардах зураг болгон хувиргаж, асуудлыг засан сайжруулах арга хэмжээ авахад хүргэж чадсан билээ.

Байгаль орчны зөрчлийн асуудал нь хүмүүс уг зөрчлийг олж мэдэхийн аргагүй маш их нуугдмал байдалд орсон байдаг. Ийм асуудлыг илчлэн гаргаж ирсэнээрээ Грийнпийс үүний эсрэг ажиллах шинэ дэмжигчдийн хүрээг бий болгожээ. Хүмүүсийн мэдлэг дээшилсэн, мөн шинэ хуулийг гаргасан зэрэг амжилтын гол түлхүүр нь маш шаргуу аялал, зураглал хийх оролдлогыг тод харуулсан хэвлэлийн мэдээллүүд, байгууллагын хувьд бас тодорхой бодлогын өөрчлөлтийн төлөө лобби хийсэн явдал байсан билээ.

“Зураг бол олон мянган үгнээс хавьгүй илүү үнэтэй юм.” Өөрсдийн шалтгааныг дэвшүүлэн гаргахын тулд та бүхэн зураг дүрсийг хэрхэн ашиглаж болох вэ?

Page 150

Understanding how we got here and where we are going:

Энд хэрхэн хүрсэнээ болоод хаашаа явж буйгаа ойлгох нь: Түүхт газар, хувь хүний домгийн талаар сэтгэл хөдлөлийн хүчийг ашиглан хүний эрхийн одоогийн асуудлуудын талаарх ойлголтыг дээшлүүлэх нь

Амьдарлаас хол, хөндий хүний эрхийн асуудлуудыг илт харагдахуйц болгоход түүх домгууд тус болдог. Нью Йорк хотын Тэнэмэнтийн Музей нь өнөөгийн хөдөлмөрийн эрхийн асуудлаар мэдлэг, хэлэлцүүлгийг бий болгохын тулд өнгөрсөн үеийн түүх ашигладаг.

1897 оны хувцас загварын дэлгүүрийн байшинг дахин засварлан байгуулагдсан Лоүэр Ийст Сайд Тэнэмэнт Музей нь хөлсний хөдөлмөр ашигладаг өнөөгийн үйлдвэрүүдийн асуудлуудад анхааран хэн, юу хийх хэрэгтэйг хэлэлцүүлэхээр хувцасны үйлдвэрийн хоорондоо зөрөлдөөнтэй талуудын төлөөлөгчдийг авчирдаг ажээ. Тэнэмэнт Музей нь 1863-1935 оны хооронд 20 улс үндэсний 7,000 гаруй цагаачид амьдарч байсан Орчардын гудамжин дахь барилгуудыг 1997 онд сэргээн засварласан бөгөөд Америкад тэдний туулсан тэмцлийн түүхийг өгүүлдэг. Польшоос ирсэн цагаач Харрис, Жэнни Лэвайн нар 1897 онд өөрсдийн байрандаа хувцас загварын үйлдвэр, худалдаа нээн ажиллуулснаар “хөлсний хөдөлмөр ашигладаг үйлдвэр” гэх нэр

томъёог анхлан тодорхойлсон орон зайг бий болгосон юм. Өнөөдөр, АНУ-д ойролцоогоор 15,000 цагаач ажилчид бүхий 400 гаруй хувцас загварын үйлдвэр, худалдаа бий. Тэдний дөрөвний гурвыг нь АНУ-ын Хөдөлмөрийн Яам “хөлсний үйлдвэрүүд” хэмээх ангилалд багтаасан боловч хөлсний үйлдвэр гэж юуг хэлэх вэ, хөдөлмөрийн эрхийн зөрчлийг арилгахын тулд юу хийх хэрэгтэй, хэн хариуцлага хүлээх ёстой зэрэг мэтгэлцээн ширүүн өрнөсөөр л буй билээ.

Тус музей Лэвайнхны гэрийг хувцас үйлдвэрлэлийн хүмүүс асуудлаа хэрхэн шийдвэрлэх талаар санаагаа солилцдог төв болгон өөрчилсөн юм. 2002 онд болсон анхны уулзалтандаа Human Rights Watch буюу Хүний Эрхийн Сэрэмж ТББ, UNITE! буюу нь хувцасны үйлдвэрийн ажилчдын холбоо, Levi's, Eileen Fisher зэрэг хувцас загварын брэндүүд, King's County Manufacturers Association болон өөр олон байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн холимог оролцогчдыг урьжээ. Ихэнхдээ хувцас загварын үйлдвэрлэлийн хувьд эсрэг тэсрэг хэмээн тооцогддог салбаруудын эдгээр удирдагчид энэ удаа бие биетэйгээ ихэд ойр байж, тэдгээр цагаач ажилчид давчуухан 325 дөрвөлжин фүүт зайд хэрхэн хэдэн зуун хувцасыг янзалж, идэж ууж, унтаж амарч, гэр бүл үр хүүхдээ өсгөн өндийлгөж байсан түүхүүдээс сонсоцгоосон юм.

Энэ уулзалттай хамтатган тус байгууллага хувцасны үйлдвэрлэлийн өнгөрсөн түүхийг эргэн харж, ололт амжилтанд хүргэх шинэ хэтийн төлвийн тухай бүтэн өдрийн хурал зохион байгуулж, үйлдвэрийн нөхцлийг цаашид сэрэмжлүүлэх шинэ санаануудыг санал болгожээ.

2002 онд болсон анхны уулзалтаас хойш тус музей хувцас үйлдвэрлэлийн хэдэн арван байгууллагатай хамтран иймэрхүү яриа хэлэлцээрүүдийг зохион байгуулаад байна.

Хүмүүс хувийн үйлдлээсээ нийгмийн томоохон асуудал руу чиглэх тул сөрөг үзэл бодлуудад хүлээцтэй хандан сонсох, томоохон чуулга уулзалтын зэрэгцээ жижиг бүлгээр үзэл бодлоо солилцох боломжтой байх хэрэгтэй бөгөөд үүний тулд сайн чиглүүлэгчтэй байж, яриа мэтгэлцээнийг болгоомжтой хөтлөх нь маш чухал.

“Бусад үед хамт байхаас татгалздаг байсан эдгээр хүмүүс музейд уулзаж, ярилцахыг зөвшөөрцгөөсөн. Бидний хувьд өнгөрснийг тайлбарлан ганц түүх хэлээд өнгөрөх бус харин олон жижиг хэтийн төлвөөс хэлэлцүүлэх асуултуудыг ургуулах болно гэдгийг чухалчилж байлаа. Ер нь оролцогчид түүхийн музейд хамтдаа байхдаа өөр газарт эдэлж байгаагүй тийм аятайхан байдлыг мэдэрсэн гэдгийг бидэнд хэлж байсан. Нэгэн оролцогчийн сэтгэгдэлд

“Эндэх орчин нь хэлэлцүүлгийг өөрийн эрхгүй эхлүүлмээр байдал руу хүн бүрийг бага зэрэг туйлшруулан хөтөлж байв. Энэ бол бүх асуудлыг хамтдаа харах гайхамшигтай бололцоо байлаа” гэжээ.

—Лиз Сэвченко, АНУ-ын Лоүэр Ийст Сайд Тэнэмэнт Музей.

АРГА ХЭРЭГСЭЛ, НӨӨЦ БОЛОМЖ

Энэ номонд дурдагдсан хувь хүмүүс, байгууллагууд хүч чадал, учрах эрсдлүүдээ тооцоолон өөрсдийн өвөрмөц нөхцөл байдалд тургуурласан тактикуудыг сонгож, тэдгээрийг сайтар тодорхойлсон зорилгодоо хүрэх томоохон стратегийн бүрэлдэхүүн болгон ашиглаж буй билээ. Зарим нэгэн тактикууд, эсвэл тэдгээрийн зарим тал нь та бүхэнд хэрэгтэй байж болох ч өөрийн үндсэн санаа, зорилго, нөөц боломж, холбоотон дэмжигчид гээд нөхцөл байдлаа эхлээд үнэлэх нь чухал. Номын энэхүү хэсэгт оруулсан арга хэрэгслүүд энэ зорилгын дагуу танд тус болно гэдэгт бид найдаж байна.

Бүтээлч стратеги, тактикуудыг хөгжүүлэх нь

Энэхүү хэсгийг өөрийн зорилго, зорилтот бүлгүүдийг тодорхойлох, боломжит стратеги, тактикуудыг бодож олоход ашиглаарай. Мөн үүнийг байгууллагынхаа хүмүүстэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд болон өөрийн хувийн санаагаа цэгцлэхэд ашиглана уу.

Тактикаа хуваалцах: Тактикийн загвар танилцуулга

Өөрийн сайн мэдэх тактикийн загвар танилцуулгыг ашиглан бусдад тактикийн сургалт явуулаарай. Хүний Эрхийн Шинэ Тактик Төслийн нэгэн чухал зорилт бол нэг нэгэндээ өөрсдийн тактикийг танилцуулан хуваалцдаг хүний эрхийн ажилтнуудын сүлжээнүүдийг байгуулах явдал юм. Та бүхнийг ийнхүү ажиллахад энэхүү ном урам өгнө гэдэгт бид найдаж байна.

Тактикуудыг өөртөө тохируулах

Тодорхой нэгэн тактик эсвэл тактикийн аль нэг тал зорилгуудыг чинь хөгжүүлэхэд хэрэг болох вэ гэдгийг шийдвэрлэхийн тулд энэ хэсэгт буй асуултуудыг ашиглаарай. Гагцхүү нөхцөл байдал бүрт бүх тактик тохирох албагүй гэдгийг санах хэрэгтэй.

Өөртөө анхаарах: Өөрийн хамгийн үнэт нөөц, боломжоо анхаарах

Та өөрийн хөрөнгө санхүү, үүрэг хариуцлагыг нягтлан шалгаж байхдаа өөрийгөө болон хамт олноо хамгийн үнэт нөөцөд тооцож санаж байх нь чухал. Өөрийнхөө тухай болоод бусдынхаа талаар анхаарч болох арга замуудыг

эргэцүүлэхийн тулд өөрөө ганцаараа болон хамт олноороо дараах хуудсуудыг ашиглаарай.

Page 156-160

Бүтээлч стратеги, тактикуудыг хөгжүүлэх нь

DEVELOPING CREATIVE STRATEGIES AND TACTICS

Тактикгүй стратеги бол ялалтанд хүргэх хамгийн удаан зам. Харин стратегигүй тактикууд нь ялагдлын урьтал шуугиан юм. — Сүн Цу

2000 гаруй жилийн өмнө бичигдсэн Сүн Цугийн өгүүлэл өнөөгийн бидэнд үйл ажиллагаагүй төлөвлөлт оргүй хоосон зүйл, төлөвлөгөөгүй үйл ажиллагаа сүйрэл гэдгийг хэлж өгч байна.

Өнөөдөр бид олон жилийн өмнө Сүн Цугийн тодорхойлсон амжилтын суурийг хэрхэн тавих талаар шинжилгээний гурван хүрээнээс суралцана.

Өөрийгөө тань

Өөрийн бодолдоо бүү итгэ. Өөрийн хүч чадал, сул тал, нөөц боломж, чадавхи, дэмжлэгийг бодитойгоор харах ёстой. Өөрийн холбоотнуудын чадавхи, хязгаарлагдмал байдлын талаар тодорхой ойлголттой байх нь мөн адил чухал.

Сөрөг талаа тань

Сөрөг талынхаа ухуулгад ч бүү авт. Хүний эрхийн талаарх танай асуудлыг урагшлуулахад цагаа олсон, бүр зайлшгүй чухал байж болох эрч хүч, санаачлагуудыг нь булаан авахын тулд сөрөг хүчнийхээ хүч чадал, сул тал, нөөц боломж, чадавхийг ойлгох нь мөн л маш чухал. Сүн Цу өрсөлдөгчийнхөө стратегийг ойлгоход болон нураахад онцгой анхаарахыг зөвлөдөг.

Орчноо тань

Орчин бол сөрөг талтайгаа уулзах жинхэнэ газар чинь байж болох юм. Үүнд мөн цаг хугацаа, орон зай, болон хууль, нийгэм, соёлын нөхцөл байдлууд, таны ажиллагаа явагдах орчин зэрэг багтаж болно.

Эдгээр хүрээнд дүн шинжилгээ хийх мэдээллүүдийг цуглуулсан л бол та одоо өөрийн стратегийг хөгжүүлэхэд бэлэн байна гэсэн үг. Стратеги бол:

- гол зорилтууд ба тохирох зорилтот бүлгүүд
- дэмжигчид ба нөөц боломжууд

- ямар тактикийг хэзээ хэрэглэх

зэргээс бүрдсэн байж болох олон шийдвэрүүд, мэдээлэл цуглуулах ажил, зорилго руу чиглэсэн үйл ажиллагаа юм.

Харин тактик бол өгөгдсөн нөхцөл байдалд нөлөөлөхөөр хийгдэж буй тусгай үйл ажиллагаа юм. Таны тактикууд томоохон стратегийн нэгэн хэсэг нь бөгөөд түүнд тохирохуйц байх нь чухал.

ЭХЛЭХДЭЭ:

Эхлэхдээ санаж байх чухал зүйлс:

Бусадтай хамтран ажилла

Аль болох алсын хараа, түүх намтар, амьдралын туршлагаараа өөр өөр хүмүүсийг хамтад нь нэг бүлэг болгохыг хичээгээрэй. Энэ нь зөвхөн бүлгийн чинь буй болгох санаануудыг баяжуулаад зогсохгүй мөн улам олон хүн, бүлгүүд өөрсдийн санааг хуваалцаж, бие биенээсээ суралцахад дэм болно.

Эхлэхийн өмнө хэлэлцүүлгийн үндсэн дүрмийг зөвшилц. Үүнд:

- Бие биенээ хүндлэх
- Тухайн цагт нэг л хүн ярих /Зэрэгцэж ярихгүй байх /
- Хэрэв хоёр хүн яримаар байгаа бол огт яриагүй байгаад нь түрүүлж ярих боломж олгох
- Бүх санааг сонсох
- Хүндлэлгүй, бүдүүлэг саналуудыг хүлээн зөвшөөрөхгүй ба тэдгээрийг хүндэтгэлтэй боловч хатуу чанд байдлаар дахин чиглүүлэх ёстой.
- Санаануудыг эерэг, бүтээлч байдлаар үнэлж дүгнэх гэх мэт.

Хэрэв бүлгийн хэн нэгэн гишүүн хэлэлцүүлэгт давамгайлж эхэлвэл тухайн бүлгийн ажилд хөндлөнгөөс оролцох боломжийн арга замыг та олох ёстой.

Бодол санаагаа чөлөөтэй уралдуулах

Аль болох олон санааг олж, нээлттэй хэлэлцүүлэх. Хүн бүрийг өөрийн санаагаа нэмэрлэхэд дэмжиж, аливаа хэрэгжүүлэхэд хэцүү, эсвэл илүү амархан, аль эсвэл этгээд санаануудыг бүү няцаа. Онцгой л биш бол бүх санаанууд хүчирхийллийн бус байх ёстой. Хүчирхийллийн бус санаанууд бол хууль ёс, итгэлтэй байдлын тулгуур юм.

Гарч байгаа санаа бүрийг жагсаан бич. Дараагийн хэлэлцүүлэгт зарим нь сонгогдох, сонгогдохгүй алин байсан ч тэдний нэгийг ч орхилгүй бичих нь зүйтэй. Зарим нэгэн санаа эхэндээ этгээд хачин, эгдүүцмээр санагддаг ч дахин харахад гэнэтийн сонин хэрэгтэй зүйл байдаг. Дараа нь та илүү гүн гүнзгий дүн шинжилгээ хийх хэрэгтэй ч эхний зорилго бол аль болох олон санааг төрүүлэх явдал билээ.

Үйл явцыг баримтжуулах

Бүлэгт нийтэд нь үйл явц нээлттэй байж, даган ажиллаж болохуйцаар санаануудыг том цаасан дээр юмуу эсвэл самбар дээр бичнэ. Үйл явцыг баримтжуулах нь санамжийг бий болгож, туршлагаудыг өөр үед эсвэл өөр хүмүүстэй хуваалцах мэтээр буцаан ашиглах боломжийг бүрдүүлдэг. Гэхдээ үйл явцынхаа бичмэл тайланг хадгалахад учрах эрсдэлүүдээ үнэлээрэй.

Нэг дэх алхам: Асуудлаа тодорхойлох

- Анхаарал хандуулвал зохих ямар асуудал байна вэ?
- Үүнийг бага багаар магадлахын тулд асуудлын гол элементүүдээс жагсаан бичнэ. Томоохон асуудлыг алхам алхмаар шийдвэрлэхийн тулд та эдгээр жижиг хэсгүүдийг тус тусад нь гарцаагүй авч үзнэ.
- Уг асуудал тодорхой зан төлөв, институци, бодлого, хууль эс бөгөөс хувь хүнд хамааралтай байна уу?
- Асуудлыг товчхон ганц өгүүлбэрээр илэрхийл.

Хоёр дахь алхам: Зорилтот бүлгүүдээ тодорхойлох

Таны зорилтот бүлэг буюу нөлөөлөхийг хүсэж буй хүн, газар орон, юмс.

- Тодорхойлоод буй асуудалд тань хэн, юу гол үүргийг гүйцэтгэдэг вэ?
- Асуудлыг удаашруулж байгаа бодлого, хууль журам, дадлага байна уу?
- Уг асуудалд анхаарлаа хандуулах үүрэг бүхий байгууллагууд бий юу? Хэрэв бий бол яагаад тэд үүнийг анхаарахгүй байна вэ?
- Бүлгийнхээ нөлөөлөхийг хүсэж буй нэгээс хоёр гол хүн, зорилтот бүлгийг тодорхойл.

Гурав дахь алхам: Зорилгоо тодорхойл

- Уг асуудалд та бүхэн ямар цохилт үзүүлэхийг хүсэж байна вэ?

- Өөрсдийн оролдлогоос хүсэж буй үр дүнгээ товчхон тодорхойл. Хэрэв та бүхэнд бүх зүйлсийг үнэн болгох эрх мэдэл байсан бол тэр нь юу байх байсан бол гэдгийг эргэцүүл. Дэндүү агуу байхаас бүү санаа зов. Энэ бол бүлгийн үйл явцын ашиг тус. Бүлэг бүрт нэг нь нөгөөгөө тэнцвэржүүлэхээр өөдрөг, гутранги үзэлтнүүд болоод реалистууд байдаг.
- Дэвшүүлсэн зорилгод тань хүргэхэд гол тодорхойлсон гол хүмүүс, зорилтот бүлгүүд танд хэрхэн тусалж чадах вэ?

Тэмдэглэгээ: Энэ зорилго бол танай байгууллагын эрхэм зорилгоос өөр байж болох ч сонгосон стратеги, тактикууд эрхэм зорилготой чинь хамааралтай буй эсэхийг няглахын тулд түүнийг санаж байх нь тустай.

Дөрөв дэх алхам: Холбоотнууд ба сэргөлдөгч талуудаа тодорхойлох

- Зорилго, зорилтот бүлгүүдээ санаандаа хадгал.
- Өөрийн оронд тань болон олон улсын хэмжээнд хэн таны холбоотнууд болон боломжит холбоотнууд байж болох вэ? — хувь хүмүүс, байгууллагууд, интституциуд. Яагаад тэд та бүхний зүтгэлийг дэмждэг бөгөөд дэмжих сонирхолтой байаг вэ?
- Хэн танай одоогийн идэвхгүй холбоотнууд бөгөөд идэвхгүй эсэргүүцэгчид вэ? Ихэнхи хүмүүс эдгээр ангилалд хуваагддаг.
- Хүмүүсийн ийм бүлгүүдэд нөлөөлөх арга замуудыг олох нь өөрийн тактикийг сонгоход чухал хэрэг болно.

Тав дахь алхам: Нөөц боломжоо тодорхойлох

- Нөөц боломж бол зорилгод хүрэхэд тусалдаг, бэлэн буй аливаа зүйлс юм.
- Танд ямар тодорхой нөөц боломжууд бэлэн байгаа вэ? Хүмүүс, бусад байгууллагууд, сүлжээ, санхүү, нийгэм, улс төрийн болоод эрх зүйн нөхцөл байдлуудын талаар бодож үз.
- Урьдчилан тодорхойлсноор, анхаарлаа хандуулж буй асуудалд гол үүрэг бүхий хүмүүстэй та болоод таны сэргөлдөгч талынхан ямар холбоотой вэ? Эдгээр нь мөн л нөөц боломжууд мөн юм.
- Өөртөө хэрхэн анхаардаг бөгөөд анхаарах гэж буйгаа эргэцүүл.

Зургаа дахь алхам: Стратегиа тодорхойлох

Стратегийг тодорхойлоход маш олон шийдвэр гаргах шаардлагатай болдог. Дээр дурдсан шатуудыг гүйцээснээр та стратегитай шийдвэрүүд гаргахад хэрэг болох үнэтэй мэдээллийг олж авна.

- Танай бүлэгт өмнөх шатны арга хэмжээнүүдээс ямар хүрээнд цохилт өгөх бололцоо хамгийн их байна вэ гэдгийг тунгаа.
- Зорилгоо санангаа, тэдгээр хүрээний жагсаалтыг гаргана.
- Зорилтот бүлгүүдэд өгөх цохилтуудыг хамгийн ихээр нэмэгдүүлэх ямар алхмууд хэрэгтэй байна вэ?
- Эдгээр алхмуудыг хэрэгжүүлэх тусгай дараалал байна уу? Тэдгээр дарааллаас гадна бусад оролдлогуудтай зохицуулах шаардлага байна уу? Танд зайлшгүй шаардлагатай нөөц сурвалжууд байгаа юу?
- Өөрсдийн үйл ажиллагааны арга зам болон энэхүү үйл ажиллагаа зорилгод чинь хэр ойртуулж туслах вэ гэдгийг хэлэлц. Стратеги бол зорилгод хурдан хүргэх бус харин та нарыг үйл ажиллагааны өөр түвшинд аваачих зүйл гэдгийг санах хэрэгтэй. Энэхүү үйл ажиллагааны арга зам бол та нарыг огт өөр чиглэл рүү аваачихгүй бөгөөд та нарын ерөнхий зорилгод тохирно гэдэгт итгэлтэй бай.

Долоо дахь алхам: Тактикаа тодорхойлох

Одоо бол тодорхойлсон стратегиа хэрэгжүүлэхэд ашиглах тактикуудаа шийдвэрлэх цаг. Тактикуудаа сонгохдоо та нарын чадавхи болоод тэргүүн зэргийн ач холбогдол нь юу вэ гэдгийг эргэцүүлээрэй. Асуудалд гол үүрэг бүхий хүмүүс, дэмжигчид, холбоотнууд, эсэргүүцэгчидийн зэрэгцээ өөрийн сөрөг хүчний хүч чадал, сул тал болон нөөц боломжуудыг дахин үнэлж үз.

- Өөрсдийн мэддэг бөгөөд хүлээн зөвшөөрөх тактикуудыг бүртгэ
- Ямар тактикууд идэвхгүй холбоотнуудыг идэвхтэй болгож болох вэ?
- Ямар тактикууд идэвхгүй эсэргүүцэгчдийг идэвхгүй хэвээр байлгах эс бөгөөс тэднийг холбоотон болгож болох вэ?
- Ямар тактикууд сэргэлдэгчдийг зөөлрүүлж болох вэ?
- Танай бүлэг үүнийг ганцаар хийж чадах уу, эсвэл бусад бүлгүүдтэй хамтрах шаардлагатай юу?

- Зорилго, стратегитаа тохирсон дараагийн хэлэлцүүлгийг явуулах нэг тактикийг сонго.

Тактик бүр илүү нарийн хэлэлцүүлэг, хэрэгжүүлэх олон үе шатууд, бүр нэмэлт тактикуудыг ч шаарддаг.

Найм дах алхам: Тактикийг үнэлэх нь

- Яагаад энэ тактикийг сонгосноо хэлэлц. Энэ нь одоо байгаа нөхцөлд та нарыг зорилго руу тань хөдөлгөх хамгийн сайн бололцоотой тактик мөн үү?
- Энэ тактик та бүхний нөхцөл байдалд тохирсон хамгийн мундаг хүч болж чадах уу? Та нарын нөөц боломжийг хамгийн сайнаар ашиглаж чадах уу?
- Нэмэлт нөөц боломжуудыг та нар хэрхэн бий болгох вэ? Өөр хэнтэй хамтран ажиллаж болох вэ? Бусдыг хамтран ажиллах талаар ба нөөц боломжоор хувь нэмэр болох талаар итгүүлэхэд ямар тактикууд хэрэгтэй вэ?
- Сонгосон тактикаа хэрэгжүүлэхэд туслах өөр ямар тактикуудыг ашиглах хэрэгтэй байна вэ? Эцсийн зорилтот бүлэгт хүрэхийн өмнө хандах ёстой урьдчилсан зорилтот бүлэг байна уу? (тухайлбал: дарга нь бодлогын өөрчлөлт хийхээс өмнө байгууллагын доторхи бусад холбоотнуудыг олж авахыг яаравчлах)
- Тактикаа хэрэгжүүлж эхлэхээс өмнө бусад байгууллагуудын дэмжлэгийг олох хэрэгцээ байна уу?
- Тактикийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай алхмуудыг чадах хэмжээгээрээ олныг дүрслэх. Өөрт буй нөөц боломжийг үнэлгээг үргэлжлүүл.

Ес дэх алхам: Энэ гарын авлагаас тактикуудыг тохируулах

Тактикуудыг хэрхэн тохируулан хэрэглэх талаар илүү санамж болохуйц
Тохируулах Тактикуудыг санал болгох

- Өөрсдийн судалмаар тактикуудыг жишээ болгон сонго.

- Уг жишээ тактик, танай нөхцөл байдлын хооронд адил төстэй ямар зүйлс байна вэ? Ямар ялгаа байна вэ? Бусад байгууллагын туршлагаас суралцмаар ямар зүйлс байна вэ?
- Энэ гарын авлагад дурьдагдсан жишээ тактикт байхгүй өөр ямар эх сурвалж та нарт байна вэ? Уг тактикийг илүү үр дүнтэй болгохын тулд эдгээр эх сурвалжийг хэрхэн ашиглаж болох вэ?
- Өөр ямар саад бэрхшээлүүд та нарт тулгардаг вэ?
- Уг тактикийг өөрийн нөхцөлд тааруулан хэрхэн хэрэглэж болох вэ?
- Өөр ямар мэдээлэл шаардлагатай бөгөөд хэн түүнийг олж авах вэ?
- Та бүхнийг зорилгодоо хүрэхэд туслах шинэ санаануудыг бий болгох, стратеги тактикуудаа бодитойгоор төлөвлөж, үнэлэхэд тань тус дөхөм болох дүн шинжилгээний хамгийн сайн чадваруудыг хөгжүүлдэг сургалтын сайн үндэс суурь болох байдлаар энэхүү үйл явц танай байгууллагад үйлчилнэ.

Page 161

ADAPTING TACTICS

ТОХИРУУЛАХ ТАКТИКУУД

Энэхүү гарын авлагад дурдагдсан тактикууд бол ажил хэргээ явуулах шинэ арга барилын тухай эргэцүүлэхэд тань тус болох арга хэрэгслүүд билээ. Мөн бид та бүхнийг өөрийн нөхцөлдөө шилжүүлэн хэрэглэж болох тактикуудыг эндээс олж мэднэ гэдэгт найдаж байна.

Шилжүүлж болмоор тактикууд гэсний учир нь тэдгээрийг зөвхөн санаачилсан тухайн оронд төдийгүй бусад орны нөхцөлд ч тохируулан ашиглаж болно гэж үзсэнд оршино. Гэхдээ энэ нь уг номноос юмуу өөр хаа нэгтэйгээс авсан тактикаа анхлан яаж хэрэглэгдэж байсан яг тэр байдлаар нь ашиглахыг хичээх хэрэгтэй, эсвэл ашиглаж болно гэсэн үг биш. Өөрийн нөхцөл байдал, нөөц боломжуудаа дүгнэж, учрах эрсдэлүүдээ үнэлэх хэрэгтэй. Нэг тактикийг нөгөөтэй нь хослуулах, эсвэл өөрийн нөхцөлдөө тохирох тактикийг бүхлээр нь бус түүний зарим нэг хэсгийг нь ашиглах хэрэгтэй байж болох юм.

Доорх асуулт шинэ тактикийг үнэлэх, нөхцөл байдалдаа тааруулахад тань тусална.

Энэ тактик миний асуудал, нөхцөл байдалд тохирч байна уу?

Би үүнийг өөр хэнтэй хэлэлцэж болох вэ?

Энэ тухай өөр бусад ямар байгууллагуудад би хэлэх хэрэгтэй вэ?

Урьд өмнө ийм тактик хэрэглэгдэж байсаныг би ер нь мэдэх билүү?

Тэр нь амжилттай байж чадсан уу?

Яагаад амжилтанд хүрсэн эсвэл амжилтгүй болсон?

Зорилгондоо хүрэхэд энэ тактик надад хэрхэн туслах вэ?

Миний зорилтот бүлэг рүү чиглэсэн нөлөөлөл үүнд байна уу?

Миний зорилтот бүлэгт энэхүү тактик нь өмнө нь хэрэглэгдэж байв уу?

Надад ямар нөөц сурвалжууд хэрэг болох вэ?

Ямар нөөц сурвалжууд надад байгаа вэ?

Би өөртөө байхгүй нөөц сурвалжуудыг хэрхэн олж авах вэ?

Энэ тактикийн талаар илүү мэдээллийг олж авахын тулд хэнтэй ярилцах вэ?

Энэ тактикийг хэрэглэхэд хэнийг холбоотнуудаа болгох хэрэгтэй вэ?

Би тэднийг хэрхэн холбоотноо болгох вэ?

Асуудлыг маань эсэргүүцдэг хүмүүс энэхүү тактикт хэрхэн хариу үйлдэл үзүүлж болох вэ?

Энэ тактик надад болон манай байгууллагад хэр эрсдэлтэй байх бол?

Энэ тактикаас урган гарах эрсдэлийн шатыг хүлээн авахад би бэлтгэгдсэн үү?

Уг тактикийг ашиглахад учрах эрсдэлүүдийг би хэрхэн бууруулж чадах вэ?

Энэ тактикийн зарим хэсгийг би ашиглаж болох уу?

Бусад тактиктэй хослуулан хэрэглэж болох уу?

Миний туслах төлөвлөгөө юу вэ?

Хэрэв энэ тактик миний хүлээж байсан байдлаар хийгдэхгүй бол би яах вэ?

Additional resources: Нэмэлт эх сурвалжууд

Working with the Media

Хэвлэл Мэдээлэлтэй ажиллах

Хэрэв та болон танай байгууллага хэвлэл мэдээлэлтэй харьцах туршлага багатай эсвэл түүнтэй харьцах ажилтнуудын цаг бага байдаг бол өөрсдийн санааг сонин хэвлэлд өгөх нь сүрдмээр хэцүү зүйл байх болно. Иймд хэвлэл мэдээлэлтэй харьцахад тань хэрэг болох зарим нэг маш энгийн санамжуудыг энд хүргэж байна.

Санаагаа шинэ мэдээ болго

Хэвлэлийн мэдээлэл илгээх, сурвалжлагчтай холбогдохдоо хэвлэл мэдээллийнхний анхаарлыг татах үйл явдлуудын тухай бодоорой. Мэдээний үйл явдалд “дэгээ” хэрэгтэй байдаг. Тэдгээрийн заримаас дурдвал:

- Хүмүүнлэг ашиг сонирхол: бодит хүний үйл явдал
- Хандлагууд: олон нийтийн үзэл бодол, зан төлөвт гарч буй өөрчлөлтүүд
- Цаг хугацааны дэгээнүүд: Үйл явдлаа баяр ёслол, амралтын өдрүүд эсвэл жилийн тодорхой цаг үеүдтэй холбох
- Тэмдэглэлт өдрүүд, ой, түүхэн үйл явдлууд
- Онцгой үйл явдлууд
- Хамгийн сүүлийн үеийн үйл явдал, мэдээнд зориулсан хариултууд
- Нэр алдарт хүмүүс
- Санаандгүй холбоотнууд: тухайн асуудлаар санаа нийлсэн гэнэтийн бүлгүүд
- Сөрөг үзэл бодол

Өөрийн өгүүлэх үйл явдлыг аливаа томоохон асуудлын нэг хэсэг, олон тооны хүмүүст нөлөөлөх зүйл хэмээн үзүүл.

Хялбар болго

Таны төвөгтэй асуудлын цаадах гол санаа нь чухам юу вэ? Үүнийгээ нэг юмуу хоёр өгүүлбэрт багтаан дүгнэхийг хичээ. Хэвлэл мэдээлэлтэй харьцахдаа энэ санаагаа оруулсан эсэхээ үргэлж нягтал. Түүнчлэн цаашдаа хэрэглээд дасчихаж магадгүй тул этгээд үг хэллэг, гоёмсог товчлолоос зайлсхийх хэрэгтэй. Асуудлынхаа талаар огт өөр салбарт ажилладаг өөрийн найздаа ярьж байгаа мэт ярихыг хичээгээрэй.

Зөв хүмүүстэй холбогд

Таны үйл явдлыг гаргах нийтлэлийн талаар олж мэд. Мэдээний редакторуудын гол гомдлуудын нэг нь хэвийн хэмжээнд нийтэлчихэж

болохоор юм юу ч үгүй хэвлэлийн мэдээллүүд, үйл явдлуудыг хүлээн авахыг хориглох явдал болжээ. Ямар нийтлэл, нэвтрүүлгүүд аливаа асуудлыг бизнесийн, хүний ашиг сонирхлын, орон нутгийн чанартай гэх мэт өнцгүүдээс харахыг эрмэлздэг болохыг тогтоож ав.

Ойр хавьд ажилладаг сурвалжлагчдаа мэддэг бол. Нийтлэл, нэвтрүүлгийн зохиогчдын нэрийг уншиж, танайхтай адил асуудал, байгууллагын тухай бичиж буй сурвалжлагчдын нэрийг тэмдэглэж ав. Хэдийгээр тэдний албан ёсны үүрэг биш ч гэсэн сэтгүүлчид тодорхой нэг төрлийн үйл явдалд чиглэн ажиллах хандлагатай байдаг.

Хэрэв та тухайн сонины чухам ямар сэтгүүлчид танай үйл явдлыг сонирхохыг мэдэхгүй буй бол гүйцэтгэх редактор, эсвэл бүр ерөнхий редактортай нь холбоо барьж болох юм. Нэг сонинд хамтдаа ажилладаг олон сурвалжлагч руу утасдах хэрэггүй!

Мэргэжлийн бөгөөд уриалгахан бай

Сурвалжлагчид үйл явдлын эх сурвалжид хүрэхэд төдийлэн их зүтгэл гаргадаггүй тал бий. Таныг олж авахад хялбар гэдгийг тэдэнд ойлгуул: Өөртэйгээ шууд холбогдох утас, гар утасны дугаар, магадгүй бүр гэрийн утсаа ч өгсөн болно.

Сурвалжлагч утасдсан тохиолдолд хэлэх зүйлээ бэлэн эсэхээ нягтал. Тэдэнд тантай эргэж холбогдох цаг байхгүй ч байж мэднэ.

Хэрвээ асуултанд нь юу гэж хариулахаа мэдэхгүй байгаа бол түүнийгээ л хэл. Хариултыг зохиож, бас хуурч болохгүй. Хариултыг өгөхөө сурвалжлагчид амалж, яг хэзээ вэ гэдгээ хэл эсвэл тусалж болох хоёроос гурван хүний утасны дугаарыг өгөөрэй. Таныг эх сурвалжаа хэмээн бодож буй сурвалжлагч тантай байнга холбоотой байх болно.

Хүндэтгэлтэй ханд

Сэтгүүлчид бол шударга, сонирхолтой үйл явдлыг бичихийг хичээдэг томоохон мэргэжилтнүүд юм. Тэдний хөдөлмөрийн бүтээмж нь сонины мөр багануудыг бөглөх инч зайгаар, шахуу чанд хуваариар цацагдах нэвтрүүлгийн цагаар хэмжигдэж байдаг юм. Үүнийг үргэлж санаж, сэтгүүлч танай асуудлын талаар болон таны сонирхож буй асуудлын талаар үнэхээр сайн нийтэлж, нэвтрүүлсэн бол та түүн рүү утасдаж, эсвэл бичиж түүнийгээ илэрхийлэх нь зүйтэй. Гэхдээ сурвалжлагчид танд зөвлөгөө өгөх эсвэл таны эсрэг үзэл бодлуудыг үгүйсгэнэ гэж найдах хэрэггүй.

Successful Meeting Tips

Уулзалтыг амжилттай зохион байгуулах санамжууд

Юу болохыг хүмүүст мэдүүл

Урилган дээрээ хурлынхаа зорилго, бүтцийг дурьд. Хүмүүсийг ирэхэд хөтөлбөрөө тараа. Үүнийхээ дагуу баримтлахыг хичээ.

Тодорхой үүрэг даалгавруудыг хариуцуул

Цаг баримтлах, хурал хөтөлбөрийн дагуу явж буй эсэхийг нягтлах үүргийг нэг хүнд хариуцуул. Тэр хүн юмуу өөр хэн нэгэн уулзалтыг удирдах үүргийг гүйцэтгэх хэрэгтэй бөгөөд үг хэлэх хүмүүсийг ээлж дараагаар нь яриулж, хүн бүрт ярих боломж олгох ёстой.

Хүн бүрийг оролцуулахын тулд урамшуулан зоригжуулах

Хурал, уулзалтыг удирдагч нь өөрийн үзэл бодлоо илүү зоримогоор илэрхийлэх, бусдыг бодвол бэлэн байдалд буй зарим хүмүүсийг мэдэж байх хэрэгтэй. Зарим хүмүүс ярихаасаа өмнө асуух байх хэмээн хүлээж байдаг. Нэг хүн хэр хугацаагаар, хэдэн удаа ярьж болохыг тогтоосон энгийн дүрэм тогтоож мөрдөх хэрэгтэй. Хүн бүрийг оролцуулахыг зорьж, идэвхтэйгээр урамшуулж, зоригжуулаарай.

Мэдээллээ хүргэх аргаа олон янз байлга

Насанд хүрэгчид олон янзын мэдрэхүй шаардсан тохиолдолд маш сайн суралцдаг. Тиймээс тэд сонсох, ярилцах, бичих, үйлдэх зэргийг зэрэг олон үйлдэл хийж байхдаа зөвхөн унших буюу сонсохоос хавьгүй илүүгээр сурдаг аж. Тодорхой зорилтод шаардагдах олон мэдрэхүй нь тэдний хувьд илүү сайн сурах арга нь билээ.

Завсарлага ав!

Магадгүй та богино хугацаанд маш олон мэдээлэл өгөхийг оролдож болох ч хүмүүс залхаж, амрах боломж олгосон нь дээр болох нь харагддаг. Иймд дор хаяж 90 минут тутамд завсарлага байхаар төлөвлөөрэй.

Жижиг бүлгүүдэд хуваа

Хүмүүст сурсан зүйлсээ идэвхтэй ашиглахад нь тус болох жижиг бүлгээр ажиллах боломжийг олгоорой. Энэ нь сургалтын явцыг бататгаж, мөн хүн бүрт оролцох боломжийг өгдөг юм.

Санамсаргүй бөгөөд аяндаа үүсэх яриануудад цаг төлөвлө

Хүний эрхийн ажилд өөрсдийн хамтран ажиллах хүмүүсээ олж мэдэх нь энэхүү уулзалтаас гарах хамгийн үнэ цэнэт үр дүн нь байж болох юм. Тиймээс

завсарлагын үеэр кофе уунгаа санамсаргүй байдлаар хоорондоо яриа үүсгэх боломжийг хүмүүст олго.

Тэмдэглэл хөтөл

Уулзалтын үеэр тэмдэглэл хөтлөх үүргийг хэн нэгэнд хариуцуул. Энэ нь тухайн үйл явдлын амжилтыг үнэлж, дараагийн удаа хэрэгжүүлэх зүйлсээ анхаарахад тань тусална.

Уулзалтын дараа холбоотой байхыг хүмүүст сануулж, урамшуулах

Уулзалтын төгсгөлд оролцогчидын холбоо барих мэдээллийг тараана. (Мэдээж, оролцогчдын зөвшөөрлөөр). Хүмүүсийг холбоотой байх талаар урамшуулж, хэрхэн холбоотой байж болох арга замуудаас хэлж өгнө. Үүнд: бүлгийн и-мэйл хаяг бий болгох, гүйцэтгэлээ дүгнэх уулзалтуудыг товлох гэх мэт.

Үнэлгээний /Дүгнэх хуудас цуглуулах

Дараагийн уулзалтуудад хэрэгжүүлж болох сургамжтай зүйлсийг энэ уулзалтаас сурсан эсэхээ нягтлан үзэх хэрэгтэй. Иймд товчхон үнэлгээний хуудсыг оролцогчдоороо бөглүүлэх цөөхөн минутыг цагийн хуваарьтаа тусгаж, хүмүүсийг тарахаас нь өмнө хурааж аваарай. Уулзалтын юу нь амжилттай болсон, юуг нь сайжруулж болох вэ гэдгийг асуу.

Цаашид үргэлжлүүлэх

Оролцогчидтой холбоотой бай. Уулзалтын тэмдэглэлүүдийг оролцогчдодоо хэрхэн хүргэхээ бод. Магадгүй оролцогчдын хоёр нь уулзалтын дараагаас хамтран ажиллаж эхлэх ч юмуу эсвэл танай байгууллага төслөө ямар нэгэн байдлаар сайжруулан хөгжүүлэх гэх зэрэг дараагийн ахиц хөгжлүүд гарсан үед бүх оролцогчдодоо и-мэйл, сонин бичиг, утсан харилцаагаар мэдүүлэх хэрэгтэй.

Principles of Adult Learning

Насанд хүрэгчдэд зориулсан сургалтын зарчмууд

Сургалт, уулзалтын төлөвлөгөө хөтөлбөрөө боловсруулж байхдаа насан хүрэгчид хэрхэн суралцдаг тухай зарчмуудыг санаж байх нь зүйтэй.

1. Насанд хүрэгчид нь олон янзын мэдрэхүй шаардсан тохиолдолд маш сайн суралцдаг. Тиймээс тэд сонсох, ярилцах, бичих, үйлдэх зэрэг олон үйлдэл хийж байхдаа зөвхөн унших буюу сонсохоос хавьгүй илүүгээр сурдаг. Тодорхой зорилтод шаардагдах олон мэдрэхүй нь тэдний хувьд илүү сайн сурах арга нь юм.

2. Насанд хүрэгчид нь тэдний нэн шаардлагатай хэрэгцээнд тохирсон зүйлсийг хамгийн сайн сурдаг.
3. Насанд хүрэгчид тэдний мэддэг зүйлд хамаатай шинэ зүйлийг хамгийн сайн сурдаг.
4. Насанд хүрэгчид өөрсдийн туулсан туршлагаасаа хамгийн сайн суралцдаг.
5. Насанд хүрэгчид дэмжлэгтэй, шүүмжлэлгүй орчинд хамгийн сайн сурдаг.

SHARING YOUR TACTIC:

A SAMPLE TACTIC PRESENTATION

ТАКТИКАА ХУВААЛЦАХ НЬ:

ТАКТИКИЙН ЗАГВАР ТАНИЛЦУУЛГА

Шинэ Тактик төсөл нь шинэ тактикуудаас суралцах, сургахын аль алиныг нь хэрэгжүүлдэг. Та бүхнийг зөвхөн тактикуудтай холбогдох өөрийн ажлыг бодож, уг номонд дурдагдсан бусад тактикуудаас суралцаад зогсохгүй өөрсдийн тактикийг бусадтай хуваалцаасай хэмээн бид хүсэж байна. Тактикийн санаачлагуудаа хуваалцах нь уг тактикуудыг санаачилсан хүмүүс (удирдагчийн болон танилцуулах чадварыг нь хөгжүүлэх замаар) болон тэдний сургах хүмүүсийн аль алинд нь ашиг тусаа өгнө.

40 минутын танилцуулгад багтсан үндсэн зураглалын дагуу тактикаа танилцуулах хэрэгтэй. Сонсогчиддоо өөрийн тактикийг хамгийн сайн ойлгуулж, хэрэгжүүлэхэд тусалж чадах мэдээллүүдийг сонгоход туслах зорилгоор энэ үндсэн зураглалыг ашиглаарай.

Өөрийн тактикаа тодорхойл.

1 минут

Сургалтаа өөрийн тактикийн товч тодорхойлолтоор эхэл. Нөхцөл байдал, асуудлыг бус зөвхөн тактикаа эхлээд анхаарах ёстойг санаарай. (Үүнийг тайлбарлах цаг олдох тул). Өмнө дурдагдсан тактикийн тухай тодорхойлолтыг давтаж үзээд, энэ талаар гүйцэд ойлгосон эсэхээ баталгаажуулан “Шинэ Тактикийн Хэрэгцээ” -г уншина уу.

Мөн уг тактик яагаад өвөрмөц, чухал эсвэл амжилттай гэдгийг сонсогчдод хэлэх сонирхолтой арга замын тухай ч бодолцох хэрэгтэй. Богино түүх ярьж өг. Сонсогчдынхоо анхаарлыг татах асуулт асуу.

Нөхцөл байдлыг дүрсэл.

5 минут

Та яагаад чухам уг тактикийг энэ нөхцөлд хэрэглэгдсэнийг сонсогчдодоо ойлгуулахыг хүснэ. Үүний тулд дараах аргаар тэдэнд туслаарай:

- Ялангуяа тактикийг чинь ойлгоход бусдад туслах хариулт шаардсан нийгмийн өнөөгийн ба өнгөрсөн асуудлуудыг дүрслэн харуул.

- Энэхүү хариулт зохион байгуулагдсан үйл явцыг тодорхойл.
- Зорилго, зорилтуудыг чинь харуулах энэхүү тактикийг хэрэглэснээр хүрэх үр дүнг дүрсэл.
- Хэрэгжүүлж буй стратеги, түүнийг хэрэгжүүлэх тактикуудаа товчхон тайлбарла.

Эдгээр асуулт бүрт цагийнхаа ихэнхийг үрэх хэрэггүй ч асуулт бүрийг товчхон анхаарах нь зүйтэй.

Тактик хэрхэн ашиглагдахыг тайлбарла.

20 минут

Энэ бол таны танилцуулгын үндсэн хэсэг нь. Та сонсогчиддоо хожим тэд өөрсдийн нөхцөлдөө таны тактикийг хэрэгжүүлэхэд хэрэгтэй гол мэдээллүүдийг өгнө.

Уг тактикийг хэрхэн хэрэгжүүлж буй тухай шат шатаар нь тодорхойлон үзүүл. Онцгой, ганцхан тохиолдлыг жишээ болгон ашиглахыг танд зөвлөж байна. Тактикийг чинь ашиглахаар зорьж магадгүй өөр орны хүмүүсийн талаар төсөөлж үз. Юуг тэд мэдэх шаардлагатай вэ? Хаанаас нь тэд эхлэх вэ? Хичнээн хүн оролцох вэ? Тэдэнд ямар дэмжлэг, ямар нөөц сурвалжууд хэрэгтэй вэ?

Энэ бүхнийг үе шаттайгаар авч үзэхээ санаарай.

Тактикийн хөгжлийг давтан үзэх

7 минут

Зорилтот бүлгүүдийн тухай ярих: Тактик чухам ямар зан чанар, институци, бодлого, хувь хүмүүст нөлөөлөхөөр чиглэсэн бэ? Эхний ээлжинд болон урт хугацаанд нөлөөлөх эсвэл эцсийн эцэст хүрэх зорилтот бүлгүүд байж болохыг санаж байх хэрэгтэй.

Бодит үр дүнг тайлбарлах: Оролцож буй хүмүүс үр дүн, хүч нөлөөг хэрхэн дүрсэлж байна? Оролцсон хүмүүсийн хэлсэн үг, санаануудыг ашигла.

Юу сурсан, уг тактик өөр нөхцөлд хэрхэн ашиглагдаж болох тухай хэлэлц.

7 минут

Энэ тактикийг хэрэгжүүлэх явцаас сурсан зүйлээ тайлбарла: Юу болсон? Юуг өөрөөр хийж болох байсан? Бусдад өгөх ямар зөвлөмж байна вэ?

Өөрийн туршлагаас чинь үзвэл энэхүү тактикийг хэрэгжүүлэхийн өмнө ямар хүчин зүйлүүдийг авч үзсэн байх ёстой вэ? Үүний хязгаарлалтууд нь юу вэ?

Уг тактикийн бусад хэрэгжилтийн талаар мэдэж буй бол яагаад, хэрхэн өөр байдлаар хэрэгжсэн тухай нь хүмүүст хэлж өг.

Page 164-165

***SELF-CARE: CARING FOR YOUR
MOST VALUABLE RESOURCE***

***ӨӨРИЙГӨӨ АНХААРАХ: ӨӨРИЙН ХАМГИЙН ҮНЭ ЦЭНЭТ
НӨӨЦ БОЛОМЖИЙГ АНХААРАХ НЬ***

Хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх энэ хүнд ажлыг хийхийн тулд та осолтой нөхцөл байдалд олон цагаар ажиллаж болох юм. Үнэхээр тэсвэрлэхэд бэрх үзэгдэл, цуу яриа, үйл явдлыг та илчилж ч магадгүй. Таны хийж буй ажил танд шууд болон шууд бус аль ч байдлаар хүнд дарамт авчирна.

Хүмүүс дарамтыг олон замаар даван туулдаг. Зарим нь гэр бүл, найз нөхдийнхөө зарлагын төлөө шаргуу ажиллахыг хичээдэг эсвэл хангалттай боллоо гэж үзэн шийдвэр гаргаж ажлаа солин, сайн дурынхны эгнээнд шилждэг. Бусад нь улам их тамхи татаж, эсвэл улам уух буюу дарамтыг маш хүндээр даван туулдаг. Нөгөө хэсэг нь амьдралын эерэг талыг олж харахаа больж, бусад хүмүүс зовж байхад хүмүүс хөгжиж цэнгэх учиргүй гэж боддог болдог.

Энэ ажлыг хийхдээ өөрийн хүч чадал, зориулалт, баяр хөөрөө хадгалахын тулд та эрүүл бус дарамтыг аргалах л хэрэгтэй. (Гэхдээ дарамт бүр эрүүл бус гэсэн үг биш! Зарим дарамт үнэндээ биднийг илүү сайн ажиллахад түлхэж өгдөг шүү дээ.)

The ABCs of Self-Care

Өөрийгөө анхаарахуйн цагаан толгой

Өөрийгөө анхаарахуйн цагаан толгой буюу ABC нь Ухаалаг байдал, Тэнцвэрт байдал, Холбоо хэлхээ билээ. (Saakvitne & Pearlman, 1996).

Ухаалаг байдал

Юуны түрүүнд та эрүүл бус дарамтын шинж тэмдэг, хүндрэлийн нөлөөг тодорхойлж чаддаг байх ёстой. (шууд болоод шууд бус аль нь ч байсан). Энэ нь ухаалаг байдлыг шаарддаг.

Өөрийн бие махбодийн талаар анхаарч бай: Их ойр ойрхон өвдөж буй эсэх, ядрах цухалдах аль эсвэл илүү түргэн уурлах, боогдож хавчигдсан мэт санагдаж байна уу?

Харилцаа холбоогоо мэдэрч бай: Хайртай хүмүүстээ цаг гаргаж чадаж байна уу, өөртэй чинь цагаа өнгөрөөх боломжийг тэдэнд олгож байна уу?

Өөрөө хэрхэн өөрчлөгдөөд буйгаа анзаарч бай: Алжаалаа тайлахад чинь тус болдог эсвэл гэр бүл, найз нөхөдтэйгээ холбогдох, цагаа өнгөрөөх арга зам байсан хобби, үйл ажиллагаандаа дуртай хэвээр байна уу? Өөрийн итгэл үнэмшил болоод бусад хүмүүсийн талаарх үзэл бодол чинь өөрчлөгдөж үү? Та ертөнцийг нэг л өөрөөр хараад байгаа юм биш биз?

Тэнцвэр

Ажил төрөл, хувийн болоод гэр бүлийн амьдрал, амралт, чөлөөт цаг гэх мэт олон төрлийн үйл ажиллагааныхаа тоог тэнцвэртэй байлгахад анхаар.

Та амрах, алжаал тайлах боломжтой байх үедээ л илүү үр бүтээлтэй байх болно. Таны алжаалыг тайлахад тус болдог зүйлс танай хамт олны болон гэр бүлийнхнийхээс тань огт өөр байж болох юм. Алжаалаа тайлах арга замууд тань таны эрүүл мэнд, сайн сайхан ба өөрт чинь чухал харилцаануудад хор учруулахгүй байх нь чухал юм. Амьдралын тэнцвэр алдагдаж буйг мэдрэх явдал нь түүнийг өөрчлөх боломжийг танд олгоно.

Холбоо, хэлхээ

Хамтран ажиллагсад, найз нөхөд, гэр бүлийнхэн болон нийгэмтэйгээ холбоо хэлхээ, дэмжлэгт харилцааг байгуул.

Хэрэв та эерэг, эрүүл холбоо хэлхээ бий болгоогүй бол илүү сайн сайхан нийгэм бий болгохоор хийж буй таны бүхий л ажлын утга учир тун өчүүхэн байх болно. Дахин хэлэхэд, өөрт чинь хэрэгтэй хүмүүстэй тогтоосон холбоогоо алдаж буйгаа мэдрэх явдал нь танд энэ бүхнийг эргэцүүлэх, амьдралдаа илүү тэнцвэрт байдлыг эргүүлэн авчрах арга хэмжээ авах боломжийг олгоно.

Өөрийгөө анхаарах байдлыг хэлэлцэх нь

Хүний эрхийн ажлыг хийх явцад үүссэн дарамтыг хувиараа болон хамт олноороо даван туулах арга замуудыг хэлэлцэх цаг гаргах нь танай байгууллагын хувьд маш тустай.

Хоёр хоёроороо эсвэл жижиг бүлгүүдээр, эсвэл бүр бүхэл байгууллагаараа хэлэлцэх хэлэлцүүлгийг нээхийн тулд дараах асуултуудын алийг ч ашиглаж болно.

- Хүний эрхийн ажлын чухам юунд нь дуртайгаа хуваалцана уу. Та яагаад өөрийн үнэт цаг, энерги, нөөц хүчээ энэхүү ажилд үргэлжлүүлэн зориулж байгаа вэ?
- Таны ажилтай огт хамаагүй хийх дуртай зүйлээ хуваалцана уу. Үүнийгээ хийх цагийг та гаргадаг уу?
- Өөрийгөө болон гэр бүл, нийгэм, эх орон эсвэл өөр ямар нэгэн зүйлийн талаар үзэх үзэл бодлын хувьд таныг өөрчлөгдөхөд хүргэсэн туршлагаасаа хуваалцана уу.
- Тэсвэрлэхүйеэ бэрх, ядарсан, хяхагдаж хавчигдсан, уурлаж цухалдсан үедээ өөрийн талаар юу анзаарсаныгаа хуваалцана уу. Иймэрхүү сэтгэгдэл, нөхцлүүдийг та хэрхэн даван туулахыг чармайдаг вэ? Бусдыг татан оролцуулдаг уу? Таны хийдэг ажил уг нөхцөл байдалд тус болдог уу? Эсвэл энэ нь нөхцөл байдлыг улам дордуулдаг уу?
- Дарамт нэмэгдэхэд байгууллага ямар байдаг талаар анзаарсан зүйлээ хуваалцана уу. Байгууллага үүнийг даван туулахын тулд юу хийдэг вэ?
- Хийж буй ажлаа гэр бүлийнхнээрээ дэмжүүлсэн эсвэл дэмжүүлээгүй гэх сэтгэгдэл төрсөн үеийнхээ талаар хуваалцана уу. Тэд танд туслахын тулд эсвэл байдлыг улам хүндрүүлэх юу хийсэн бэ?
- Хийж буй ажилдаа хамт олныхоо нэгээр нь дэмжүүлсэн эсвэл дэмжүүлээгүй гэх сэтгэгдэл төрсөн үеийнхээ талаар хуваалцана уу. Тэд танд туслахын тулд эсвэл байдлыг улам хүндрүүлэх юу хийсэн бэ?
- Эрх нь зөрчигдсөн хүмүүстэй ажиллах, эрхийн зөрчлийг өөрсдөө нотлох хүнд ачааг тэсвэрлэхээр хамт олон, байгууллагаараа нэг нэгэндээ тусалж болох арга замуудыг хуваалцана уу.
- Эцэст нь, дарамтыг анагаах ABC-г судалсаны хувьд та одооноос огт өөрөөр хийх нэг зүйлээ хуваалцана уу.

Одоо та өөрийгөө анхаарахад хэрэгтэй өөрийн ухаалаг байдал, үйл ажиллагааны талаар алхам хийхэд бэлэн боллоо. Хамт олон тань өөрсөддөө туслахын тулд юу хийдэгийг та мэдэж авлаа. Эдгээр эерэг алхам, үйл ажиллагааг хэрэгжүүлэх цаг гаргаарай. Бидний хамгийн үнэт нөөц сурвалж бол бид өөрсдөө л юм! гэдгийг чухалчлан үзэж, авч хэлэлцэх ажлыг үргэлжлүүлэхийг тогтмолжуул.